

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл:

1-4

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:

5-56

1.Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ./

5-7

2.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, танилцуулгаа Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./

7-56

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны
9 дүгээр сарын 30-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Б.Бейсен ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 30 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 53.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 56 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Бат-Эрдэнэ, С.Ганбаатар, С.Лүндэг, С.Мөнхсоёл;
Чөлөөтэй: С.Амарсайхан, О.Амгаланбаатар, Д.Жаргалсайхан,
З.Мэндсайхан, А.Ундраа, Б.Уянга.

Нэг.Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Ж.Дэлгэрсайхан, Л.Гангэрэл, Монгол Улсын Шадар сайдын ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга Б.Батбямба, Монгол Улсын Шадар сайдын зөвлөх Х.Сүхбаатар, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батбаяр, мөн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Т.Золбаяр, Байгалийн нөөцийн бодлого, зохистой ашиглалтын газрын дарга Т.Балжинням, Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлогын газрын дарга Ц.Уранчимэг, Салбарын хяналтын газрын дарга Б.Мөнхтогтох, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Даваасүрэн, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын ахлах мэргэжилтэн Д.Дэчин, Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга Э.Баттулга, Усны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч З.Батбаяр, Ойн газрын Ойн нөхөн сэргээлтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Цөлжилттэй тэмцэх тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцын талуудын 17 дугаар Бага хурал (COP17)-ыг зохион байгуулах Үндэсний хорооны дэргэдэх бэлтгэл Ажлын албаны Бодлого,

төлөвлөлтийн хэлтсийн дарга Д.Ариунтуяа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн, Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга З.Тулга, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга М.Дондогдорж, Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан, Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга Я.Гантөмөр, Стандарт, хэмжил зүйн газрын дарга С.Батбаатар, Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэнгийн Гүйцэтгэх захирал Д.Эрдэнэбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, зөвлөх Бад.Баярмаа, референт Б.Бадралт, Б.Энхгэрэл, Хүнс, хөдөө аж ахуйн дэд хороо хариуцсан референт Ц.Рэнцэнтогтох, Төсвийн байнгын хорооны ажлын албаны референт С.Тэгшжаргал нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1 болон 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 05 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, танилцуулгаа Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Ж.Дэлгэрсайхан, Л.Гангэрэл, Монгол Улсын Шадар сайдын ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга Б.Батбаямба, Монгол Улсын Шадар сайдын зөвлөх Х.Сүхбаатар, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын менежер С.Нацагдорж, мөн газрын Гүйцэтгэлийн аудитын газрын аудитын менежер Ю.Энхтуяа, Гүйцэтгэлийн аудитын газрын аудитор Д.Нямжаргал, Нийцлийн аудитын газрын менежер Э.Баттогтох, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга Т.Баясгалан, Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Тогтвортой

хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн дарга П.Чандмань, Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн З.Райымбек, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Төсвийн зарлагын хэлтсийн шинжээч Ж.Алтантуяа, Төсвийн зарлагын хэлтсийн мэргэжилтэн С.Гэлэгжунай, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батбаяр, мөн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Т.Золбаяр, Байгалийн нөөцийн бодлого, зохистой ашиглалтын газрын дарга Т.Балжинням, Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлогын газрын дарга Ц.Уранчимэг, Салбарын хяналтын газрын дарга Б.Мөнхтогтох, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Даваасүрэн, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын ахлах мэргэжилтэн Д.Дэнчин, Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга Э.Баттулга, Усны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч З.Батбаяр, Ойн газрын Ойн нөхөн сэргээлтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Цөлжилттэй тэмцэх тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцын талуудын 17 дугаар Бага хурал (COP17)-ыг зохион байгуулах Үндэсний хорооны дэргэдэх бэлтгэл Ажлын албаны Бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Д.Ариунтуяа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн, Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга З.Тулга, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга М.Дондогдорж, Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга Я.Гантөмөр, Стандарт, хэмжил зүйн газрын дарга С.Батбаатар, Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэнгийн Гүйцэтгэх захирал Д.Эрдэнэбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, зөвлөх Бад.Баярмаа, референт Б.Бадралт, Б.Энхгэрэл, Хүнс, хөдөө аж ахуйн дэд хороо хариуцсан референт Ц.Рэнцэнтогтох, Төсвийн байнгын хорооны ажлын албаны референт С.Тэгшжаргал нар байлцав.

Төсвийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, М.Мандхай, Н.Наранбаатар, Л.Мөнхбаясгалан, М.Ганхүлэг, Н.Алтаншагай, Ц.Туваан, П.Батчимэг, Ц.Идэрбат, Г.Ганбаатар, Б.Бейсен нарын тавьсан асуултад Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Монгол Улсын Шадар сайдын ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга Б.Батбямба, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн бодлого, зохистой ашиглалтын газрын дарга Т.Балжинням, Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлогын газрын дарга Ц.Уранчимэг, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Усны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч З.Батбаяр, Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга Э.Баттулга, Цөлжилттэй тэмцэх тухай Нэгдсэн

Үндэстний Байгууллагын конвенцын талуудын 17 дугаар Бага хурал (COP17)-ыг зохион байгуулах Үндэсний хорооны дэргэдэх бэлтгэл Ажлын албаны Бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Д.Ариунтуяа нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хороо эрхлэх асуудлын хүрээнд төсвийн төслийн хэлэлцүүлэг хийсэн талаарх танилцуулгаа Төсвийн байнгын хороонд хүргүүлэхээр тогтов.

Уг асуудлыг 16 цаг 59 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 3 цаг 03 минут үргэлжилж, 30 гишүүнээс 20 гишүүн хүрэлцэн ирж, 66.7 хувийн ирцтэйгээр 16 цаг 59 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Б.БЕЙСЕН

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим
13 цаг 56 минут.

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Б.Бейсен: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирж, ирц 53.3 хувьтай бүрдсэн тул Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Наранцэцэгийн Алтаншагай гишүүн ирсэн байна. Буланы Бейсен гишүүн ирсэн байна. Сонгобайн Замира гишүүн ирсэн байна. Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн ирсэн байна. Ухнаагийн Отгонбаяр гишүүн ирсэн байна. Жигжидийн Чинбүрэн гишүүн ирсэн байна. Жигжидийн Батжаргал гишүүн ирсэн байна. Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн ирсэн байна. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн ирсэн байна. Тогтмолын Мөнхсайхан гишүүн ирсэн байна. Ренчинбямбаагийн Сэддорж гишүүн ирсэн байна. Пүрэвийн Батчимэг гишүүн ирсэн байна. Гонгорын Дамдинням гишүүн ирсэн байна. Мэндбаярын Мандхай гишүүн ирсэн байна. Нанзадын Наранбаатар гишүүн ирсэн байна. Цэвэгдоржийн Туваан гишүүн ирсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал танилцуулъя. Хэлэлцэх асуудал.

1.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027, 2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Хоёрдугаарт, Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төсөл ийм 2 асуудал хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу?

Саналтай гишүүн байхгүй байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027 оны, 27, 28 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2-т Байнгын хороод эрхлэх асуудлынхаа хүрээнд төсвийн хүрээний мэдэгдлийн төсөөллийг хэлэлцэж гишүүд Төсвийн тогтвортой байдлын зөвлөл болон төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж, гаргасан саналынхаа үндэслэлийг тайлбарлаж өгөх, хэлж болно. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Ажлын хэсгийн нэрс Батбаатар сайд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд орж ирээрэй. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл Ж.Дэлгэрсайхан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн ирсэн байна. Ирсэн байна. Л.Гангэрэл Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Монгол Улсын Шадар сайдын Ажлын алба Б.Батбямба Монгол Улсын Шадар сайдын ахлах зөвлөх, Ажлын албаны дарга Батбямба орж ирээгүй байна дуудаарай. Х.Сүхбаатар Монгол Улсын Шадар сайдын зөвлөх.

Эдийн засаг, хөгжлийн яамнаас И.Батхүү Төрийн нарийн бичгийн дарга, О.Мягмардорж Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Ц.Мөнхдэлгэр Эдийн засгийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга, Б.Төгөлдөр Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн дарга, Ж.Өлзийсайхан Макро эдийн засгийн бодлогын газрын шинжээч.

Сангийн яамнаас Ж.Ганбат Төрийн нарийн бичгийн дарга, Сангийн яамныхныг дуудаарай. Төрийн байгуулалтын байнгын хорооны хурал давхцаж байх шиг байна. Ирэх байх. М.Санжаадорж Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, С.Тулгаа Санхүүгийн бодлогын газрын дарга, Ж.Дэлгэржаргал Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам Ш.Батбаяр Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Т.Золбаяр Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Б.Бат-Өлзий Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Т.Балжинням Байгалийн нөөцийн бодлого, зохистой ашиглалтын газрын дарга, Г.Энхмөнх Хүрээлэн буй орчны бодлого, хэрэгжилтийн газрын дарга, Ц.Уранчимэг Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлогын газрын дарга, Б.Мөнхтогтох Салбарын хяналтын газрын дарга, Э.Баттулга Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга, З.Батбаяр Усны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Б.Ганзориг Ойн газрын Ойн нөхөн сэргээлтийн хэлтсийн дарга, Д.Даваасүрэн Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Д.Дэчин Санхүү, хөрөнгө оруулалтын газрын ахлах мэргэжилтэн, Д.Батмөнх Цөлжилттэй тэмцэх тухай Нэгдсэн Үндэстний конвенцын талуудын 17 дугаар Бага хурал, (COP17)-ыг зохион байгуулах Үндэсний хорооны дэргэдэх бэлтгэл Ажлын албаны дарга.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас Ц.Болорчулуун Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Д.Довчинсүрэн Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулалтын газрын дарга, Д.Есөн-Эрдэнэ Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулалтын газрын дарга, З.Тулгаа Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, М.Дондогдорж Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулалтын газрын дарга, Я.Эрдэнэсайхан Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга.

2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Онцгой байдлын ерөнхий газар. Я.Гантөмөр газрын дэд дарга, хурандаа ирсэн байна уу? Дуудаарай. Т.Мөнх-Эрдэнэ Санхүү, ар талын газрын санхүүгийн хэлтсийн дарга, хошууч. Онцгой байдлынхан ирээгүй байна шүү. Дуудаарай ажлын албаныхан.

Стандарт хэмжил зүйн газар. С.Батбаатар газрын дарга, Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэнгээс Д.Эрдэнэбаяр Гүйцэтгэх захирал. Хөдөө аж ахуйн Төрийн нарийн бичгийн дарга Жамбалцэрэн дарга бас ирсэн байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэх бөгөөд хуулийн төсөл 2 зүйлтэй.

Гишүүн хуулийн төслийн тухай зүйлтэй холбогдуулан Төсвийн тогтвортой байдлын зөвлөл болон төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж болно.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Нэрсээ өгөөрэй.

Байхгүй байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Нэрсээ өгөөрэй.

Байхгүй байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 онд төсвийн хүрээний мэдэгдэл, 2027, 2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ.

Санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал танилцуулна.

Хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа. Дараагийн асуудалд оръё.

14.05 цаг

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудад танилцуулъя. Ажлын хэсгийн нэрс Б.Жавхлан Сангийн сайд. Сангийн сайдаа дуудаарай. Б.Батбаатар Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл Ж.Дэлгэрсайхан Төсвийн

2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Л.Гангэрэл Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн. Монгол Улсын Шадар сайдын алба Б.Батбямба, Монгол Улсын Шадар сайдын ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга, Х.Сүхбаатар Монгол Улсын Шадар сайдын зөвлөх.

Үндэсний аудитын газар С.Нацагдорж Санхүүгийн аудитын газрын менежер, Ю.Энхтуяа Гүйцэтгэлийн аудитын газрын аудитын менежер. Энхтуяа байна уу? Дуудаарай. Д.Нямжаргал Гүйцэтгэлийн аудитын газрын аудитор. Аудитынхан ирээгүй байна уу, үгүй юү? Э.Баттогтох Нийцлийн аудитын газрын менежер, Б.Идэрбалжинням Гүйцэтгэлийн аудитын газрын аудитор. Аудитынхныгаа дуудаарай ажлын албаныхан.

Эдийн засгийн хөгжлийн яам И.Батхүү Төрийн нарийн бичгийн дарга, Т.Баясгалан Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга, Б.Мөнхтөр Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга. Ирээгүй байна уу? О.Мягмардорж Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга. Ц.Мөнхдэлгэр Эдийн засгийн бодлого, төсөөллийн хэлтсийн дарга. П.Чандмань Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын, Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн дарга, Б.Төгсдэлгэр Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн дарга, Б.Урьболд Эдийн засгийн хамтын ажиллагааны хэлтсийн дарга, Б.Баярмаа Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүүгийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, З.Райымбек Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн ирээгүй байна уу? Т.Мягмаржав Макро эдийн засгийн бодлогын газрын мэргэжилтэн.

Сангийн яам Ж.Ганбат Төрийн нарийн бичгийн дарга. Энэ Төрийн байгуулалтын байнгын хорооны хурал давхцаад байна уу? Ажлын хэсгийг нь бас дуудаарай. М.Санжаадорж Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Г.Золбоот Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, С.Тулгаа Санхүүгийн бодлогын газрын дарга, Ж.Дэлгэржаргал Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Э.Батмөнх Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга, Л.Ичинноров Төсвийн орлогын хэлтсийн дарга, П.Бат-Эрдэнэ Төсвийн зарлагын хэлтсийн дарга, Б.Батзориг Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Л.Гантогтох Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Ч.Чимэдсүрэн Татварын ерөнхий газрын дарга байна уу ирсэн үү? Дуудаарай ажлын хэсгийнхэн. Р.Мягмаржав Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга, Ж.Алтантуяа Төсвийн зарлагын хэлтсийн шинжээч, С.Гэлэгжунай Төсвийн зарлагын хэлтсийн мэргэжилтэн, Э.Цолмон Төсвийн орлогын хэлтсийн мэргэжилтэн, Т.Бат-Оргил Татварын бодлогын газрын ахлах мэргэжилтэн, Б.Энхжин Татварын бодлогын газрын мэргэжилтэн, Д.Баасандаш Татварын бодлогын газрын мэргэжилтэн.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас Батбаяр Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Т.Золбаяр Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Б.Бат-Өлзий Нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын дарга, Т.Балжинням Байгалийн нөөцийн бодлого, зохистой ашиглалтын газрын дарга, Г.Энхмөнх Хүрээлэн буй орчны бодлого хэрэгжилтийн газрын дарга байна уу? Ц.Уранчимэг Тусгай хамгаалалттай газрын нутгийн бодлогын газрын дарга, Б.Мөнхтогтох Салбарын хяналтын газрын дарга, Э.Баттулга Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга, З.Батбаяр Усны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Б.Ганзориг Ойн газрын Ойн нөхөн сэргээлтийн хэлтсийн дарга, Д.Даваасүрэн Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр

2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

орлон гүйцэтгэгч, Д.Дэнчин Санхүү, хөрөнгө оруулалтын газрын ахлах мэргэжилтэн, Д.Батмөнх Цөлжилттэй тэмцэх тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцын талуудын 17 дугаар Бага хурлыг зохион байгуулах Үндэсний хорооны дэргэдэх бэлтгэл Ажлын албаны дарга.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас Төрийн нарийн бичгийн дарга Жамбалсүрэн дарга ирсэн байна. Ц.Болорчулуун Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, З.Тулгаа Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Я.Эрдэнэсайхан Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга.

Онцгой байдлын ерөнхий газар Я.Гантөмөр газрын дэд дарга, хурандаа, Т.Мөнх-Эрдэнэ Санхүү, ар талын газрын санхүүгийн хэлтсийн дарга, хошууч байна уу? Ирж байна.

Энэ Стандарт хэмжил зүйн газар С.Батбаатар газрын дарга.

Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэнгээс Д.Эрдэнэбаяр Гүйцэтгэх захирал.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-т Байнгын хорооны хуралдаанд гишүүд тухайн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хууль санаачлагч, Монгол Улсын Ерөнхий аудитор, Төсвийн тогтвортой зөвлөлийн дарга болон төсвийн ерөнхийлөгч захирагч нараас асуулт асууж, үг хэлж болно гээд заасан байгаа. Тэгээд асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Туваан гишүүнээр тасалъя. Батжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Батжаргал: Баярлалаа. Салбарын яамдынхаа төсөвтэй холбогдуулж тодруулах зүйлүүд байгаад байна.

Нэгдүгээрт энэ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны хүрээнд энэ хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнүүдэд өгдөг урамшууллын чинь хэмжээ 26 онд төсөвлөгдөж байгаа хөрөнгө нь ер нь яаж өөрчлөгдсөн юм бэ? Энэ дээр тодорхой хариу авмаар байна.

Хоёрдугаарт бид бас хэд хэдэн том аянууд өрнүүлээд яваад байгаа улсууд. Тэр рүү дан дамаа боловсруулах чиглэлийнхээ юмыг нэмэгдүүлье гээд тодорхой төрийн бодлого, чиглүүлээд хөнгөлөлттэй зээлийн асуудал яриад яваад байгаа. Энэ зээлийн хүүгийн зөрүүд олгох хөрөнгийн хэмжээ ер нь ямархуу байдлаар өөрчлөгдсөн бэ гэдэг асуудлыг тодруулмаар байх юм.

Гурав дахь зүйл жил гаран хэдүүлээ энэ гурил тойрсон, газар тариалан тойрсон хэрүүл хийцгээсэн. 7 сарын 9-нд байх энэ чинь хаврын чуулганы төгсгөл дээр бид Гаалийн албан татвар чөлөөлсөн хуулиа хүчингүй болгосон. Баруун бүс нутаг, газар тариалан хийгээд гурилын үйлдвэрлэлийн хөгжил султай тэр хүн амын хүнсний хангамж, хэрэгцээг хангахын тулд бид тусгайлсан бодлогууд авч хэрэгжүүлэх ёстой юм байна, тухайн бүс нутгийн боомтуудаар нь жишсэн хүн амдаа ноогдох хэмжээний гурилыг нь оруулж ирэх асуудлыг шийдье гэдэг ийм яриа юмнууд явагдсан. Дагасан тогтоол, шийдвэрүүдэд би орсон гэж ингэж ойлгодог. Өнөөдөр манай зарим Их Хурлын гишүүд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн

2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

үйлдвэрийн сайдад тодорхой асуудал тавиад явж байна лээ. Би дэмжээд гарын үсэг зурсан.

Тэгэхээр юу гэж байна гэхээр зэрэг дахиад энэ чиглэлийн бүтээгдэхүүнүүд гэдэг юм уу энэ жилийн энэ гантай нөхцөлөөс хамаараад малын тэжээлийн хэрэгцээ үүсэж байна. Тэгэхээр үүн дээр ямар бодлого, зохицуулалтын арга хэмжээ авах юм бэ гэдэг асуудлыг хөндөж байна. Хөндөхдөө өнөө яаран хөндчихөж болохооргүй гаалийн тарифын бодлого дээр чинь хөндөх маягтай яваад байх юм. Тэгэхээр хэдүүлээ татварын тарифаар нь биш тарифын, татварын бус зохицуулалтуудаар нь шийдэх бололцоо, боломжууд байна уу? Та хэд маань энэ үндэсний үйлдвэрүүдтэйгээ ярьж хөөрөөд энэ баруун бүс нутгийн хангамжийг бас их учиргүй үнэ өртгийг нь өндөржүүлэхгүйгээр шийдчих тухай яриа хөөрөөнд хүрсэн юм байна гэж би ингэж ойлгоод байсан. Энэ талаараа тов тодорхой мэдээлэл өгөөч ээ. Энэ тэгэхгүй бол боломгүй л ийм л асуудал яригдаад яваад байна.

Дараагийн зүйл 25 оны нөхцөл байдал тийм ам.../минут дуусав./

Б.Бейсен: Хэдэн номер хариулах вэ? Төрийн нарийн хариулах юм уу 4 номер дээр. 4 номер микрофон.

Т.Жамбалцэрэн: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Жамбалцэрэн. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны нийт төсөв, төсвийн хязгаар 671 тэрбум байгаа. Тэгээд өргөн барьсан төсөв маань 641 тэрбум. Тэр дотор салбарын сайдын төсвийн багцын 64-70 хувь нь тэр чигээрээ татаас, урамшуулал, хүүгийн хөнгөлөлтүүд байгаа. 26 онд нийтдээ 395.3 тэрбум төгрөгийн татаас урамшуулал тусгагдсан явж байгаа.

Үүний 332.2 хувь нь, тэрбум нь татаас, 63.1 тэрбум нь урамшуулалд явж байгаа. Урамшуулал нь арьс ширний урамшуулал, ноосны урамшуулал, сүүний урамшуулал нь хүнсний ногоо, улаан буудай гээд 5 төрлийн урамшуулал. Хүүгийн хөнгөлөлт нь Атрын-4 дүгээр аяны зээлийн хүүгийн хөнгөлөлт, татаас, Хүнсний хангамжийн аюулгүй байдал, үндэсний хөдөлгөөн буюу Улсын Их Хурлын 36 дугаар тогтоолын хүрээнд олгогдож байгаа зээлийн татаас, хүүгийн хөнгөлөлт. Шинэ хоршоо, Чинээлэг малчин хөтөлбөрийн татаас, хүүгийн хөнгөлөлт, Цагаан алт хөтөлбөрийн татаас, хүүгийн хөнгөлөлт явж байгаа. 2023-2025 онд нийтдээ 379.4 тэрбум төгрөгийн хүүгийн хөнгөлөлтийг олгосон. Нийтдээ 2.8 их наяд төгрөгийн зээлийг гаргасан байгаа.

Нийт дүнгээр нь задлаад аваад үзэх юм бол 26 онд зээлийн хүүгийн татаас 332.2 тэрбумыг олгоно гэсэн. 26 ондоо нийт олгогдох зээлийн хэмжээ 1.7 их наяд төгрөгийн зээлийг гаргана гэж ингэж тооцож байгаа. 36 дугаар тогтоолтой холбоотой зээлийн хүүгийн хөнгөлөлт өнгөрсөн 23 оноос 26 онд нийтдээ гээд ингээд аваад үзэхээр 290.8 тэрбум төгрөгийн татаас, хүүгийн хөнгөлөлт олгохоор байгаа. Энэ оны дүнгээр гээд нийт хөтөлбөр эрхэлсэн хугацаанаас авхуулаад 1.2 их наяд төгрөгийн зээлийг 3100 гаруй зээлдэгчдэд олгосон байгаад байгаа. Ирэх оны төсөв дээр бид 650 орчим тэрбум төгрөгийн зээлийг энэ 36 дугаар тогтоолын хүрээнд гаргах ийм төлөвлөгөөтэй байгаа. Энэний үр дүнд өнөөдрийн байдлаар 50 гаруй үйлдвэр ашиглалтад орсон. Томоохон үйлдвэрүүдийг нь авч үзвэл 50 гаруй

2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

үйлдвэр. Энэ дотор сүүний 9 үйлдвэр, гурилын 12 үйлдвэр гэдэг юм уу, мах төхөөрөх, боловсруулах 18 үйлдвэр гээд иймэрхүү үр дүнтэй байгаа.

Атрын-4 зээлийн хүрээнд үндсэндээ нийт олгох зээлийн хэмжээ 800 тэрбум байгаа. Тэгээд энэ оны гүйцэтгэлээр 350 орчмыг гаргасан. Нийтдээ 815 зээлдэгч иргэн, аж ахуйн нэгж хамрагдсан. 2026 ондоо 400 тэрбумыг гаргах ийм төлөвлөгөөтэй. Цагаан алт хөтөлбөрийн хүрээнд 690 тэрбум төгрөгийн яг зээлийг гаргасан. Зээлдэгчдэд 160 гаруй зээлдэгчид зээлийг олгосон. 26 онд 500 тэрбум төгрөгийн зээлийг олгохоор байгаа. Зээлийн үр дүнгүүд эхнээсээ харьцангуй сайн гараад явж байгаа. Шинэ хоршоо, Чинээлэг малчин хөтөлбөрийн хүрээнд ирэх онд 500 тэрбумын зээлийг гаргана гэж ингэж төсөв дээр тусгагдсан явж байгаа. Өнгөрсөн хугацаанд нийтдээ 844.5 тэрбум төгрөгийн зээлийг.../минут дуусав./

Б.Бейсен: 4 номер гүйцээж хариулъя.

Т.Жамбалцэрэн: 25 мянган хоршоодод зээл олгосон ийм дүнтэй байгаа. Баруун бүсийн гурил, газар тариалангийн салбарыг сэргээн хөгжүүлэхтэй холбоотой салбарын яаман дээр тодорхой төлөвлөгөө гаргаад ажиллаж байна. Салбарын яамнаас Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдаас өгсөн чиглэлийн дагуу ажлын хэсэг гараад баруун бүсийн аймгуудад ажилласан. Энэ жилийн тухайд бас харьцангуй байгаль, цаг уурын эрсдэлээс хамаараад баруун бүсийн ургацын төлөв байдал бас төдийлөн сайнгүй гарсан.

Цаашдаа бид нар энэ байгаль цаг уурын, уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах чадвартай, тэсвэртэй ийм газар тариалан, хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлж цаашдаа авч явахгүй бол энэ байгаль цаг уур, энэ хурмастаас хамааралтай нөхцөл байдал манай салбарт нэлээд тийм эмзэг байдлыг бий болгож байна гэж ингэж үзэж байгаа. Ялангуяа Завхан аймаг, Увс аймаг гол тариалан хийж байгаа Завхан аймаг, Увс аймгуудын тариалан эрхлэгч аж ахуйн иргэн, аж ахуйн нэгжүүдтэй холбогдох уулзалтыг зохион байгуул.../минут дуусав./

Б.Бейсен: 4 номер гүйцээж хариулъя.

Т.Жамбалцэрэн: Төлөвлөгөөг гаргаад ажиллаж байгаа. Тэгээд дотоодын гурил үйлдвэрлэгч 5, 6-н аж ахуйн нэгжтэй холбогдох уулзалтыг, хэд хэдэн удаагийн уулзалтыг хийсэн. Улаан буудайн гурилын хэрэгцээг хангах, тогтвортой байдалд анхаарч Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг хүчингүй болгосонтой холбоотойгоор баруун бүсийн иргэдэд гурил өндөр байхааргүй зохицуулалтыг хийхэд хамтран ажиллах чиглэлээр санал солилцоод ингэж ажиллаж байгаа. Энэ ажлын хүрээнд үйлдвэрийн үнээр тодорхой борлуулалтын цэгүүдийг тухайн бүс нутгуудад байгуулаад ажиллаж байгаа. Тухайн үйлдвэрүүд нь тухайн сард, улиралд явуулах тоо хэмжээг хүн амын жишсэн хэрэгцээнд нь тулгуурлаад орон нутагт нь үйлдвэрийнхээ үнээр хүргэх чиглэлээр ажилласан. Бидний хувьд дутагдалтай байгаа улаан буудайн нөөцөө бүрдүүлэх дотоодын гурил үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдийг улаан буудайгаар таслахгүй байх энэ чиглэлийн.../минут дуусав./

Б.Бейсен: Батжаргал гишүүн тодруулъя.

Ж.Батжаргал: Энэ жилийн ургац хураалтын байдал ер нь байж байгаа нөхцөл байдлуудаа харахаар зэрэг бид хэдэд ирэх жил хүнсний улаан буудай дээр

2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

хэдий хэмжээний дутагдал үүсэхээр, тариалах үр дээр хэдий хэмжээний дутагдал үүсэхээр ийм тооцоолол юмнууд гарч байна вэ? Дан дамаа тариалах үрийн энэ нийлүүлэлтийн асуудлыг ер нь ямархуу байдлаар хөрөнгийн эх үүсвэрээ зохицуулна гэж бодоод байна вэ? Уг нь Хүнсний хангамж, аюулгүй байдал 36 дугаар тогтоол дотор 2 нөөц бүрдүүлэх үүрэг хүлээсэн.

Нэг нь стратегийн нөөц буюу энэ таваарын улаан буудай, нөгөөдөх нь технологийн нөөц буюу үрийн улаан буудай. Бид хэд таваарын улаан буудай дээр нь нэлээн дөхөж байгаа болов уу гэж санаад байна. Би 3, 4 жилийн тодорхой хөрөнгө тавилтаар 100 мянга руугаа хүрэх хэмжээний юмыг бий болгосон байх гэж технологийн нөөцөө хийж чадахгүй байгаад байгаа. Энэ ер нь Монголын газар тариалангийн тогтвортой байдлыг хангахад хамгийн гол нөөц энд байгаад байгаа. Үүнийг ер нь яана гэж тооцож төсөөлөөд явна вэ? Энэ дээр тодорхой мэдээлэл юмнууд өгөөч ээ гэсэн ийм зүйл байна.

Хоёрдугаарт, малын тэжээлийн хангамжийг яаж тооцож байна вэ? Нэлээн нутгууд гантай байлаа, бас будаа багавтар хурааж авч байгаатай холбогдуулаад тэжээлийн гарцын хэмжээ буурах ёстой. Энийг дагуулж хэдүүлээ энэ дутагдаад байгаа нөөцийг хаанаас, яаж оруулж ирж борлуулалтад оруулах вэ? Энэ тал дээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр ер нь ямархуу байр суурь, чиглэл барьж байна вэ гэж?

Байгаль орчны уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас ирэх оны төсөв дээр энэ байгалийн төрөл, зүйлүүд дээр хамгаалалтын чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд чинь өмнөх оныхоо түвшнээс ер нь ямархуу байгаа вэ? Дан дамаа энэ ой, хортон шавжтай тэмцэх чиглэлийн ажил дээр тавигдсан хөрөнгө мөнгөнүүд гэж ер нь ямархуу юмнууд байгаад байна вэ? Өнөө гаднын өмнө хүлээхээд байгаа өнөө том чуулга уулзалтыг чинь хөрөнгө.../минут дуусав./

Б.Бейсен: 4 номер Төрийн нарийн хариулъя.

Т.Жамбалцэрэн: Батжаргал гишүүний асуултад тодруулж хариулъя. Энэ жилийн ургацын төлөв байдал, ургацын балансаас харж байхад бид ирэх жил 100-гаад мянган тонн улаан буудай импортоор авах ийм тооцооллыг гаргаад тэгээд холбогдох судалгааг хийгээд ажиллаж байгаа. Энэ дотроо хүнсний улаан буудаа 80 орчим мянган тонн дутах ийм нөхцөл байна. 10-20 мянган тонн үрийн улаан буудай татаж авахаар тооцоолж байгаа.

Ингэхдээ улсын төсвийн хөрөнгө оруулалт, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны үр дүнд энэ 10-20 мянган тонн үрийн нөөцөө бүрдүүлнэ ээ гэж ингэж тооцож байгаа. Ер нь энэ үр, үр дээр бид нар бас шинэчлэл эхлээд богино хугацаанд хийгээд явахгүй бол энэ байгаль, цаг уурын өөрчлөлтөөс хамаараад энэ үрийн шинэчлэлүүд гадаад талдаа маш сайн шинэчлэлт хийгээд яваад байдаг манай үрийн шинэчлэлт 3-4 жил, 4-5 жил гээд энэ нэлээн тийм удаашралтай яваад байгаа. Тийм учраас.../минут дуусав./

Б.Бейсен: 4 номер гүйцээж хариулъя.

Т.Жамбалцэрэн: Тэгэхээр нийтдээ 100-гаад мянган тонн улаан буудайг импортоор авахаар ингэж тооцож байгаа. Тэгэхээр хүнсний хэрэгцээнд болон улаан буудайн үрийн нөөцөө бүрдүүлэх. 26 оны төсөв дээр 23 тэрбум төгрөгийн

2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

төсвийн санал явж байгаа. Энэ хүрээн дээрээ бид нар улаан буудайн аюулгүй нөөцөө бүрдүүлж авна гэсэн ийм тооцоо байгаа.

Б.Бейсен: Байгаль орчны яам. Батбаатар сайд хариулъя.

Б.Батбаатар: Ер нь өмнөх оныхоос нэлээн хэмжээгээр зардал нь багассан байгаа. Хортон шавж дээр, хөнөөлт хортон шавж гэж байгаа. Түүнд ирэх зардал багасаад ойн хөтөлбөр дээр тавигдаж байсан 60, өмнөх оныхоос 2025 оныхоос 17 тэрбум төгрөгөөр зардал буурсан байгаа. Тэгэхээр тэр хэмжээгээр хортон шавж устгах энэ асуудал дээр бас нэлээн багасаж байгаа юм. Тэр COP17 гээд түрүүн өөр Байнгын хороон дээр ч гэсэн хүмүүс яриад байгаа энэ COP17-г 2022 онд Монгол Улс хүлээж авна гээд НҮБ дээрээ санал хураалгаад конвенцын газар дээр ингээд шийдвэр нь гаргачихсан.../минут дуусав./

Б.Бейсен: Батбаатар сайд гүйцээж хариулъя.

Б.Батбаатар: Тэгээд шийдвэр нь гарчихсан. Одоо үндсэндээ 330 хоног үлдэж байгаа. Үүн дээр энэ 25 онд суугдсан 50 тэрбум төгрөгийг хотын Засаг даргад эрхийг нь шилжүүлээд тэр чигээр нь явуулсан Байгаль орчны сайд дээр тавигдсан. Энэ хурал болох газар, тэрний бүтээн байгуулалтын ажилд 150 тэрбум төгрөг гарч байгаа. 67 тэрбум төгрөг нь НҮБ-ын талаас стандарт тогтоосон жагсаал дээр ирсэн тэр тоног төхөөрөмжийн зардал болж ингэж гарч байгаа. Эд нар нь эргээгээд харин үр дүнтэй байх, Монгол Улсын аль төрийн байгууллагуудад яаж хэрэглэгдэх вэ гэдэг дээр анхаарах зайлшгүй шаардлага байгаа.

Б.Бейсен: Мандхай гишүүн асуулт асууя.

М.Мандхай: Эхнээс нь зарчмын юм асуугаад ерөнхийдөө сайдын төсвийн нийт зардлын бүтцэд татаасны хэмжээ жилээс жилд ер нь нэмэгдэж орж ирж байгаа. Тэгээд энэ ер нь яг ямар бодлогоор ингээд жил ирэх тусам татаасны мөнгө өсөж орж ирдэг вэ гэдгийг асуумаар байна. Энэтэй холбоотойгоор ер нь энэ хөдөө аж ахуйн татаасны ерөнхийдөө тоо өсөөд байдаг. Тэгэхэд чанарын үзүүлэлт болон бүтээмжтэй холбоотой ажлууд ерөөсөө харагддаггүй. Тэгэхээр 26 онд яг энэ илүү нөгөө чанарт суурилсан энэ татаасны бодлогыг хэрэгжүүлэх ямар ажлууд ер нь өөрчлөлтүүд хийх вэ гэдгийг асуумаар байна. Тэгээд хөдөө аж ахуйг илүү нөгөө ер нь чанараас бүтээмж шилжүүлэх Алсын хараа-2050-ийн зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн ямар бодит арга хэмжээ авч байгаа вэ гэдэг нэгд асуулт байна.

Хоёрдугаарт хөдөө аж ахуйн энэ хөрөнгө оруулалт дээр энэ 26 оны төсөв өөрөө хэмнэх төсөв байгаа. Тэгэхлээр ер нь тэвчиж болох зардлуудыг тэвчих, шинээр оруулах хөрөнгө оруулалтыг ер нь дахин харах шаардлага байгаа тээ? Гэтэл энэ цөцгийн тос үйлдвэрлэх сүүний ферм 8 жил дамнасан төсөв, төсөл яваад байдаг. Гэтэл одоо цөцгийн тос яг үндсэндээ үйлдвэрлэхийн тулд маш их хэмжээний өөрөө нөгөө түүхий эдийн баазтай байх ёстой.

Тэгэхлээр энэ ингээд 8 жил яваад 26 онд 3.6 тэрбум төгрөгийг тавьсан байна. Тэгээд энэ 8 жил явахад чинь энэ барилгын өртөг, нөгөө урсгал зардал, капиталын элэгдэл гээд маш олон асуудлууд энэ барилга дуусахгүйгээр ингээд яваад байдаг. Тэгээд энэ ингээд үргэлжлүүлээд ингээд жил ирэх тусам ингээд 8 жил дамнасан төсөв яваад байдаг нь яг ямар учиртай? Энэний цаана яг ямар асуудал байгаа юм бэ? Энэ хэзээ анх дуусна гэсэн ер нь төсөв байсан юм бэ?

2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Хоёрдугаарт цөцгийн тос үйлдвэрлэх сүүний энэ уучлаарай 201 чинь малын гаралтай түүхий эдийн цэвэрлэх байгууламж юм байна шүү. Энэ нөгөө түрүүний анхны хэлсэн нь 2018-аас оноос хойш явж ирсэн 6.7 тэрбум төсөл. Цөцгийн тос үйлдвэрлэх ферм гэж байгаа юм 3.6 тэрбум төгрөг. Энэ сүүний фермийг хувийн хэвшил нь хийж болдоггүй юм уу? Яагаад төр ерөнхийдөө энэ ферм байгуулахад оролцож байгаа юм бэ? Энэ үйлдвэрийг тэгээд барьчихаар хэн ажиллуулах вэ, энэний урсгал зардал нь төсөвт ачаалал болж орох юм уу гэдэг дээр асуумаар байна.

175 дээр энэ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын тоног төхөөрөмж 11.2 тэрбум төгрөг шинээр энэ жил тусгагдсан байгаад байгаа юм. Энэ яг юуны төсөв бэ гэдгийг асуумаар байна.

Тэгээд Байгаль орчны сайдаас асууя энэ анхаарал татаж байгаа том төсөл бол энэ 217 тэрбум төгрөгийн НҮБ-ын барилга. Энэ яг нэн яаралтай шаардлагатай барилга юм уу? Энэ 2027 онд жишээлбэл ямар өгөөж авчрахаар энэ том.../минут дуусав./

Б.Бейсен: Энэ 2026 оны төсөв хэлэлцэж байгаа учраас ажлын хэсгийнх нь энэ гишүүдийн асуусан асуултад дотроо хариулаарай. Хөдөө аж ахуйн яамнаас Төрийн нарийн бичгийн дарга Жамбалцэрэн 4 номерын микрофон.

Т.Жамбалцэрэн: Мандхай гишүүний асуултад хариулъя. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны татаасны зардал, урамшууллын зардал өнгөрсөн оноос буурч орж ирж байгаа. Сүүлийн жилүүдэд гэдэг агуулга дээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан хүнсний хангамж, аюулгүй байдал үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэхтэй холбоотой, мөн малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний үнэ цэнийг өсөн нэмэгдүүлэх зорилготой Цагаан алт хөтөлбөр, газар тариалангийн салбарыг сэргээн хөгжүүлэх зорилготой Атрын-4 дүгээр аян, малчдын энэ уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах тэсвэртэй мал аж ахуйн салбарыг авч явах малчдын амьжиргаа малчдын нэгдэж нийлэх энэ хорших хөдөлгөөнийг дэмжихтэй холбоотой Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд Улсын Их Хурлаас баталчихсан Улсын Их Хурлын тогтоолуудтай ийм 4 хөтөлбөр байгаа.

Тэгээд эдгээр хөтөлбөрүүд маань өөрсдөө хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилго, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөтэй, суурь түвшин, зорилтот түвшнүүдтэй. Зөвхөн энэ хүүгийн хөнгөлөлт, татаас бол цэвэр хувийн хэвшил дээр очиж байгаа арилжааны банкны эх үүсвэртэй, хүүгийн хөнгөлөлтийг нь улс хариуцаад ингээд олгож байгаа хэлбэр. Нэг ёсондоо байгаа төсвийнхөө эх үүсвэрийг л бид нар арилжааны банкны эх үүсвэрээр нэмэгдүүлж хүүгийн хөнгөлөлтийг нь улс, засаг хариуцах ийм зохицуулалттай явж байгаа. Яг зүгээр биет агуулгаараа гэдэг юм уу улсын төсвөөс өөрөө ингээд хөнгөлөлттэй зээл олгоод явах боломж нь тааруу учраас энэ хамгийн боломжит хэлбэр нь юм болов уу л гэж ингэж ойлгож байгаа.

Нөгөө талдаа ЖДҮ-лэлийг дэмжих чиглэлээр 2018 оноос ЖДҮ-лэлийг хөгжүүлэх сан дээр улсын төсвөөс 1 ч төгрөг ч нэмэгдээгүй. Зөвхөн эргэн төлөлтөөсөө, санхүүжээд эргэн төлөлтөөрөө ЖДҮ-лэлүүд дээр санхүүгийн дэмжлэг олгоод явж байгаа ийм хэлбэр байгаа. Түрүүн асуултад хэлж байсан сайдын багцын төсвийн 64-70 хувь нь ерөөсөө татаас урамшуулал, хүүгийн

2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

хөнгөлөлт байгаа. Салбарт шинээр нэмэгдэж байгаа хөрөнгө оруулалтууд, тэвчиж болох урсгал зардлуудыг бүгдийг нь тэвчиж шинэ хөрөнгө оруулалтуудыг тусгалгүй оруулж ирсэн байгаа гэдгийг хэлье. Салбарт үндсэндээ орон нутгийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн санал, Улсын Их Хурлын гишүүдээс ирүүлсэн санал дээр тулгуурлаад улсын хэмжээнд нийтдээ хөдөө аж ахуйн салбарын тоног төхөөрөмжийн зардал дээр 11.2 тэрбум төгрөг байгаа. Энэ дотор Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн тоног төхөөрөмж 650 сая, 10 мянган тонны багтаамж бүхий үр тарианы цэвэрлэх, хатаах, хадгалах иж бүрэн механикжсан цогцолбор байгуулах ажил энэ баруун болон зүүн бүсэд

Б.Бейсен: 4 номер гүйцээж хариулъя.

Т.Жамбалцэрэн: Түрүүн асуултад бас гарч байсан энэ баруун бүсийн газар тариаланг энэ алслагдсан бүс нутгийн газар тариалангийн салбарыг сэргээн хөгжүүлэхтэй холбоотой зүүн бүсэд, баруун бүсэд ингээд энэ хоёр 10 мянган тонны үр тарианы энэ агуулах барьж байгуулах ажил хийгдэж байгаа. Өнгөрсөн онуудад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар суурь дэд бүтцийн ажлууд нь хийгдчихсэн. Эхний ээлжид бид Увс аймгийн Баруунтуруун дахь бүтээн байгуулалтын ажил энэ сав, элеватор байгуулах ажлыг хийгээд явах юм.

Шилжих хөрөнгө оруулалтын барилга байгууламж гэдэг дээр нийтдээ 26 аравны, 24.6 тэрбум төгрөг байгаа. Шинээр 7.2 тэрбум төгрөг тусгагдсан. Энэ нь юу вэ гэхээр бэлчээрийн усан хангамжийг сайжруулах чиглэлд 1.6 тэрбум төгрөг. Шинэ Ховд үйлдвэр, технологийн паркийн цахилгаан хангамж, гол шугам сүлжээний ажлыг хийхтэй холбоотой 1.9 тэрбум төгрөг, цэвэрлэх байгууламжийн 3 аравны.../минут дуусав./

Б.Бейсен: Мандхай гишүүн. Байгаль орчны Батбаатар сайд. Айн Батбаатар сайдын микрофон өгье.

Б.Батбаатар: 217 тэрбум төгрөг COP17 буюу цөлжилтийн эсрэг тэмцэх олон улсын талуудын 17 дугаар бага хурал Улаанбаатар хотод зохион байгуулагдахтай холбоотой тавигдсан. Үүний 150 тэрбум төгрөг нь дэд бүтэц, хурал зохион байгуулагдах түр байгууламж орж байгаа. Энэ оны төсөв дээрээс 150 тэрбумыг нь тийш нь шилжүүлчихсэн Хотын захиргаа руу, хотын дарга руу. 67 тэрбум төгрөг нь тоног төхөөрөмж байгаа. Аюулгүйн гарц, компьютер, бусад энэ үндэсний аюулгүй байдал. НҮБ-ын гишүүн орнуудын зохион байгуулалтаар оруулдаг төрийн тусгай хамгаалалт өндөр дээд хэмжээний зочид, айлчдыг авдаг энэ жагсаалтын тоног төхөөрөмжүүд байж байгаа. Эд нар нь өөрсдөө саналаа өгөөд дээрээс нь НҮБ-ын.../минут дуусав./

Б.Бейсен: Батбаатар сайд гүйцээж яриулъя.

Б.Батбаатар: Дээр нь энэ хэрэглэгдэх тоног төхөөрөмж НҮБ-ын жагсаалтаар ирдэг. Бид нар нөгөө тусад нь тоног төхөөрөмжийнхөө жагсаалтыг гаргадаггүй гэсэн үг. Тэгээд тэрийг нь энэ дараа нь хариуцаж авч явах ёстой байгууллагууд дээрээ бараг худалдан авалт нь зарлагдах байх. COP17-г зохион байгуулж байгаа Үндэсний хорооны дарга нь Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд байгаа. Бусад улс оронд ч COP-ууд зохион байгуулахад Байгаль орчны сайдууд байдаг. Тэр утгаараа төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд над дээр тавигдаад байгаа юм. Байгаль орчны сайдын төсөв дотор.

Түрүүн тэр хортон шавж асуусан 49 тэрбумаас 15.6 тэрбум төгрөг нь хортон шавж устгахад зориулагдана.

Б.Бейсен: Мандхай гишүүн тодруулъя.

М.Мандхай: Яах вэ ер нь нийт бараг 60, 70 хувь нь хөдөө аж ахуйн угаасаа татаас байгаа. Хөтөлбөр хэрэгжих дээр ерөөсөө эсэргүүцсэн юм алга. Хөтөлбөрөөр дамжуулж бас тодорхой салбарыг хөгжүүлэхэд хөтөлбөр зайлшгүй ач холбогдолтой. Гэхдээ 25 онд нийт хөдөө аж ахуйн татаас бол 419.6 тэрбум төгрөг байсан. 26 онд 400.4 үндсэндээ 5 орчим хувиар л төсөв буурсан харагдаад байгаа байхгүй юу. Тэгэхлээр ерөнхий татаасны хэлбэр их дорвитой жишээлбэл хэмнэлт ч гэдэг юм уу, хийсэн нөхцөл харагдахгүй байгаад байгаа юм. Хамгийн гол нь хөтөлбөр хэрэгжүүлж болно. Гэхдээ гарч байгаа яг энэ хөтөлбөрүүдийн чинь тийм индикаторууд чинь аягүй тодорхойгүй байгаад байгаа байхгүй юу. Энэ хүнсний дотоодын бүтээгдэхүүний гарц, бүтээгдэхүүнийх нь төрөл хэдээр нэмэгдэж байгаа юм, хэдэн хувиар нэмэгдэж байгаа юм?

Б.Бейсен: Мандхай гишүүн гүйцээж асууя.

М.Мандхай: Манай хүнс өөрөө импортын 46 хувь хараат. Үгүй ээ тэгээд энэ олон татаас, урамшуулал хэрэгжүүлээд байдаг импортын хүнсний хамаарал энэ хөдөлгөөн эхэлснээс хойш хэдэн хувиар буурч байгаа юм? Хөнгөн үйлдвэрийн Цагаан алт орон нутгийн түүхий эдийн хэдэн хувийг малчид болон хоршоодоос аваад эргэлтэд оруулж байгаа вэ гэдэг ийм бүтээмж, гарц, энэ тоо хэмжээ ийм индикаторууд дээр түшиглэж яримаар байгаа байхгүй юу. Тэрнээс биш ингээд тэдэн төгрөг гаргалаа, тэдэн аж ахуйн нэгж авлаа гэдэг тоо яг үндсэндээ хэмжих үзүүлэлт биш болчихоод байгаа юм. Одоо эндээс тэгээд ямар үр дүнг бид нар хүлээгээд байгаа юм бэ гэдэг энэ тоотой нь уялдуулж яриач ээ гэж хүсээд байгаа юм. Тэгээд энэ 8 жил явж байгаа төслийн чинь энэ хэзээ дуусах төсөл юм бэ? 6.7 тэрбум төгрөгийг үндсэндээ 18-26 онд ингээд 8 жил дамнаад дахиад л ингээд жил ирэх тусам аягүй өндөр дүнтэй төсөв байгаад байдаг дуусдаггүй энэ. Тэгээд.../минут дуусав./

Б.Бейсен: 4 номер хариулъя.

Т.Жамбалцэрэн: Мандхай гишүүний асуултад тодруулж хариулъя. Хөтөлбөрүүдтэй холбоотой, хөтөлбөрүүдийн үр дүн ингээд тодорхой Хүнсний хөтөлбөр, Цагаан алт гээд энэ хөтөлбөрүүд нөгөө хэрэгжүүлэх үйл ажиллагаа өөрөө тодорхой, тэгээд суурь түвшин, зорилт, үр дүн нь тодорхой. Тэгэхээр тэр дээр бид нар үр дүнгийн үзүүлэлтийг нь хяналт шинжилгээ, үнэлгээ мониторинг хийгээд эргээд Их Хурал дээр танилцуулах ийм үүрэгтэй. Тэр хүрээндээ бас дэлгэрэнгүй танилцуулна. Зөвхөн одоо бүтээгдэхүүн дээр гээд ингээд аваад үзэх юм бол энэ хүнсний хөтөлбөрийг хэрэгжүүлж байхад бид нар 2 өндөг тутмынхаа 1-ийг нь импортоор авдаг байсан. Өнөөдөр гээд тэгэхэд бид нар 3 өндөгнийхөө 2-ыг дотоодоос хангах ийм боломж, бололцоо бүрдсэн. Үндсэндээ дотоодын үйлдвэрлэл 25 хувиар өндөг үйлдвэрлэлийн салбар дээр өссөн гэдэг юм уу. Ингээд бүтээгдэхүүн болгоноор үр дүнгүүдийн үзүүлэлт гарч болж байгаа.

2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Энэ жилийн эдийн засгийн суурь үзүүлэлтээр гээд ингээд аваад үзэхээр ДНБ-ий өсөлт 5.6 хувьтай байхад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 3.6 хувьтай өссөн ийм үзүүлэлт.../минут дуусав./

Б.Бейсен: 4 номер гүйцээж хариулъя.

Т.Жамбалцэрэн: Улсын төсөвт төсвийг юу гэдэг юм тодорхой хэмжээнд хувьчлаад аваад үзэх юм бол Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын сайдын багцын төсөв тийм өндөр биш харьцуулахад 3, 4 хувьтай байгаад байгаа. Цаашдаа ч энэ хөтөлбөрүүдийн үр дүнг харахад нэмэлт эх үүсвэр, эрэлт хэрэгцээ, хэрэгцээ шаардлага маш өндөр байгаа гэдгийг бас хэлье. Сая энэ он дамжсан, дамжиж байгаа ажлуудтай холбоотой тэр цөцгийн тосны үйлдвэрийг гишүүн бас тодруулж асууж байна. Энэ 26 онд санхүүжээд л ингээд л бүрэн дуусах хөтөлбөр байгаа юм. Үндсэндээ 22 оноос 26 оны хооронд хэрэгжсэн. 26 онд 120 сая төгрөгийн санхүүжилт аваад л ингээд бүрэн дуусаж байгаа. Ажлын хэсэг, үнэлгээний ажлын хэсгүүд нь гарчихсан улсын комисс нь ингээд ажиллаад явж байгаа ийм ажлууд байгаа.

Б.Бейсен: Мандхай гишүүн тодруулъя.

М.Мандхай: Энэ төсөв дээр чинь болохоор энэ цөцгийн тос, энэ малын гаралтай түүхий эд чинь 6.7 тэрбум гээд бид нарын өгсөн энэ, та яамнаас өгсөн материал дээр чинь байна л даа. 129 сая гэж ерөөсөө алга. Энэ маш өндөр дүнтэй ялангуяа өмнөх жилтэй харьцуулах юм бол 1.8 тэрбум төгрөгийн зөрүүтэй ийм өндөр дүнтэй орж ирж байгаа байхгүй юу. Тэгээд би тодруулж асуугаад байгаа юм. Тэгэхлээр энэ 6.7 тэрбум төгрөг өгчхөөд энэ жил дуусах юм байна гэж болж байна. Тэгээд энэнийхээ төслийн үр өгөөж, энэ задаргаа мэдээллүүдийг хармаар байна. 8 жил явсан бүтээн байгуулалтын ер нь яг юу хийгдсэн юм бэ гэдэг дээр.

Хоёрдугаарт та хэд энэ өөрийнхөө суурь түвшнээ дахиад хараад хараарай. ЖДҮ-ийн төсөв 25, 26 он дээр яг адилхан ингээд 300 гаран тэрбум төгрөг тавьчихсан мөртөө энэ ЖДҮ-ийнхээ суурь түвшнийг тавихдаа аягүй ойлгомжгүй 25 онд 299 бол аж ахуйн нэгжүүдийг дэмжиж зээлд хамрагдсан бол одоо энэ жил 2026 онд 2800.../минут дуусав./

Б.Бейсен: 4 номер Төрийн нарийн хариулъя. Дараа нь Жижиг, дунд үйлдвэр хариуцсан хүн бас хариулт өгөөрэй энэ дээр.

Т.Жамбалцэрэн: Малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүн түүхий эдийн цэвэрлэх байгууламж байгуулна гээд. Энэ Ховд аймагт энэ үйлдвэр технологийн паркийн бүтээн байгуулалтын ажил хийгдэж байгаа. Үндсэн дэд бүтцийн ажлууд бүрэн хийгдээд дуусаж байгаа. Цэвэрлэх байгууламжийн 26 онд санхүүжигдэх дүн нь 1.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөг 26 онд санхүүжигдээд энэ Ховд үйлдвэр технологийн парк бүхэлдээ ингээд дуусах юм. Тэгээд энэ дэд бүтцийг нь хийчихсэн энэ ажлууд дээр хувийн хэвшил үйлдвэр, аж ахуйн газруудаа байгуулаад ингээд явах ийм бүрэн бололцоотой байгаа. Тэгээд энэ тодорхойгүй байгаа зүйлүүд дээр, бусад тэр индикатор, тэр суурь түвшний үзүүлэлтүүдээр бас танд дэлгэрэнгүй мэдээллийг бас танд бичгээр хүргүүлъя. Эрдэнэсайхан дарга саяын агуулга дээр нэмэлт тайлбар.

Б.Бейсен: Эрдэнэсайхан дарга хариулт өгөөрэй.

Я.Эрдэнэсайхан: Мандхай гишүүний асуултад хариулъя. Сүүлийн 6, 7 жил бол ЖДҮ-ийг дэмжих санд улсын төсвөөс 1 ч төгрөг хуваарилаагүй. Тийм учраас эргэн төлөлт буюу өмнө олгосон зээлийнхээ эх үүсвэрээс жилдээ 30-40 тэрбум төгрөг төвлөрүүлээд энийгээ үйл ажиллагаандаа болон зээл хэлбэрээр олгож явж байгаа. Жилдээ бид нар хуучин 2018, 2019 онтой харьцуулахад 70, 80 тэрбум төгрөгийг, 70, 80 тэрбум төгрөгийг 200-гаад аж ахуйн нэгжид өгдөг байсныг одоо 30-40 тэрбум төгрөгийг 300 гаруй аж ахуйн нэгжид өгч байгаа. Өөрөөр хэлбэл жилдээ 300 гаруй аж ахуйн нэгжид 30-40 тэрбум төгрөгийн зээл олгож байгаа. Энэ жилийн улсын төсөв дээр жижиг, дундын агентлагаас 145 тэрбум төгрөгийн зээлийн эх үүсвэр 6.2 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны зардлыг.../минут дуусав./

Б.Бейсен: 4 номер гүйцээж хариул.

Я.Эрдэнэсайхан: Ийм санал явуулсан. Одоо эндээс орж ирж байгаа мэдээллээр ерөөсөө эргэн төлөлтийн 45 тэрбумаа л улсын төсөв дээр оруулж байгаа юм байна. Ахиад энэ жил дахиад улсын төсөв дээрээс ч төгрөгийн Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх санд зээл олгох мөнгө тусгагдаагүй. 6.2 тэрбум үйл ажиллагааны зардлыг нь 50 хувь хасчихсан. 3 аравны хэдэн тэрбум төгрөг. Тэгээд ийм төсвөөр ийм л ажлыг ирэх жил хийх, наадах чинь нөгөө 145 тэрбумаараа төлөвлөгдсөн байх гэж бодож байна. Өргөн баригдсаныг нь мэдэхгүй байна. Манайхаас 145 гээд 2000 гаруй ЖДҮ эрхлэгчдэд зээл олгоно гэдэг ийм санал явсан.

Б.Бейсен: Тэр ЖДҮ-ийн зээлийн найдваргүй зээл нь хэд байна, хуулийн байгууллагаар шалгагдаж байгаа нь хэд байна тэрийг нь тодорхой бичгээр хариулт өгөөрэй Мандхай гишүүнд.

Наранбаатар гишүүн асуулт асууя.

Н.Наранбаатар: Энэ өдрийн мэнд хүргэе та бүхэнд. Байгаль орчин, уур амьсгалын сайдаас асуулт байгаа юм. Ирэх оны төсөв нь 181 тэрбум төгрөгөөр өссөн. Тэгээд сая би тойрогтоо яваад бас говийн бүсийнхэнтэйгээ уулзаад энэ улсын төсөв танилцуулаад явсан юм. Тэгээд говийн сонгогчид маань нэг л зүйлийг хүсэн хүлээж байгаа шүү дээ усны асуудал. Энэ төсөв нь нэмэгдэхлээр би бас нөгөө усны төсөл дээрээ юм тавьчихсан юм болов уу гэж баярласан юм. 181 тэрбум. Тэгээд ингээд харахаар 180 тэрбум төгрөг нь хүрээлэн буй орчны бодлого, удирдлага гэдэг дээр л тавьчихсан байна л даа. Тэгээд цаашаа задаргаа байхгүй байгаа юм. Тэгэхээр энэ зөвхөн COP17 дээр ингээд төсөв нэмэгдсэн юм уу, аль эсвэл өөр юу зүйлүүд дээр зардал нэмэгдсэн юм уу? Тэгээд усны нөөц, нуур, гол мөрний менежмент гэдгийг харахлаар нэмэгдээгүй бүүр хасагдсан байгаа. 1.7 тэрбум төгрөг хасагдчихсан байгаа усныхаа менежментээс.

Тэгээд бид чинь сая 5 сарын 6-нд Орхон-Онгийн эхлэл Цагаан бургастай төсөл гээд л төслийн нэгж байгуулаад их л баяр баясгалантайгаар нээлтээ хийгээд л усны энэ төсөл маань хөдөллөө. Нөгөө уул уурхай маань руу маань ус очих нь, дотооддоо түүхий эдээ хүдрээр баяжуулдаг, боловсруулдаг, нэмүү өртөг бий болгох нь түүнийг дагаад мал аж ахуй газар тариалан хөгжих нь гээд л бид хэд чинь их л сүрхий нээлт хийгээд төслийн нэгжээ байгуулсан. Одоо тэгээд энэ дээрээ төсвийг нь хасчихсан л би харагдаж байна гэж л ойлгоод байгаа юм.

2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Тэгээд энэ төслийн нэгж энэ бидний эхлүүлсэн ажил маань цаашаа явах юм уу, үгүй юм уу? Говийн бүсийн зөвлөлийн хурал анхдугаар зөвлөгөөн Сайншанд хотод болсон. Хамгийн эхэнд л энэ усны төслүүд, гол нуур, хөв цөөрөм гээд л бид нар ийм л зүйлүүдийг ярьсан шүү дээ. Тэгээд говийн бүсэд бас энэ үйлдвэрлэл, үйлчилгээ, бүх л газар тариалан, мал аж ахуй, энэ ЖДҮ-гийн зээл аваад үйлдвэрлэх эрхлэхэд хамгийн тулгамдаж байгаа асуудал бас л энэ усны асуудал ингээд л бүх юмтай холбоотой энэ асуудлаа яагаад орхичихсон юм бэ? Яагаад төсөв хөрөнгө тавиагүй байгаа юм бэ? Энэ дээр ер нь яам цаашаа ямар бодлого барьж байгаа юм усны энэ төслүүдээ? Засгийн газрын хөтөлбөр бүх л хөгжлийн баримт бичигт орсон энэ том төслүүдээ 14 мега төсөл гээд тэгээд энэ том төслүүд орсон энэ томоохон төслөө яагаад хөрөнгө мөнгөгүй орхисон юм бэ? Энэ дээр хариулт авъя. Дараа нь тодруулъя.

Б.Бейсен: Батбаатар сайд хариулъя. Дараа нь Батбаяр дарга энэ усны асуудлаар бас тодорхой хариулт өгөөрэй.

Б.Батбаатар: Энэ төсөв 442 тэрбум төгрөг гээд Байгаль орчны сайд дээр том дүнгээрээ тэгж харагдаад байгаа. Энэний 229 тэрбум төгрөг нь COP17-г зориулагдсан төсөв. Тэр 180 тэрбум төгрөг гэдэг нь нөгөө урсгал болон хөрөнгө оруулалтын зардлаар 2 салаатай гэж харагдаж байгаа. 217 тэрбум төгрөг бол COP17-д зориулагдаж байгаа, 150 тэрбум нь барилга байгууламж, 67 тэрбум төгрөгт тоног төхөөрөмж. Тэр тоног төхөөрөмжийн жагсаалтыг Үндэсний аюулгүйн зөвлөл, төрийн тусгай хамгаалалт, өндөр дээд хэмжээний зочид, төлөөлөгчдийг авчрахад, дээрээс нь тэр нөгөө аюулгүй ажиллагааны эд нар гээд НҮБ-ын стандартуудын дагуу тоног төхөөрөмжийн жагсаалтаар гарч ирж байгаа үнэ байгаад байгаа юм.

Одоо бид нар COP17-г буцаах аргагүй болсон шүү дээ. Анх COP17-г Монголд уриад авч байх үедээ бодох ёстой байсан. Тэр үеэс ажилласан бол өнөөдөр ийм их мөнгө тавигдахгүйгээр шийдэж болох байсан. Одоо 330 хоног үлдсэн. НҮБ-ын конвенцын нарийн бичгийн дарга нартай гэрээ, хэлэлцээрээ байгуулчихсан. Газар нутгаа, хурал болох, зохион байгуулагдах газар, талбайг координатыг нь хийгээд сонголтыг нь хийлгүүлчихсэн. Бид өөрсдөө хурлын заалны, хурал болох газрын сонголтыг өөрсдөө хийгээгүй. НҮБ-ын Цөлжилтийн конвенцын газрын Нарийн бичгийн дарга нарын газраас ирээд Монгол Улсын Засгийн газартай гэрээ, хэлэлцээрээ хийчихсэн.

Тэгэхээр ийм нөхцөл байдал дотор орж байгаа. Тэгээд тэр усны хөрөнгө оруулалт усны зардлууд хасагдсан уу гэвэл хасагдсан. Өөрийн чинь хэлж байгаа үнэ, усны газар дээр өнгөрсөн онд энэ 25 онд 3.2 тэрбум төгрөг тавигдаж байсан бол 26 онд 2.3 тэрбум болж байгаа. 2.3 тэрбумын 2 тэрбум нь Эгийн голын УЦС-ын судалгаа, шинжилгээ гээд энэ Шинжлэх ухааны хүрээлэн рүү шилжиж байгаа Төрийн байгууллага руу. Үндсэндээ 390 сая төгрөг болж хасагдсан. 3.2 тэрбум тавигддаг байсан төсөв. Нийтдээ өнгөрсөн гэдэг чинь энэ 25 оныг хэлж байгаа шүү дээ. 47.9 тэрбум төгрөгөөр Байгаль орчны сайдын төсөв хорогдсон байгаа. 47.9 гэдэг чинь 48 тэрбум төгрөгөөр гэсэн үг. 265 тэрбум байсан төсөв 213 тэрбум болж хасагдсан. Тэр хөрөнгө оруулалтын зардал дээр 30 тэрбум байгаагийн 20 тэрбум нь 2 радарт л зориулагдаж байгаа юм. 97 онд энэ Морин толгой дээр тавигдсан Япон улсын тусламжаар тавигдсан радар аянгад цохиулаад Монгол Улс 1 ширхэг радаргүй болсон. Монголчлоод засчихсан байгаа. Тэгээд 2 радар нь 20 тэрбум

2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

төгрөгийн үнэлгээтэй нийлээд. Тэгэхээр үндсэндээ байгаль орчны салбар бол төсвийн доройтолд нэлээдгүй орсон.

Дээрээс нь энэ жил нэлээдгүй өр төлбөр тавигдаж байгаа. Салбар дундаа зохицуулалт хийж өр төлбөрийг цэгцэлье ээ гэдэг байдлаар ажлын хэсэг байгуулаад зарим төсөл, хөтөлбөр алийг нь зогсоох, алийг нь хөдөлгөх юм энэ чиглэлд нь анхаар гэдэг ажлын хэсэг байгуулаад ажиллаж байгаа. Цаг уур, орчны тэр хөдөө сумд байдаг төвүүд хүйт ороход гал түлээ бусад энэ олон олон зардлууд нь интернэт, интернэтийн зардал ч гэсэн байхгүй байгаа. Энэ чинь цаг уурын мэдээ газар болгоноос энэ 300 сумаас интернэтээр ирж байгаа интернэтийн төлбөр нь байхгүй. Ингээд салбар дунд үүсэж байгаа өр төлбөрийг цэгцлэхээр бид нар ажиллаж байгаа.

Б.Бейсен: Усны газар.

3.Батбаяр: Сая сайд хэлчихсэн учраас усны газар дээр 3 янзын, Байгаль орчны сайдын багцад 3 янзын юм байдаг. Хөрөнгө оруулалт, урсгал зардал, тэгээд сая гол мөрний менежментийн хөтөлбөр. Хөрөнгө оруулалт нь буурсан байгаа. Урсгал зардал, сав газрын захиргаа дээр 9 тэрбум байсан бол 7 тэрбум болж энэ цалин хөлс, түрээс гэсэн үг. Усны газар дээр 3.1 байсан 2.9 болж буурсан. Гол мөрний менежментийн хөтөлбөр дээр 3.2 байсан бол төсөв дээр 2 тэрбум 390 гэж бичигдсэн байгаа. Гэхдээ тэрний 2 тэрбум нь юу руу явна гэсэн үг Эгийн гол руу явна гэсэн үг. Энэ жил бас байсан 3.2-оосоо 2 тэрбумыг нь Эгийн гол руу явуулсан. Тэгэхээр үлдсэн мөнгө ердөө 390 болж байна гэсэн үг.

Тэгэхээр Эгийн гол маань ажиллаж байгаа нь сайн юм шиг боловч нөгөө талдаа бууралтууд харагдаад 3.2 байсан нь 10 дахин буурчихсан. Бид нар 12 ажил төлөвлөж байсан бол одоо ганцхан ажил хийх боломжтой болж байна л гэсэн үг.

Б.Бейсен: Тэр юунд нь тодорхой хариулаарай усны шинжилгээний 2 тэрбум тоног төхөөрөмж юм уу, яагаад тийм их хэмжээний зөвхөн усны шинжилгээнд тавьж байгаа юм ШУА-д?

3.Батбаяр: Эгийн гол дээр Орос Монголын ШУА-аас бүрдсэн багууд 2 талд зэрэг шинжилгээ судалгаа хийж байгаа. Монголын тал Монголын нутаг дэвсгэр дээрээ, Оросын тал Оросын нутаг дэвсгэр дээр. Ингээд ажлын хэсгээр хийж байгаа шинжилгээ, судалгаа нь бид шинжилгээ судалгаа гэдэг ганцхан үг хэлээд байгаа болохоос маш олон төрлийн усны, биологи, амьтнаас судалгаанаас авхуулаад мөсний үеийн бүтцийн асуудал, дээр нь мөсний үед юу Эгийн голын УЦС-ын үйл ажиллагаа явагдаад эрчим хүч үйлдвэрлэх үеэр мөс юуны үеэр, өвлийн үед их хэмжээний урсац гарна.

Тэгэхээр тэр урсцыг хэрхэн яаж тогтоон барих вэ, хил давж байгаа нөхцөлд байгалийн усны градусыг хэрхэн яаж барих вэ зэрэг маш олон судалгаа хийх учраас зөвхөн шинжилгээ судалгаа гэж хэлж болохгүй. Энэ жилийн 2 тэрбум төгрөгийн 465 тоног төхөөрөмж тэрбум 600 сая нь бүх төрлийн шинжилгээ, судалгаанд байгаа юм. Одоогийн байдлаар 30-аад хүн Монголын талаас 30-аад хүн гарчихсан Эгийн гол, Сэлэнгэ мөрөн.../минут дуусав./

Б.Бейсен: Наранбаатар гишүүн тодруулъя.

2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Н.Наранбаатар: Би уг нь говь руу хэрэгжиж байгаа том төсөл байгаа юм. Тэрийгээ л явах уу үгүй юу, мөнгө төгрөг тавьсан уу үгүй юу гэсэн ер нь юм ярьсангүй, бараг тавиагүй л юм байна гэж би ойлголоо шүү дээ. Тэгээд энэ Эдийн засаг, хөгжлийн яам тэр Бүсчилсэн хөгжлийнхнөөс асууя. Та нар чинь бүсчилж хөгжүүлнэ гээд бүс болгонд нь зөвлөгөө хийгээд сүрхий өчнөөн олон хүн зардал чирэгдэл болгоод л цуглуулаад л 1 аймгийг бүхэлд нь л 2 өдрийн л арга хэмжээ хийгээд байсан шүү дээ. Тэгээд говийн бүс дээр чинь усны асуудал хамгийн түрүүнд яригдаад эрэмбэлэгдээд явсан. Ингээд төсвөө баахан юм ярьчихаад ингээд төсөвт нь юу ч байхгүй байх юм. Тэгэхээр та нарын энэ хийгээд байгаа ажил чинь ер нь тэгээд Эдийн засгийн хөгжлийн яам, Бүсийн хөгжлийн зөвлөл гэж байх хэрэг байгаа юм уу? Тэгээд огт хэн ч тоохгүй юм байна шүү дээ. Тэгээд Сангийн яаман дээр бүх юм нь хасагдчихдаг тэгээд өөрсдөө тэгээд л чимээгүй байж байдаг. Тэгээд ийм үр дүнгүй яам, ийм үр дүнгүй үйл ажил гэж байж болох юм уу?

Б.Бейсен: 3 номер тодорхой хариулаарай. Энэ юун дээр 2 номер.

Б.Батбямба: Батбямба Шадар сайдын ахлах зөвлөх. Говийн бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаан дээр энэ асуудал ороод Засгийн газрын тогтоолд орсон. Тэрний дагуу бид нар яг энэ говийн бүс, зөвхөн говийн бүс гэлтгүй хойд бүс, Хангайн бүсийн зөвлөлийн хуралдааны хүрээнд энэ бүсүүд дээр хийгдэх хөрөнгө оруулалт төсөл, хөтөлбөртэй холбоотой асуудлуудаа эрэмбэлээд Сангийн яаманд бас Эдийн засгийн хөгжлийн яамтай хамтраад ингээд эрэмбэлээд хүргүүлсэн байгаа. Энэтэй холбоотой асуудал дээр энэ эдийн засгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн нөхцөл байдал, төсөв санхүүгийн хүндрэлтэй байдлаас холбогдуулаад энэ жил энэ шинэ төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх асуудлыг бүхэлд нь Сангийн яам хассан байгаа. Шинэ ямар ч яг нийгэм, эдийн засгийн гол ийм амин чухал салбараас бусад газрууд дээр ингээд хасчихсан явж байгаа. Тэрнээс ер нь бусад төсөл, хөтөлбөрүүдийн эрэмбэ дараагийнхаа дагуу байж байгаа. Бид нар бас зарим зураг төсөв, ТЭЗҮ боловсруулах ажлаа, зарим нэг ажлаа амжуулсан. Одоо 24, 25 оноос хойш он дамжаад явж байгаа зарим ажлуудын хөрөнгө татагдсан. Нөгөө 6 сарын 1-нээс өмнө амжаагүй.

Б.Бейсен: Мөнхбаясгалан гишүүн асуулт асууя. Энэнээс өмнө юм яриадахъя. Ер нь говь руу ус татах асуудал өнгөрсөн 4 жил бас яригдсан. Би сая Дунд Азийн орнуудаар явсан шүү дээ. Та бас явсан. Одоо яг Арал, тэнгисийг бараг ширгэтэл нь усыг нь татаад гол мөрөн аваад явчихсан. Тэгэхэд говь руу жоохон ус татахад буруудах юм байхгүй байгаа. Тэр талын асуудал дээр ер нь Байгаль орчны яамныхан, усны газрынхан бас анхаараад энэ говийн усны асуудал дээр анхаарах шаардлагатай байх шүү.

Мөнхбаясгалан гишүүн асуулт асууя.

Л.Мөнхбаясгалан: Монголын Засгийн газар 1 жил говиос сонгогдсон 7 гишүүний говийн ард түмнийг сайхан хуурч байгаа юм. Ямар ч говийн төсөл дээр усны мөнгө юу ч тавиагүй. Би энэ Балжинням дарга, Батбаяр дарга, дараа нь COP17 ажлын хэсгийн Баттулга дарга нараас асуулт асууя гэж бодож байгаа юм л даа. Сая Эдийн засгийн сайдын зөвлөх юу хэлчхэв? Ус чинь амин чухал асуудал биш юм уу? Амин чухал бус асуудлуудыг хассан гээд хэв хэлж байна шүү дээ. Та ус уудаггүй юу? Монгол Улсын 76.9 хувь нь газар нутгийн өнөөдөр цөлжчихсэн байгаа. Монгол Улс 2026 онд дэлхийд манлайллаа үзүүлнэ гээд НҮБ-ын Бага хурлыг COP17 гээд энэ хамгийн өндөр өртөгтэй хурлыг зохион байгуулна гэхчхэн

2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

байгаа. Ийм байхад Эдийн засгийн сайдын зөвлөх ийм утгагүй юм яримааргүй байна.

Усны газар дээр ингэсэн. 2.3 тэрбумыг тавьсан гол, нуурын менежментийн зардал гээд. 2.2 тэрбум нь Эгийн гол руу өгнө. Тэгээд цаана нь 300 гаруй сая төгрөгтэй үлдэнэ ээ. Газрын доройтлыг бууруулж, цөлжилтөөс сэргийлэх хөтөлбөр дээр 11.9 тэрбумыг тавьчихсан байгаа. Энэ нь тэр чигээрээ COP17 руу орно. Энэ хөтөлбөр дээр 25 онд 3 тэрбум төгрөг тавигдсан байсныг төсвийн тодотголоор 500-г нь хассан мөн үү? 2.5 тэрбум нь үлдэж байгаа юм. Энэнээс 2 тэрбумаа COP17 руу өгчхөж байгаа юм. 500 саяар Монгол Улсын 76.9 хувийн цөлжилттэй газар нутгийг хамгааллаа юу хийж чадах юм? Усны газар 300 хэдэн сая төгрөгөөр Батбаяр дарга та юу хийж чадах юм? Усны өдрөө тэмдэглэнэ гээд байгаа шүү дээ. Цай, кофены зардал өөр юм байхгүй байхгүй юу. Тэгчхээд бид нар өнөөдөр дэлхийд Монгол Улс 196 оронд манлайллаа үзүүлж цөлжилтийн эсрэг бага хурал хийж байгаа хүү хаа гээд байгаа юм. Би энэ дээр тавигдаж байгаа 229 тэрбум төгрөгтэй юу ч ярихгүй.

Яагаад гэвэл энэ Монгол Улсын нэр нүүр, үүгээрээ та нар ажлаа зохион байгуулаарай. Тэгэхдээ Баттулга дарга та энэ COP17 дээрээс манай улс мөнгө босгоно тийм үү? ТЭЗҮ-гийн мөнгө босгох гээд байгаа биз дээ говийн усны? Одоо байгаа тэр Монголд байгаа гээд байгаа тэр ТЭЗҮ чинь НҮБ-ын стандартыг хангахгүй шүү дээ. Тэрүүгээр бид нар өнөөдөр мөнгө олж чадахгүй. Зүгээр ТЭЗҮ-гийн мөнгө л олбол их юм болчихоод байна уу? Би тэгж ойлгоод байгаа. Тэрийг надад хэлээд өгөөч. Тэгээд Баттулга даргаа 300 саяар юу хийх юм? Балжинням даргаа 500 саяар юу хийх вэ? Байгаль орчны сайд төсвөө хасуулчихсан сайд л энд суучихсан бусад нь байхгүй шүү дээ. Нөгөө бодлого ярих, шууд улс төрийн шийдэл гаргах ямар нэгэн тоо баримт ярих сайдууд нь байхгүй энэ хэдэн агентлагийн дарга нарыг чичлээд яах вэ дээ. Би тэгээд тэр COP17-гоос асууя. Яг одоо олон улсын стандартад нийцсэн тийм ТЭЗҮ байна уу говийн усан дээр Хэрлэн-Тооно, Орхон?

Б.Бейсен: Хэдэн номер хариулах вэ? 4 номер хариулъя.

3.Батбаяр: Маш товчхон хариулахыг бодъё. Төсвийн төсөл дээр боловсруулж өгсөн. Тэгэхээр энэ жил 2024 оны гүйцэтгэлээр 84 тэрбум төгрөг усны төлбөрт орсон. Бид нар 25 ондоо энэ усны төлбөрийг нэмэгдүүлж 150 орчим тэрбум руу зүтгэж яваа. Энэнийхээ Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд 35 хувийг нь эргүүлээд зарцуулна гэсэн үндэслэлээр бид нар 50 тэрбум төгрөгийн менежментийн хөтөлбөртөө 50 тэрбум төгрөгийг тусгаж өгөөч ээ гэдэг ийм хүсэлтийг оруулсан байгаа. Энэ маань хасагдаад 2.39 буюу нөгөө сая яригдаад байгаа Эгийн голд 2 тэрбумыг өгөөд 390-тэй үлдсэн. 390 дээр юу хийж чадах вэ гэхээр эхний ээлжид дэлхийн усны өдрөө тэмдэглэх байх. Хэрвээ мөнгө үлдэх юм бол, мөнгө үлдэх юм бол үүрэг хүлээчихсэн байж байгаа 2 улстайгаа хилийн усны хэлэлцээрийг хийж чадвал болохоор байна. Нөгөө төлөвлөсөн байсан 12 ажил, энэ жил 12 ажил төлөвлөчихсөн байснаас жишээлбэл говийн бүсэд бид нар 2-3 сумд газрын доорх усны эрэл хайгуул хийх ажил төлөвлөсөн байсан энэ чадаагүй.

Мөн бид нар 1 лист гэж ярьдаг юм 17.8 хувьд нь дунд масштабын зураглал хийчихсэн байгаа. Энийгээ ядаж 18 хувьд хүргэе гэж төлөвлөсөн байсан. Энийгээ хийж чадаагүй. Тэгэхээр энэ ажлууд маань дахиад хойшилж байна гэсэн үг байгаа.

2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

СОР дээр цаг хэмнээд Онги, Цагаан бургастайн төслийг явуулахын тулд СОР-ын хэмжээнд НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудтай ажиллах тухай асуудлуудыг ярьж байна. Азийн хөгжлийн банктай 330 нуурынхаа хөв цөөрмийн тухай асуудлуудыг бид нар бас ярьж байна. Мэдээж төсөв гадаадаас хөрөнгө оруулалт татах тухай асуудал дээр зээлийн асуудал огт байхгүй. Зөвхөн буцалтгүй тусламжийг авч чадна. Энэ тохиолдолд Монголын төсөв дээр тусгагдсан байгаа хөрөнгө, мөнгөний хэмжээ их чухал байгаа юм. Тийм учраас бид асуултын хариулт 3.2-оор ийм ажил хийх байсан. Гэтэл одоо 390-ээр юу хийх вэ гэдэг нь ойлгомжтой гэсэн хариулт өгмөөр байна.

Б.Бейсен: 2 номер хариулт өгье.

Б.Батбямба: Би Онцгой байдал, Бүсчилсэн хөгжлийн асуудал хариуцсан Амарсайхан Шадар сайдын ахлах зөвлөх Батбямба байгаа юм. Түрүүн бас буруу ойлгочих шиг боллоо. Говийн бүсийн зөвлөлийн хурал дээр 5 мега төсөл дээр шийдвэр гарсан. 4 нь 26 оны улсын төсөв дээр ингээд дэд бүтцийн ажилд суучихсан байгаа. 5 дахь нь яг энэ усны төслийн ТЭЗҮ боловсруулах ажлыг бүхэлд нь Эдийн засгийн хөгжлийн яаман дээр ирэх жилийн төсөв дээр гээд 50, 60 тэрбум төгрөг суучихсан явж байгаа. Эндээс ингээд задаргаанд ороод явах боломжтой болов уу гэж харж байгаа. Тэрнээс гадна энэ жил Оюу толгойтой, Оюу толгой компанитай 1 тэрбум төгрөгийн яг энэ усны асуудлыг хөндсөн асуудлаар санамж бичиг байгуулчихсан одоо яг ингээд үйл ажиллагаа нь эхлэх гээд байж байгаа. Мандхай гишүүн энэ дээр бас нэлээн бас дэмжлэг үзүүлж, бодлогын дэмжлэг үзүүлж хамтарч ажилласан байгаа.

Б.Бейсен: 4 номер Балжинням дарга.

Т.Балжинням: Хариулъя гишүүний асуултад. 25 онд бол нийт 3.3 тэрбум төгрөгөөс 500 сая төгрөгийг нь татуулсан байгаа. 500 сая төгрөгийн асуудал, энэ үлдэгдэл 500 сая төгрөгийн асуудал дээр бол энэ цөлжилттэй холбоотой ...-ийг хийлгэх ажлыг төлөвлөөд ажиллаж байна. 2 тэрбум бол СОР-ын ажлын СОР17-гийн хурлын ажлын үйл ажиллагаа нь зарцуулагдаад явж байгаа. 26 оны төсөв дээр нийтдээ 74.8 тэрбум төгрөгөөс 6 ажил төлөвлөснөөс одоогийн байдлаар 2 ажил буюу 11.9 тэрбум байгаад байгаа юм. Тэгэхээр 11.9 тэрбум дээрээ бол СОР17 хурлын юун дээр 10 тэрбум нь орно. Үүнтэйгээ уялдуулаад бид нар яах вэ гэхээрээ цөлжилтийнхөө үйл ажиллагаатай холбоотой бэлчээрийн доройтолтой асуудлуудыг уялдуулаад явахаар төлөвлөж байгаа.

Дээр нь мөн төсөвт хөтөлбөрүүдийн хүрээнд бас энэ цөлжилтийн тэмцэх арга хэмжээнүүдийн хүрээнд бас.../минут дуусав./

Б.Бейсен: Ариунтуяа 4 дүгээр микрофон дээр очоорой. Ажлын албаны 4 номер. 4 номерын микрофон.

Д.Ариунтуяа: Батмөнх дарга өвчтэй байгаа учраас оронд нь Бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Ариунтуяа таны асуултад хариулъя. СОР17 Цөлжилттэй тэмцэх конвенцын талуудын 17 дугаар бага хурлаар усны асуудлыг Засгийн газраас зохион байгуулалт үндэсний хороо болон ажлын албанаас маш өндрөөр авч үзэж байгаа. Энэ хүрээндээ түрүүн Усны агентлагийн дарга Батбаяр дарга хэлсэнчлэн усны төслүүдийг ялангуяа хөрөнгө оруулалттай говийг усжуулах юм уу, эсвэл говийн экосистемийг нөхөн сэргээхэд усны нөөцийн менежментийг

2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

нэмэгдүүлэх гэдэг хүрээнд НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр, НҮБ-ын Ази, Номхон далай эдийн засаг, нийгмийн комисс, Дэлхийн байгаль хамгаалах холбоо, Даян дэлхийн байгаль хамгаалах холбоо гэдэг байгууллагуудтай хөрөнгө оруулалт татах.../минут дуусав./

Б.Бейсен: 4 номер гүйцээж хариулъя.

Д.Ариунтуяа: Хөрөнгө оруулалт татах, татахуйц хэмжээний чанартай олон улс хүлээн зөвшөөрөх төслүүдийн саналыг боловсруулаад энэ төслүүдийнхээ саналыг цааш нь 2 дугаар ээлж, эхний ээлжид төслүүдийн санал боловсруулах, 2 дугаар ээлжид төслүүдийг олон улсын байгууллагуудаар, ялангуяа НҮБ-ын байгууллагуудаар ТЭЗҮ хийлгэх ажлыг төлөвлөөд замын зургаа гаргаад ажиллаад эхэлчихсэн байгаа. Эхний ээлжид Онги-Бургастайн, Цагаан бургастайн төслийн саналыг говийг усжуулах төслийн багаас манай ажлын алба авсан байгаа. Тэр төслийнхөө саналыг олон улсын байгууллагуудтайгаа ярилцаад эхлээд уншлагаа хийгээд судалгааныхаа ажлуудыг дахин шалгаад эхэлчихсэн байгаа. Бас нэг төслийн саналыг яг одоогоор боловсруулаад явж байгаа нь говийн, Буйр нуурын экосистемийг нөхөн сэргээх замаар орчны

Б.Бейсен: 4 номер гүйцээж харилъя.

Д.Ариунтуяа: Буйр нуурыг хадгалах, хамгаалах замаар орчны экосистемийг нөхөн сэргээх гэдэг бас нэлээн том дүнтэй төслийн боловсруулалтыг олон улсын багтай бас хийгээд эхэлж байгаа. Тэгэхээр эхний ээлждээ манай Монгол Улсад олон улсын байгууллагуудад ялангуяа Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Уур амьсгалын ногоон санд тавихуйц хүлээн зөвшөөрөгдөхүйц хэмжээний ТЭЗҮ-нүүд хангалттай байхгүй байгаа учраас ажлын албанаас Үндэсний хорооны даргын өгсөн чиглэлийн дагуу ТЭЗҮ боловсруулалтыг хийх тэр төслүүдийг бид нар эрэмбэлээд тавьж байгаа.

Тэгээд 26 оны 8 сарын 17-нд талуудын бага хурал эхлэх үеэр ус ба газар гэдэг олон улсын санаачилга гаргана. Тэр санаачилга санаачилгад нэгдэж, тэр санаачилгад.../минут дуусав./

Б.Бейсен: Мөнхбаясгалан гишүүн тодруулъя.

Д.Ариунтуяа: Уучлаарай одоохон тэр санаачилга.

Б.Бейсен: Тодруулсны дараа хариулчхаарай. Мөнхбаясгалан тодруулъя.

Л.Мөнхбаясгалан: НҮБ-ын стандартад тэнцсэн ТЭЗҮ байхгүй тийм үү? Тэгэхээр сая нөгөө Амарсайхан сайдын зөвлөх өө та тэр ТЭЗҮ Монголд хийнэ гэж мөнгө төгрөг битгий ярь. Монголд зөвхөн ТЭЗҮ-гийн бизнес явагддаг байхгүй юу. Хэдхэн л компани байдаг юм. Тэрийг бид нар өнөөдөр боловсруулж авчхаад НҮБ-ын стандартад тэнцэхгүй юм бол бид нар COP17 дээрээс хөрөнгө оруулалт яаж босгох юм? Босохгүй биз дээ? Та ТЭЗҮ-гийн мөнгө босгох гэж байна шүү дээ. Энд ярьж байна тийм үү? Тэрийгээ очиж танилцуулаад дэмжлэг хүлээх гэж байна гэж ойлгоод байгаа шүү дээ. Тэгэхээр бид нар энд нэг мөр асуудлаа цэгцэлж авахгүй бол хэдэн говийн гишүүдийг салбайтал асуухаар нь өө ТЭЗҮ байгаа танай Онигийг ч татах гэж байна, Орхоныг ч татах гэж байна гээд хэдэн хөдөөгийн гишүүд гээд хуураад байдаг юм уу яадаг юм энийгээ болимоор байна. 1 жил бид нар яг

2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

хууртаж байгаа байхгүй юу. Тэгэхээр COP17-руу анхаарлаа хандуулдгаараа хандуулаад тэнд ямар бодлоготой орохоо сайн томъёолоод явахгүй бол наана нь элдэв.../минут дуусав./

Б.Бейсен: Батбаатар хариулъя. Батбаатар сайдын микрофон өгье.

Б.Батбаатар: Би нэмж тодруулъя. Яг өнөөдөр олон улсын стандарт шаардлага хангагдсан ТЭЗҮ байгаа юу гэвэл байхгүй. COP17 гэж манайхан их удаан ярьсан. Тэгэхдээ бодит байдал дээр ажил маш муу хийгдсэн маш муу хийгдсэн. Сая Хятад руу цөлжилтийн форум болон НҮБ-ын ассамблейд явсан бол нэлээдгүй хөрөнгө мөнгө босгох асуудлууд шийдэгдэх байсан. Засгийн газар, тэр Засгийн газар Их Хуралд төсөв өргөн барьж байгаатай холбоотойгоор гадаад явах томилолтыг зогсоогоод тэгээд яах вэ сая зүгээр зарим зүйлийг ярьж болж байгаа үгүйг мэдэхгүй байна.

Тэгэхдээ цөлжилтийн форумд манай яамны газрын дарга нар очоод бэлэн 4 сая, бэлэн бус буюу тоног төхөөрөмжид 14 сая долларын амлалт авчихсан. Тэгэхдээ танай сайд ирж байж энийг шийднэ ээ гэдэг байдалд. НҮБ-ын Ассамблейд бас тиймэрхүү зүйлүүд байсан. Тодорхой дэлхийн хэмжээний ТЭЗҮ-г боловсруулах тухай яригдаад эхэлчихсэн. Тэгээд энэ минут нь дуусчихлаа.

Б.Бейсен: Батбаатар гишүүн гүйцээж яриулъя сайд.

Б.Батбаатар: Тэгэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хуралдаж байгаа дээр, говийн гишүүд байгаа дээр, бусад энэ анхаарал тавьж байгаа хүмүүс байгаа дээр та бүхнийг би зарим зүйлийг дэмжиж өгөөсэй гэж хүсэж байгаа. Нэгдүгээрт COP-оос Монгол Улс ухрах аргагүй болсон. Энийгээ тодорхой болгоод энэ төсвийг нь дэмжчих ээ.

Хоёрдугаарт нь энэ Байгаль орчин, уур амьсгалын сайд COP17-г зохион байгуулах үндэсний хорооны даргын хувьд энэ чинь би больё гээд болчихсон биш угаасаа бүх COP-уудын Байгаль орчны сайд нар болдог. Энэ гадагшаа явах эрх чөлөөг нь нөгөө ийм төсөв хэлэлцэж байна гэдгээр хоригдоод байгаа. Тэгэхээр тэрийг нь жаахан дэмнээд өгвөл татвар төлөгчдийн мөнгөнөөс 10 дахин давсан хөрөнгө оруулалт, хандив олоод ирэхээр энэ төсөвт сууж байгаа мөнгө буцаад төсөвтөө орчих байхгүй юу. Өнөөдөр энийг ад үзэж хараад байх хэрэггүй.

Гуравдугаарт нь энэ COP17 дээр бид нар бүх шатдаа анхаарах хэрэгтэй. Энийг ямар улс төр юм уу, ямар зүйл болгож болохгүй. Нээлттэй, зарчимтай, ил тод байх нь туйлын чухал.

Б.Бейсен: Мөнхбаясгалан гишүүн тодруулъя.

Л.Мөнхбаясгалан: 2025 оны 5 дугаар сарын 29-ний өдөр Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөг Улсын Их Хурлаар эцэслэн баталсан. Энэ хэрэгжих ёстой. Тухайн үед Засгийн газар огцорчихсон дараагийн Засгийн газар байгуулах гээд сандал ширээгээ булаацалдаад 1 ч сайд танхимд байгаагүй. Бүүр ёртой юм шиг хэлж байсан. Тэн дээр говийг усжуулах төслийн нэгж 13.5 тэрбум төгрөг тусгагдсан байхгүй юу. Одоо 1 ч төгрөг байхгүй. Тэгэхээр өнөөдөр Монгол Улс уснаасаа мөнгөө харамлаж байгаа юм. Цөлжилтийн эсрэг НҮБ-ын бага хурлыг зохион байгуулж байгаа хэр нь цөлжилтдөө мөнгө харамлаж байгаа юм.

2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Дээрээс нь одоо энэ COP17-г зохион байгуулах ажлыг явуулъя гэсэн сайдыгаа ийш нь тийш нь явуулахгүй ингээд барьчихсан байж байж бид нар COP17 дээрээс ямар юмных нь мөнгө босгох вэ дээ. Тэгэхээр энэ дээр үнэхээр санаа зовж байна. Одоо бид нар яг мөрийтэй тоглож байгаа хүн шиг COP17 болчихвол хэдэн төгрөгтэй болох юм даа гээд сууж байгаа байхгүй юу. Би Байнгын хороонд санал оруулмаар байна. Энэ цөлжилтийн, энэ усны энэ асуудлыг Байнгын хороогоор би хэлэлцүүлэг зохион байгуулж өгөөч ээ гэдэг саналыг тавьж байгаа юм. Энийг зохион байгуулж өгөөч ээ.

Б.Бейсен: Таны саналыг бид нар Байнгын хороогоор яриад ирэх 7 хоногт товыг нь тогтоогоод хэлэлцүүлэг явуулна. Энэ COP17-той холбоотой ер нь бэлтгэл ажил муу байгаа. Батбаатар сайд та ингээд байж байх чинь хаашаа юм ер нь. Уг нь гадаад улс орнуудаар яваад төсвийн бүрдүүлэлтийн асуудал дээр анхаарахгүй бол ерөөсөө бид Азербайжан очсон шүү дээ. 90-ээд орны 68 мянган хүн ирчихсэн тийм хэмжээний юу байсан. Одоо ирэхэд бид нар шараа болгох гээд байна шүү дээ. Тийм учраас та засагтаа танилцуулаад ер нь хөрөнгө оруулалтын асуудал дээр Дундад Азийн орнуудаар түрүүн бид нар Ерөнхийлөгчтэй, Их Хурлын даргатай явахад бид нар бичгээ эрт явуулаад бид нартай хамтарчихъя гэдэг хүсэлт тавьж байсан. Энэ дээр анхаараарай.

Усны асуудал дээр ийм юм байгаа юм усыг олон жил ярьж байна бид нар. Би сая зарим улс орнуудын энэ жишээг ярилаа. Манайх чинь жилийн 12 сар тэр гол, мөрөн тийшээгээ гаргачхаад Орос, Хятад руу гарах ус байхгүй болчихож бодоод байх юм. Манайх чинь улирлын чанартай шүү дээ. Өвөл хөлдчихнө. 5, 6, 7, 8 сар юм уу 9 сар, 5 сар тодорхой хэмжээний усыг нь говь руу гаргаад л хүн мал ундаалах нуур цөрөм, нөгөө талаар хүнсний ногоо тариалах, хадлан бэлтгэл хийх ажлаа бас бэлдэх дээр анхаараад буруудсан ч гэсэн хэдий ирнэ. Бусад орон яг тийм байдаг юм байна. Тэгээд энэ дээр зоригтой шийдвэр гаргаад тодорхой хэмжээний юман дээр чинь бас анхаарахгүй бол олон улсын конвенц гэдэг гээд бас захирагдаад байхаар чинь бас зарим юман дээр бас улс орноо бодохгүй асуудал болохгүй бодохгүй асуудал байгаа байх. Энэ дээр бас та бүгд бас анхаарлаа хандуулан хэлье.

Ганхүлэг гишүүн асуулт асууя.

М.Ганхүлэг: Өдрийн мэнд хүргэе. Ерөнхий 2 асуултаас эхэлье. Монгол Улсын бас суурь чухал 2 салбарын асуудлыг бид бүхэн бас хариуцаж ажиллаж байгаа. Энд байгаа гишүүд бас энэ салбарын гол агуулгуудыг бас дэмжих сэтгэлтэй ийм гишүүд бас сууж байдаг. Тэгэхээр 2026 оны төсөв байгаль орчин болон хүнс, хөдөө аж ахуйн энэ 2 салбарын хамгийн чухал гол асуудлуудаас аль руу чиглэх вэ? Онцгой ийм бас гол бодлого төлөвлөлттэй уялдсан ийм төсвийн зохицуулалтыг бид бүхэн хийж чадаж байна уу, гал унтраах зүгээр бас өмнөх байсан төсвийн агуулгуудыг яг тэр чигт нь л оруулж ирж байгаа ийм байдал бас ажиглагдаж байна уу гэдэг ерөнхий асуултаас эхэлье.

Эдийн засаг, хөгжлийн яамныхан бас байна. Бүсчилсэн хөгжлийн гол зорилтууд гээд тодорхой хэмжээнд энэ зорилтуудыг тавиад ажиллаж байгаа. Хэд хэдэн бүс нутгууд хөдөө аж ахуйн тэргүүлэх болон дэд зорилтуудыг тавьсан. Үүнтэй холбогдолтойгоор нэр төдий яваад байгаа асуудлуудыг ер нь бид нар цаашдаа яах вэ? Жишээлбэл зүүн бүс нутаг, мал аж ахуйн таатай бүс нутаг. Тэр

2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

агуулгаараа бол хөдөө аж ахуйн бас бэлчээр, тэжээлийн таатай байдлаа ашиглаад эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх ийм зорилт байгаа. Тэгээд энийг ер нь 2026 онд анхаарсан чиглэлүүд байна уу гэдэг ерөнхий 2 асуултыг асууя.

Детальчлаад ярилцах зүйлүүд зөндөө байна. COP17-той холбогдолтой асуудлын тухай ярьж байна. Байгаль орчны салбарын төсөв 69.4 хувиар нэмэгдсэн нь энэхүү арга хэмжээтэй холбогдолтой гэж тайлбарлаж байна. Тэгэхээр салбарын сайдын хувьд яах вэ зохион байгуулагдаад явахаас өөр аргагүй ээ гэдэг тухай тайлбарыг өгч байна. Энэ бүтээн байгуулалтууд хийгдээд цаашлаад энэ 7, 8 хоног болоод юм уу хагас сар болоод ингээд арга хэмжээ бол дуусах байх. Энийг ер нь зориулалт нь ямар байдлаар ашиглах вэ? Ялангуяа хүн амын дийлэнхийг бүрдүүлж байгаа оюутан, залуучуудын сурч хөгжих, амьдрах иймэрхүү сургалтын бааз болгож ашиглах боломж байх уу гэдэг энэ саналыг танаас бас ажил эхэлж байгаа энэ цаг үед тодруулъя. Тэнд зориулсан анхны төлөвлөлт гэдэг зүйл байна уу, зөвхөн арга хэмжээнд зориулж бас энэ бүх төлөвлөлтийг хийж байна уу гэдэг ийм л санаа байгаа.

Тусгай хамгаалалттай газар нутгийн асуудлыг сая Засгийн газрын хурлаар оруулсан. Миний бие бас ажлын хэсгийг нь ахалсан. Хэд хэдэн нөхөн олговортой холбогдолтой асуудлууд бас яригдсан. Энэ асуудал ер нь энэ 2026 оны төсөв дээр байх уу? Орон нутагт байгаль хамгаалагчдын асуудал нэлээн хүндрэлтэй байгаа тухай би бас Их Хурлын чуулган дээр бас танд хэлж байсан. Түлш бензин байхгүй. Би Биндэрт Гутайн давааны захиргаа дээр очоод уулзаад Идэрбат гишүүнтэй хамт ажиллахад өөрсдөөсөө бензин гаргаад ажиллаж байна. 7 сараас хойш ямар ч зардал мөнгө байхгүй хүндрэлтэй байна гэдэг тухай ярьж байгаа юм. Тэгэхээр энэ асуудлууд дээр 2026 оны төсөв дээр ямар байдлууд тусав гэдэг асуултыг асууя. Нэмэлтээр Хөдөө аж ахуйн яамнаас тодруулъя.

Б.Бейсен: Батбаатар сайд хариулъя.

Б.Батбаатар: COP17-г зохион байгуулах түр барилга байгууламжийг дараа нь яах вэ гэдэг тухай асууж байна. Тэгээд үүн дээр хэд хэдэн байдлаар төсөөллүүд яваад байгаа юм. Яагаад вэ гэхлээр одоо нөгөө барилга байгууламж нь нэгд баригдаагүй байна. Хоёрт төсөв дээр дөнгөж суугдах тухай ярьж байна. Дараа нь яах вэ гэхлээр энийг хар ...-ыг зохион байгуул, шинээр барьж байгаа. Хуулийг нь баталсан Улсын Их Хурал үүнтэй холбоотой нэг хэсгийн тэр чинь 20 тусдаа барилга байгууламж цогцолбор болох юм. Том жижиг.

Тэгэхээр тэнд нэг хэсгийг нь. Үгүй бол энэ аймаг болгонд барилга байгууламжийг, үгүй бол энэ бас тодорхой ийм томоохон хэмжээний хөрөнгө оруулалт орчихсон зүйл дээр Монгол Улс экспо энэ чиглэлд яаж экспо гэдэг юм уу, бусад энэ НҮБ-ын болон бүс нутгийн хэмжээний хурлуудыг зохион байгуулахад бусад хэлбэрээр яаж ашиглах вэ? Эргээд таны хэлж байгаа тэр иргэд, залуучуудын сурах, боловсрох, хөгжих тэр орчин нөхцөлд нь яаж хэрэглэж болох вэ? Өвөл хэрэглэхэд хэцүү. Энэ бол хөргүүртэй болохоос биш халаалтын механизмгүй одоо яг ярьж байгаагаараа. Тэгэхээр энэ эцсийн шийдэл нь гараагүй. Тэгэхдээ энийг ил тод, нээлттэй байлгаж хааш нь яаж хуваарилах вэ гэдгийг бүгдээрээ ярьж байгаад шийдэх нь зүйтэй байх гэж ингэж ойлгож байгаа. Ямар нэг байдлаар хаачсан нь мэдэхгүй алга болдог тийм зүйл огт болохгүй.

2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухайд нөхөн олговрын асуудлууд гэж байна. Энэ төсөв ингээд тэр чигээрээ өргөн баригдчихсан байгаа. Нөхөн олговрын асуудал Уул уурхайн сайдын багц дээр тавигдах байх. Зүгээр манай дээр тийм байгаль орчны салбар нөхөн олговор өгнө гэдэг ийм асуудал байхгүй. Орон нутагт байгаа байгаль хамгаалагчид тэр аймаг, сумынх байна уу, тусгай хамгаалалттай газрынх байна уу, түлээ түлшгүй боллоо гэдэг үнэн. Яг үнэндээ тухайн сум, орон нутгийнхаа колонкуудад өр тавиад явж байгаа. Зүгээр одоо бид нарын төсөөлж байгаа нь их хэцүү байгаа нь юу гэхлээр оны сүүлд давсан орлогоор зарим энэ өр төлбөрийг барагдуулна гээд сайдын тушаалаар 20 гаран сарын орчмын өмнө тушаалаар би дугаарыг нь санахгүй байна, тушаалаар салбарын өр төлбөрийг цэгцлэх, өр төлбөргүй оныг давах тухай ажлын хэсэг байгуулагдаад манай яамны санхүүгийн газар болон бусад газрын дарга, харьяа агентлагийн дарга нар хамтдаа суугаад аль хөтөлбөр зөв юм, аль гэрээ, контракт хийгдсэн, хийгдээгүй юм, аль зүйлүүд нь явж байгаа, явж байгаагүй вэ. Энийгээ цэгцлээд нэг талд нь гаргаад энэ салбар ялангуяа анхан шатанд ажиллаж байгаа хүмүүс өр төлбөртэй бусдын өмнө өр нэхүүлсэн байж болохгүй ээ гэдэг чиглэлээр ингэж шийдвэр гараад ажиллаж байгаа. Ажлын хэсэг саналаа оруулж ирэхэд урсгал зардал дотор хуульд байгаа эрхийн хүрээнд сайд бол зохицуулалтаа хийгээд, тушаал гаргаад ингээд өөрчлөөд явна гэсэн ийм байдалтай байж байна.

26 оны төсөвт манай салбарын төсөв тэртээ тэргүй өмнөх 25 оныхоос 47.9, 48 тэрбум төгрөгөөр буусан. Цаашид төсөв байнга хүндрэлтэй нөхцөл байдалд үйл ажиллагаа явуулах юм байна. Тэгээд үүний эсрэг салбар өөрөө бодлогоороо ямар зүйлийг яаж зохицуулж болох вэ гэдэг дээр ажиллахаар эрх зүйн орчинд болон бусад нөхцөл байдлууд дээр, хуулиудын орчинд яаж өөрчлөлт хийх вэ, Засгийн газарт ямар тогтоол, шийдвэр оруулах вэ гэдэг чиглэлээр ажиллаж байна.

Б.Бейсен: 3 номер нэмж яриулъя. 3 номер.

И.Батхүү: Ганхүлэг гишүүний асуултад хариулъя. Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Батхүү. Таны хэлж байгаатай санал нэг байгаа. Хөдөө аж ахуйн салбар эдийн засгийг төрөлжүүлэх, уул уурхайн бус салбарыг хөгжүүлэх чухал ач холбогдолтой салбар. Харамсалтай нь сүүлийн 2 жилийн байдлаар хөдөө аж ахуйн салбарын өсөлт муу байгаа. Энэ оны хагас жилийн байдлаар 35 хувийн өсөлттэй гарсан. Энэ нь тэгэхдээ унасан салбар нь эргэж сэргэж байгаа учраас өндөр өсөлт харагдсан байгаа. Яг эдийн засгийн үгүй ээ өсөлтийн тогтвортой хувь нэмэр бууруулах, болох хэмжээнд өсөлт нь ажиглагдаагүй байгаа.

Цаашдаа энэ салбарыг өрсөлдөх чадварыг нь нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалт татах, экспортын эцсийн үр дүн гаргах хэмжээнд бодлогын өөрчлөлт хийх шаардлагатай байгаа. Хэрэгжүүлж байгаа татаасны бодлогуудыг цаг хугацаатай, хүрэх үр дүнтэй, хэмжигдэх үр нөлөөтэй тэгээд хэзээ дуусах вэ гэдэг маш тодорхой байдлыг хэрэгжүүлэх ёстой гэж үздэг. Бүсчилсэн хөгжлийн хувьд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт ороод Шадар сайдын харьяанд.../минут дуусав./

Б.Бейсен: 3 номер гүйцээж яриулъя.

2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

И.Батхүү: Шадар сайдын харьяанд шилжээд Бүсчилсэн хөгжлийн хүрээлэнгийн тусдаа байгуулагдсан. 24 оны улсын төсөв дээр 60 тэрбум төгрөгийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг, төсвийн хөрөнгө тавигдаад энэ бүсүүд дээр хийгдэх гол хөрөнгө оруулалтын ажлуудын бэлтгэл ажил хангагдах ажлууд ихэссэн байгаа. Тэгээд бүсчилсэн хөгжлийн энэ зөвлөлийн бүсийн хурлуудыг Шадар сайдын ажлын албанаас зохион байгуулсан байгаа.

Б.Бейсен: Ганхүлэг гишүүн тодруулъя. Тэнд нэмж хариулах гэж байна уу та? 2 номер нэмж хариулъя.

Б.Батбямба: Батбямба Шадар сайдын ахлах зөвлөх. Ер нь Зүүн бүсийн зөвлөлийн хурал маань товлогдсон байсан боловч 6 сард ингээд янз бүрийн шалтгаанаар хойшилчихсон байж байгаа. Бид нар зүгээр суугаагүй нийтдээ энэ Зүүн бүсийн хөгжлийн үйл ажиллагаатай холбоотой бүхий л субъектүүдээс, байгууллагуудаас, эрх бүхий албан тушаалтнуудаас бас мэдээлэл цуглуулж яг энэ бүсийн хэмжээнд хийгдэх шаардлагатай байгаа төсөл, хөтөлбөрийн талаар судалгаанууд авсан байгаа.

Энэ дотроо эрэмбэлээд ингээд үзэхээр нийтдээ 57 төсөл, хөтөлбөр 320 орчим тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй ингээд гараад ирчихсэн. Энэний дагуу бид нар аль нь техник, эдийн засгийн үндэслэлтэй, аль нь зураг, төсөвтэй ингээд ингээд үзээд шалгаад явж байгаа. Монгол Улсын Засгийн газраас энэ бүсийн хөгжлийг дэмжих тусгайлсан тогтоол гарах ёстой. Энэ тогтоолын төслийг боловсруулаад тухайн бүсээс сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд аймаг, орон нутгийн удирдлагуудтай ингээд зөвшилцөөд явж байгаа. Төсвийн төсөл өргөн баригдсантай холбогдуулаад бас Зүүн бүсийн хөгжлийн үйл ажиллагаатай холбоотой энэ харьцуулсан судалгаануудаа бид нар хийгээд явж байна. Одоогийн байдлаар нийтдээ 127 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй.../үг тасрав./

Б.Бейсен: 2 номер гүйцээж хариулъя.

Б.Батбямба: 4 томоохон дэд бүтцийн ажил 26 оны төсвийн төсөлд суучихсан явж байгаа. Дандаа замын ажил байж байгаа. Цаана нь бас ингээд ер нь энэ хөдөө аж ахуйн салбар, мал аж ахуйн салбар, тэгээд байгаль орчинтой холбоотой энэ төсөл, хөтөлбөрүүдийг хөгжүүлэх шаардлагатай жижиг, жижиг гэх юм уу бусад томоохон төслүүдийгээ бол харьцангуй бага төсөвт өртөгтэй ажлуудаа бас суулгах тал дээр сайдуудын багц дээр оруулах чиглэл дээр манайх зөвлөмжүүдээ өгөөд явж байгаа. Нэг авууштай тал нь улсын төсвийн хөрөнгө оруулалт дээр энэ зүүн бүсийн хөгжлийн хөтөлбөр 10 жилийн дараа, 15 жилийн дараа ямар байх вэ гэдэг чиглэлийг хийгээд дуусчихсан. Одоо Улсын Их Хурлаар хэлэлцүүлж батлуулах асуудал байгаа. Энэ хөтөлбөр батлагдчих юм бол бусад энэ төсөл, хөтөлбөрүүдээ ингээд хөтлөөд аваад явах дунд, богино хугацаандаа төлөвлөөд, илүү дэлгэрэнгүй байдлаар яваад байх боломж нь илүү нээлттэй болоход байгаа юм.

Б.Бейсен: Ганхүлэг гишүүнд тодруулъя.

М.Ганхүлэг: Тэр COP17-той холбогдолтой дараа нь ашиглалтдаа зориулж юмаа хийгээрэй л гэдэг санал хэлээд байгаа шүү. Тийм тэгэхгүй яг зөвхөн арга хэмжээнд зориулж бас юмаа битгий төлөвлөж хийгээрэй гээд.

2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Жамбалсүрэн дарга хариулах уу? Хөдөө аж ахуйн экспорт руугаа чиглэсэн ер нь асуудлуудыг энэ оны төсөв дээр хэдүүлээ яаж хийх вэ? Гол суурь асуудлууд байгаа. Вакцинжуулалтын асуудал Дэлхийн мал эмнэлгийн байгууллагын ерөнхийдөө бид бүхэн эрүүл ийм бүс нутаг болох зорилт тавиад ажиллаж байгаа. Энэ юуг яг ер нь хэзээ бид энэ зорилтдоо хүрэх вэ? Тэр хүрэх үе шатын тодорхой бас үйл явц 2026 онд хэрхэн хангагдах вэ гэдэг. Тэгээд энэ бидний хамгийн чухал бас зорилго байх ёстой. Нөгөө талаасаа бид нар хамгаалагдсан энэ аж ахуйг баталгаажуулах бүс нутгаасаа гэхээсээ илүүтэй энэ хамгаалагдсан аж ахуйгаас хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг экспортлох тухай асуудлыг бид бүхэн хөндөөд явж байгаа. Үүнийг мэдээжийн хэрэг төсвөөс гадна өөр ямар хэлбэрээр бид нар зохицуулж болох вэ гэдэг энэ асуудлуудыг нэмж асууя.

Б.Бейсен: 4 номер Жамбалцэрэн дарга хариулъя. 4 номерын микрофон, 4. номерын микрофон.

Т.Жамбалцэрэн: Ганхүлэг гишүүн гишүүний асуултад хариулъя. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар дээр түрүүн хэлсэн үндсэн 4 хөтөлбөр байгаа. Тэгээд эдгээр хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд арилжааны банкны эх үүсвэртэй зээлийн, хөнгөлөлттэй зээл л явж байгаа. Тэгэхээр ирэх жилүүдэд энэ хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэхэд хувийн хэвшлүүд маань нэлээн хүч гаргаж оролцох ийм асуудал байгаа. Салбарын яамны хувьд бол бодлогын шинэчлэлтэй, зохицуулалтын ажлуудыг их анхаарна гэж ингэж үзэж байгаа. Ялангуяа энэ байгальд цаг уурын эрсдэл, эрс тэс уур амьсгалтай манай орны нөхцөлд энэ хөдөө аж ахуйн салбар, мал аж ахуйн салбарыг энэ уур амьсгалын өөрчлөлтийг тэсвэрлэх чадвартай, даван туулах чадвартай энэ мал аж ахуйн салбар руугаа авч явж хөгжүүлэхгүй бол энэ жилийн нөхцөл байдал гээд тэгэхэд ургац дээр бас тодорхой хэмжээний эрсдэлүүд гарсан. Ялангуяа энэ тариалангийн гол бүс нутгуудад, баруун бүсүүдэд. Мал аж ахуйн салбар дээр мөн адилхан. Өнгөрсөн жил гээд л.../минут дуусав./

Б.Бейсен: 4 номер гүйцээж хариулъя.

Т.Жамбалцэрэн: Гол бүс нутаг болох зүүн аймгуудад зүй бус хорогдлын малын тоо, тэнд нэрвэгдсэн малчид, өрхийн амьжиргааны түвшин гээд маш олон асуудлууд байгаа. Тэгэхээр бид нар энэ тогтвортой хөдөө аж ахуйг хөгжүүлэхийн тулд газар тариалангаа бид нар тогтвортой хөгжүүлэх хэрэгтэй байна, мал аж ахуйгаа тогтвортой хөгжүүлэх хэрэгтэй байна. Тэгэхээр энэ салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага байгаад байгаа юм. Одоо бидний энэ төсвийн хязгаарт багтаад төсвийн хязгаарлалттай яваад байгаа энэ хөтөлбөрүүд маань зөвхөн хувийн хэвшил дээр арилжааны зээл хэлбэрээр оччихоод байдаг.

Яг одоо төсвийн хөрөнгө оруулалтаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багц дээр сүүлийн 10 гаруй жил 1 ч төгрөгийн хөрөнгө оруулалтууд нэмэгдэж явж ирж чадаагүй. Тухайлах юм бол өнөөдөр бид нар Био комбинатынхаа өргөтгөл, шинэчлэлийн ажлыг ч бүрэн гүйцэт хийж чадахгүй олон улсын байгууллагын зээл, зээлийн төсөл, хөнгөлөлттэй зээлийн хүрээнд л энэ технологийн шинэчлэлүүдийг хийж байгаа. Өнгөрсөн жил бид нар Био комбинат дээрээ технологийн шинэчлэл хийж, үйлдвэрлэлийн шугамыг автомат шугамтай болгосон. Ирэх жил бид технологи дамжуулалтаар импортоор авдаг тарилга вакцинуудаа дотоод.../минут дуусав./

Б.Бейсен: 4 номер гүйцээж хариулъя.

Т.Жамбалцэрэн: Хөрөнгө оруулалтыг нь нэмэгдүүлэх бололцоо бага байгаа учраас олон улсын байгууллага зээл, тусламжийн хөрөнгөөр хийхээр ажиллаж байгаа. Технологийн шугамаа Био комбинатаар нэвтрүүлж чадах юм бол бид нар ёсны концентрат аваад шингэрүүлсэн вакцин дотооддоо шүлхий, мялзангийн вакциныг үйлдвэрлэх бололцоо бүрдэх болов уу гэж ингэж тооцож байна. Энэ жилийн тухайд Био комбинатаар бүтээгдэхүүн хөгжүүлэлт хийгээд адууны сахуугийн вакциныг технологи нутагшуулаад үйлдвэрлэлд нэвтрүүлээд ингээд ажиллаж байна.

Хамгаалагдсан аж ахуй байгуулах чиглэлээр энэ арилжааны банкнууд дээр олгож байгаа хөнгөлөлттэй зээлийн хүрээнд арилжааны хөнгөлөлттэй зээлийн хүрээнд энэ хамгаалагдсан аж ахуйнуудыг байгуулахад бодлогын дэмжлэг үзүүлж ажиллана. Ер нь цаашдаа энэ малын өвчлөлийн асуудлаас ДМАЭМБ-аас өгч байгаа зөвлөмжийн дагуу бид нар тусгаарлагдсан аж ахуй байгуулагдаж байж эндээс бид нар тогтвортой экспорт, тогтвортой мал аж ахуйн бүтээгдэхүүнээ гаргах бололцоо бүрдэнэ гэж ингэж харж байгаа.

Мал аж ахуй үндсэндээ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар түрүүн .../минут дуусав./

Б.Бейсен: Хариултаа дараа нь бас бичгээр өгчхөөрэй. Ганхүлэг гишүүн тодруулъя.

М.Ганхүлэг: Детальчилж ярих зүйлүүд бас нэлээн байгаад байгаа юм. Экспорт дээрээ нэлээн анхаарлаа хандуулаад явахад л чиглэлээр үргэлжлүүлээд бас ажиллая. ЖДҮ-лэлийг дэмжих чиглэл дээр 1200 гаруй хүсэлтүүд ер нь жилд дунджаар ирж байгаа байх. Авч байгаа мэдээллээр. Түүний 300 гарантайг нь л бид бүхэн хангаж чадаж байгаа. Тэгээд нөгөө халамжаас хөдөлмөрт гэдэг агуулга, юм хийж бүтээе, бас жоохон юм хийчихье гэж байгаа хүмүүсээ хүмүүсээ ер нь дэмжих, дэмжихгүй тухай бид нар ингээд жил болгон яриад сүүлийн 7 жил 1 ч улсаас дэмжлэг байхгүй бие даагаад явж байгаа юм.

Тэгээд Сангийн яамнаас байх уу, хаанаас байх вэ? Ер нь яг ямар үндэслэлээр тодорхой энэ Хөдөө аж ахуйн яамны оруулж ирж байгаа саналыг хасаад байдаг юм бэ? Энэ яг хөдөлмөр эрхэлье гэж байгаа хүмүүсийг жоохон дэмжих энэ агуулгуудыг бид нар харгалзан үзэх тал дээр байж болохгүй юу? Хөдөө аж ахуйн яамнаас тэр боловсруулах үйлдвэрүүдийнтэй холбогдолтой асуудлаа яах ёстой вэ? Ховдын аж үйлдвэрийн парк яаж орж байна? Энэ жил дуусах уу? Нөгөө Дархан энэ.../минут дуусав.

Б.Бейсен: 4 номер, дараа нь Сангийн яамнаас Ганбат дарга бас хариулаарай. Энэ төсвийг хассан гээд яриад байна шүү дээ. Ямар учраас ийм юу болсон юм тэр тэр талаар тодорхой мэдээлэл өгөөрэй. 4 номер микрофон.

Т.Жамбалцэрэн: Ганхүлэг гишүүний асуултад тодруулж хариулъя. Тэр жижиг, дундын эх үүсвэртэй зээл Сангийн яам хасна гэхээсээ илүүтэйгээр бид нар байгаа төсвийн хязгаартаа л багтааж ингэж төсвөө өргөн барьж байгаа юм. Зүгээр ер нь цаашдаа энэ Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал дээр тулгуурлаад бүсийн

2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

гэдэг юм уу тийм тодорхой бүсчилсэн хэлбэрээр нь санхүүжилтийн хэлбэрүүдийг бас гаргах нь зөв юм болов уу гэж ингэж бид ажиглагдаад байгаа. Бүс, Шинэ Ховд үйлдвэр технологийн парк 26 онд бүрэн ашиглалтад орно гэж ингэж тооцож байгаа. Суурь дэд бүтцийн ажлуудыг үндсэндээ хийгээд дууссан. Цэвэрлэх байгууламжийн нэмэлт санхүүжилттэй холбоотой асуудал түрүүн Мандхай гишүүний асуулт дээр гарч байсан 1.8 тэрбум төгрөгийн нэмэлт санхүүжилт ирэх оны төсөв дээр суугдаад ирэх 26 ондоо бүрэн ашиглалтад орно.

Дарханд Хүнс, хөнгөн үйлдвэрийн паркийн бүтээн байгуулалтын ажлуудыг эхлүүлээд суурь дэд бүтцийн ажлууд нь эхэлчихсэн явж байгаа. Тухайн бүсэд.../минут дуусав./

Б.Бейсен: Гүйцээж хариул 4 номер.

Т.Жамбалцэрэн: Бүсэд хөрөнгө оруулж үйл ажиллагаагаа явуулах аж ахуйн нэгжүүдийн сонгон шалгаруулалтыг хийгээд газар олголтын ажлыг зохион байгуулахаар ингээд ажиллаж байгаа. Ингэх юм бол ямар ч байсан баруун бүсэд Үйлдвэр технологийн парк, төвийн бүсэд Хүнс, хөнгөн үйлдвэрийн технологийн цогцолбор, үйлдвэрийн парк ашиглалтад орохоор ингээд байгаа. Ер нь улсын улсын төсвийн хөрөнгө оруулалтаар суурь дэд бүтцийн ажлуудыг нь хийх л ийм л дүр зурагтай байгаад байгаа юм.

Б.Бейсен: Сангийн яамныхан хариулт өгөөч. Ганбат дарга байна уу? 4 номер. 4 номерын микрофон өгье.

Ж.Ганбат: Гишүүний асуултад хариулъя. Ер нь энэ онд төсөв бид энэ хавар төсвийн тодотголыг Улсын Их Хурлаар батлуулсан. Орлогыг 3.3 их наядаар бууруулаад зардлыг 2 их наядаар бууруулсан ийм тодотгол хийсэн. Сая эхний 8 сарын төсвийн орлого 800 гаруй тэрбум төгрөгөөр бас буурчихсан ийм үзүүлэлттэй явж байна.

Тэгэхдээ ер нь амаргүй байна. Тэгэхээр бид ирэх онд бас бүсээ чангалсан байдлаар төр хэмнэлтийн байдлаар явах ийм ийм байдлаар бид ингэсэн. Төсөв бололцоотой байсан бол мэдээж яамнуудын оруулж ирээд байгаа саналуудыг бид бас боломжоор нь авна. Яах вэ энд яригдаж байгаа юман дээр би нэг юм харамсаж байгаа нь Сангийн яам хасдаг хасдаг гэж яриад байна. Бид Сангийн яам ганцаараа төсөв хийдэггүй. Төсвийн ерөнхийлөн захирагч нар бүх яамнууд ярьж байгаад, кабинетаараа удаа дараа ярьж байгаад энэ бүгдийгээ ойлголцоод Улсын Их Хурал төсөв өргөн барьдаг. Ийм учраас энэ дээр яригдаж байгаа юмнууд дээр бид өнөөдөр одоо яг байгаа нөхцөл байдал дээрээ л бид юмнуудаа тоо.../минут дуусав./

Б.Бейсен: 4 номер гүйцээж яриулъя.

Ж.Ганбат: Ийм учраас үүнийг бас эрхэм гишүүд бас ойлгох байх гэж ингэж байна. Тэгээд яах вэ бид ирэх оны хувьд бас амаргүй байна. Энэ оны төсвийн бас жилийн эцсийн хүлээгдэж байгаа гүйцэтгэл яг өнөөдрийн байдлаар энэ хэвээрээ үргэлжлээд л дахиад бараг 1 их наядаар орлого буурч болзошгүй байна. Тэгэх юм бол бид дахиад бүсээ чангалаад явна өөр арга байхгүй. Ийм байдлаар байгаа. Яах вэ тэр ЖДҮ энэ тэр, ЖДҮХС-ийн хувьд бид төсвөөс өгөхгүй. Энэ бол эргэлтийн мөнгөөрөө эх үүсвэрээ санхүүжүүлээд явах нь хамгийн зүйтэй юм гэдэг ийм

2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

бодлогыг ер нь гаргаад нэлээн хэдэн жил хэрэгжүүлж байгаа. Мэдээж Хөдөө аж ахуйн яамнаас энэ дээр улсын төсвийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх энэ тэр гэдэг асуудлыг удаа дараа тавьж тавьж байгаа. Бид ер нь аливаа энэ ингээд яах вэ эргэлтийн сангийн, сангуудыг өмнө олгосон. Олгосон зээлийнхээ эх үүсвэрүүдээрээ бүрдүүлээд явах нь илүү нээлттэй, ил тод юм, шударга юм гэдэг ийм байр суурийг баримтлаад явж байгаа.

Б.Бейсен: Алтаншагай гишүүн асуулт асууя.

Н.Алтаншагай: Тодруулах хэдэн зүйл байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас эхлээд тодруулъя. Өвс тэжээлтэй холбоотой үнэ тарифыг хамгаалахаар ийм бодлого орж ирсэн үү? Энэ зун баруун болон төвийн бүсийн аймгууд зудтай, их хүндрэлтэй байна. Одоо намар ид яг хадлан тэжээлийн үе хийж энэ өвлийн бэлтгэл ажлаа хангаж байна. Тэгээд үндсэндээ зүүн 3 аймаг, Дорнод, Хэнтий, Сүхбаатараас л энэ малчид өвсөө ерөнхийдөө базааж байх шиг байна. Үүнийг дагаад нөгөө бэлчээрийн доройтол гэдэг маань яг бодитоор явагдаад эхэлж байгаа. Зүүн 3-н аймгийг нөгөө хадлан тэжээл бэлтгэх нэрийдлээр ер нь талхлаад дуусаж байна шүү дээ. Бас нөөц газар нь энэ. Тэгэхээр энэ маань хүнд байдалд орж байгаа. Энэ дээр яг ямар энэ бэлчээр хамгаалах, энэ хөрсний бохирдол, энэ нөгөө доройтлоос хамгаалах яг ямар бодлого үйл ажиллагаанууд байгаа юм?

Энэ яаман дээр харахаар энэ 2 яаман дээр ижилхэн чиг үүрэгтэй газрууд байх шиг байх юм. Энэ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаман дээр энэ Ургамал хамгааллын газар гэж байгаа юм. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаман дээр болохоор Газрын доройтол бууруулах, цөлжилтөөс сэргийлэх гэсэн ийм чиг үүрэг давхцалтай байж мэдэхээр ийм 2 бүтэцтэй газрууд байгаа юм. Энэ дээр маань яг бодит хийгдэхээр ажил тусгагдсан уу? Бэлчээр хамгаалах талаар энэ дээр байна.

Байгаль орчны яамнаас асуухад энэ 21 аймгийн 330 сум чинь энэ орчны бохирдол, энэ хөрсний бохирдлын доройтолдоо бүүр дээд цэгтээ туллаа шүү дээ. Зун ингээд гэр бүлээрээ гаднын зочид, төлөөлөгчидтэй ингээд явахаар мянган км явахад замынх нь 2 тал битүү хог, сум суурин газар руу дөхөхөөр бүүр илүү ингээд хогтоо дарагдсан. 2, 3 жилийн өмнө ийм л байсан одоо ч гэсэн яг ийм л байна. Бодит өөрчлөлт гарахгүй байна. 21 аймгийн энэ 330 сумдаа энэ хог шатаах энэ жижиг зуух авах ийм төсөл хэрэгжүүлж болдоггүй юм уу? Ингээд хогноосоо ангижрах бүрэн боломж байнаа шүү дээ. Бараа, үйлчилгээнийх нь зардал нэмэгдээд байдаг бахь байдгаараа л байгаад байдаг. Энэ дээр яг бодит ажил хийж энэ асуудлаа зөв эрэмбэлж тусгаж оруулж ирээч ээ гэж хүсэж байгаа юм. Энэ дээр хариулт авъя.

Б.Бейсен: Батбаатар сайд хариулъя. Дараа нь 5 номер.

Б.Батбаатар: Энэ 21 аймаг 330 сум гээд хэлж байна. Яг энэ байгаль орчны газруудын энэ хэвтээ удирдлагатай буюу аймаг, сумын Засаг дарга томилж байгаа нэгдүгээрт. Энгийг бас бодож үзэх ёстой юм байна лээ. Яагаад вэ гэхлээр орон нутагт байгаа байгаль орчин бохирдуулж байгаа асуудлыг шийдэх тэрэнтэй тэмцэхийн тулд бас удирдлагын хувьд эрх чөлөөтэй байх нь зөв байж магадгүй гэдэг зүйлийг Байгаль орчны газрын хүмүүс маань хөдөө орон нутаг 8 аймагт томилолтоор ажиллахад нэлээдгүй олон хүн хэлж байна лээ.

2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Хоёрт нь энэ байгаль хамгаалагчдыг хог цэвэрлэгч болгодог жишиг ер нь тогтох гээд байна. Би энэний эсрэг байгаа. Хог хаяулахгүй байх, тэр хог хаясан этгээдэд хариуцлага тооцох тэр чиглэл рүүгээ байгаль хамгаалагч нар ажилладаг байх хэрэгтэй. Дээрээс нь энэ сум, орон нутгийн хог хаягдал, хүний буруутай үйл ажиллагаа, аж ахуйн нэгж, хүний буруутай үйл ажиллагаанаас үүсэж байгаа хогийг цэвэрлэх энэ чиг үүрэг орон нутгийн засаг захиргаанд байдаг юм шүү дээ. Байгаль орчны сайдад биш. Сумын Засаг дарга, аймгийн Засаг дарга, дүүргийн Засаг дарга, хотын Засаг дарга, нийслэлийн.

Тэгэхээр энэ хүмүүст хүмүүсийг хоггүй наадъя гээд бид нар уриалга гаргаад наадмын өмнө Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын албан даалгаврыг гаргаж бүх аймгийн Засаг дарга нар руу явуулсан. Зарим нь хариу ирүүлсэн. Зарим нь, ихэнх нь ирүүлээгүй. Тэгэхээр энэ асуудлуудыг бас Засгийн газрын Хэрэг эрхлэхийн газрын даргад хэлж Хэрэг эрхлэх газрын дарга, аймаг, орон нутаг, сумын дарга нар руу албан даалгавар өгч, Хэрэг эрхлэх газрын Хяналтын газар хяналт зохиож арга хэмжээ авч ажиллах нь зүйтэй юм. Энэ асуудлыг бас би Хэрэг эрхлэх газрын дарга, сайдад Засгийн газрын хуралд бас хэлэх нь зүйтэй юм байна гэж ойлгож байна.

Б.Бейсен: Дараа нь 5 номер.

Т.Жамбалцэрэн: Алтаншагай гишүүний асуултад хариулъя. Өвөлжилтийн бэлтгэл ажил хангахтай холбоотой, өвс тэжээлийн нөөц бүрдүүлэхтэй холбоотой Улсын Онцгой комиссоос ч хэд хэдэн өргөтгөсөн хуралдаануудыг зохион байгуулсан. Өнгөрсөн 8 сар, 9 сард. Өнгөрсөн 8 сарын энэ гангийн эрсдэлийн үнэлгээгээр баруун бүсийн аймгууд төвийн бүсийн хэд хэдэн аймгууд нэлээн тийм өндөр эрсдэлтэй гарсан. Үүнтэй холбоотой Ерөнхий сайдын бас өргөтгөсөн хуралдааныг 21 аймгийн Засаг дарга энэ хөдөө аж ахуй, Онцгой комисс, мал эмнэлгийн байгууллагуудыг оролцуулсан өргөтгөсөн хуралдаануудыг хийж, тодорхой үүрэг чиглэлүүд өгсөн. Засгийн газрын 56 дугаар тогтоолоор энэ өвөлжилтийн бэлтгэл хангахтай холбоотой өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэхтэй холбоотой холбогдох тогтоол, өвөлжилтийн бэлэг хангах тухай албан даалгаврууд гарсан. Энэ хүрээнд бас Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас, УОК-оос чиглэлийн дагуу тодорхой ажлын хэсгүүд гараад эрсдэл бүхий аймгуудад бас ажилласан.

Б.Бейсен: 5 номер гүйцээж хариулъя.

Т.Жамбалцэрэн: Аль болох бид тэр импортын татвар НӨАТ-ыг оролдохоосоо илүүтэйгээр дотоодын нийлүүлэлтийг нэмэгдүүлэх чиглэлд онцгой анхаарч ажиллаж байгаа. Энэ хүрээндээ экспортод гарч байгаа хивэг, тэжээлийг бас дотооддоо нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, нөгөө талдаа энэ эрсдэл бүхий баруун бүсийн аймгуудыг хил залгаа бүсүүдээс өвс, тэжээл импортлох асуудлуудыг бас чиглэлийг өгч холбогдох зохион байгуулалтын ажлуудыг хийж байгаа. Энэ жилийн тухайд тухайн аймаг, сумд, багт өвөлжих малын тоо, түүнд тохирсон шаардлагатай илчлэг, тэжээл шаардлагатай өвс, тэжээлийн нөөц нормоор нь тогтоож нэлээн өндөр хувьтай бэлдэхээр гарсан. Энэ өвөлжилтийн бэлтгэлийн тогтоолын хэрэгжилт энэ 10 сарын эхээр Засгийн газрын хуралдаанд танилцуулагдаад одоо Байнгын хороонд эргээд танилцуулагдана гэдгийг бас хэлье.

2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Ургамал хамгааллын газар бол нөгөө давхардсан чиг үүрэгтэй гэхээсээ илүүтэйгээр таримал ургамал талдаа ажилладаг. Олон улсын гэрээ, конвенцын хүрээ.../минут дуусав./

Б.Бейсен: 5 номер гүйцээж хариулъя.

Т.Жамбалцэрэн: Ургамлын гаралтай бараа, бүтээгдэхүүнийг экспортод гаргах суурь нөхцөлийг бүрдүүлж байгаа ийм чухал агентлаг. Энэ нь яг нөгөө бэлчээр, бэлчээрийн доройтолтой тэмцэх агуулгатай биш. Ер нь цаашдаа бид нар энэ мал аж ахуйн салбарыг тогтвортой явуулах, малчдаа эрсдэлээс хамгаалах энэ чиглэлд явах юм бол бид нар таримал тэжээлийг нэлээн нэмэгдүүлэх шаардлагатай. Энэ жилийн тухайд бас голд таримал тэжээл таардаг тариалангийн гол бүс нутаг маань бас ургац алдсан асуудал бий.

Цаашдаа бид нар энэ усалгаатай газар тариаланг хөгжүүлэх, малчдын түвшинд энэ өвс, тэжээлийн аюулгүй нөөцийг маш сайн бэлдэх ажлуудыг зохион байгуулахгүй бол одоо гамшиг, эрсдэл болдог тэгээд улсын аюулгүй нөөц гээд ингэдэг улсын аюулгүй нөөц нь дотооддоо хувийн хэрэглэгчтэйгээ өрсөлдөж өвс тэжээл, нөөц бүрдүүлдэг, эргээд энэ үнийг хөөргөдөх ийм асуудлууд болдог. Тэгэхээр бид нар энэ цаашдаа зохион байгуулалтынхаа асуудал дээр анхаарах нь чухал.

Дээр нь өндөр уургийн агууламжтай малын тэр шаардлагатай шим тэжээл уургийн агууламжийг агуулсан тэр таримал тэжээлийг бид нар.../минут дуусав./

Б.Бейсен: Алтаншагай гишүүн тодруулъя.

Н.Алтаншагай: Байгаль орчны яамнаас нэг зүйл тодруулах зүйл байна. Энэ самар түүхтэй холбоотой асуудлууд ид өрнөж байгаа юм. Самар үүнтэй холбоотой мэдээллийг тэр аж ахуйн нэгж болон иргэддээ маш сайн өгмөөр байна. Самар ургадаг жоохон бүс газрууд бий. Түүнийг дагасан энэ хуш мод чинь ерөнхийдөө сүйдээд дуусаж байна. Хэдий хэмжээний татвар, мөнгө яг энэ самраас улсад төвлөрч байгаа юм бэ? Эргээд үүгээр нөхөн сэргээлт хийж энэ ой байгаль орчноо хамгаалж чадах юм уу? Энэ дээр. Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас дахиад нэмж тодруулах нь энэ юутай холбоотой юм байгаа юм л даа. Өвс, тэжээлтэй холбоотой. Бид нар чинь нөгөө мах, бензин дээрээ бас хамгаалаад бодлого гаргаад мөнгө өгөөд байдаг. Өвсөн дээр 2023 оны хавар 1 боодол өвс 40 мянга болсон шүү дээ. Одоо энэ жил яг энэ ченжүүдийн гарт, аманд ороод л малчид маань ийм өндөр үнээр.../минут дуусав./

Б.Бейсен: Байгаль орчны сайд хариулъя.

Б.Батбаатар: Самрын тухай зөвшөөрөл өгдөг хугацаа байдаг юм байна лээ батлагдсан журам. 10 хоногийн өмнө аймгууд самрын ургалтынхаа нөөц мэдээллийг өгөөд манай ойн газар дээр нэгтгэгдээд тэгээд сайд 9 сарын 1-нээс өмнө байх тушаал гаргадаг. Тэгээд энэ дагуу 6 аймаг шиг санаж байна. Самрын зөвшөөрөл дээр энэ жилийн самрын тухайд нөөцийн зөвшөөрөл дээр гарын үсэг зурсан. Хэдэн тонн самар, ямар хэмжээний энэ жилийн орлого нь хэд болж байгаа тухай Байгалийн нөөцийн газрын дарга Балжинням хариулчхаарай. Балжинням дарга хариулчих тодруулаад иргэдэд нээлттэй.

2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Б.Бейсен: 6 номер хариулъя.

Т.Балжинням: Гишүүний хариултад хариулъя. Энэ жилийн тухайд 7 аймаг дээр дуудлага худалдаа явагдсан. 6.6 мянган тонн самрыг үйлдвэрийн зориулалтаар бэлтгэх дуудлага худалдаанд орсон. Тэгээд үүнээс бол 6.4 мянган тонн самар дуудлага худалдаанд орсон байна. Дуудлага худалдааны хүрээнд нийт орсон орлого өнөөдрийн байдлаар 23.5 тэрбум орсон. Үүнээс гэрээгээ байгуулаад, байгуулах дээр тухайн мөнгө нь бол дансанд төвлөрөгдөөд орно гэсэн үг.

Б.Бейсен: Туваан гишүүн асуулт асууя.

Ц.Туваан: За.

Б.Бейсен: Өвсний жилийн үнэ гэнэ үү? Төрийн нарийн 5 номер хариулах юм байна.

Т.Жамбалцэрэн: Дотоодын гурилын, гурил тэжээлийн үйлдвэрүүдээс нийлүүлэгдэж байгаа тэжээлийн үнэ ханш дээр харьцангуй өсөлт гарахгүй. Ер нь яах вэ зүгээр төр өөрөө аюулгүй нөөц улс өөрөө бэлдээд явж байгаа. Нөгөө талдаа малчдын түвшинд өвс, тэжээл аюулгүй нөөц бүрдүүлэх ийм тоо хэмжээ Засгийн газрын тогтоолоор хүргүүлдэг. Малчдын түвшинд бэлдсэн өвс, тэжээлийн нөөц өөрөө тодорхой түвшиндээ хүрдэггүй асуудал бий. Тэгээд нөгөө ган, зуд, гамшиг асуудал болоход эргээд асуудал тулгардаг. Малчдаар бид эрсдэл бүхий 10-аад аймгаар малчдын түвшинд уулзалт хийгээд тэдэнтэй бас санаа бодлыг нь сонсоод явахад үнийн тогтвортой байдлын асуудал, нийлүүлэлтийг нэмэгдүүлэх асуудлууд, дээр нь малчдын түвшинд энэ хүчит тэжээлийн асуудал гэдэг гэдэг дээр салбарын яам анхаарч өгөөч ээ гэдэг асуудлуудыг тавьдаг. Улсын онцгой нөөцөд Онцгой байд.../минут дуусав./

Б.Бейсен: Хариултыг нь бас бичгээр Алтаншагай гишүүнд бас Төрийн нарийн өгчхөөрэй. Туваан гишүүн асуулт асууя.

Ц.Туваан: Байгаль орчны яамнаас асууя. Энэ өмнөх Засгийн газрын мөрийн хөтөлбөрт ороод явж байсан л даа говийг усжуулах гээд гишүүд бас яриад байна. Тэгэхээр манай улсад энэ үйлдвэрлэлийнхээ боломжийг тэлэх, мөнгө олдог энэ салбараа тэлэхэд 3, 4 хүчин зүйл маш чухал нөлөөтэй байгаа юм. Үүний нэг нь эрчим хүч, хоёрт нь энэ говийн бүсэд ус ороод байгаа юм. Гуравт нь хүний нөөцийн асуудал дутагдалтай байна үнэхээр. Тэгэхээр энэ өмнөх Засгийн газар дээр энэ шийдвэр нь гарчихсан говийг усжуулах гээд энэ төслийн нэгж байгуулагдсан. Энэ төслийн нэгжийн санхүүжилт нь хийгдэхгүй бана, байгаа тухай бас мэдээлэл байна. Тэгээд энэ яагаад ингээд тавигдахгүй байгаа юм бэ ер нь тавигдах юм уу?

COP17-г ойлгож байна. Нэгэнт улсаараа амлаад ингээд явчихсан, зохион байгуулахаар болчихсон олон улсын өмнө хүлээсэн үүрэг учраас энэ дээрээ харин тэр төсөв мөнгө нь хүрч байдаг юм болов уу яадаг юм энийг бас хийгээд улсын нүүр царай учраас хийгээд явах нь зөв байх гэж ингэж бодож байна.

Самартай холбоотой асуудал дээр энэ Төв аймгийн Мөнгөнморьтоос асууж байсан тэгээд сүүлийн үед би тодруулж чадаагүй байна. Мөнгөнморьт дээр энэ

2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

нөгөө самар хураалтын төлөвлөгөөнд орж чадаагүйнэ тэр гээд асуудал байсан. Энэ асуудал шийдэгдчихсэн үү яасан гэдэг дээр тодруулга авчихъя гэж бодож байна.

Хөдөө аж ахуйн яамнаас ер нь зун гантай байсан, газар тариалангийн салбар чинь маш хүнд байгаа. Танайхан болохоор ингээд л ийм усалгаатай юм уу хэд гурван аж ахуйн нэгжээрээ тойроод л хэд гэнэ үү 30-35-ын өсөлт, хувийн өсөлт гээд ингээд нэг юм яриад байгаа юм. Би бол энд чинь итгэхгүй байгаа юм. Төрийн нарийн бичгийн дарга хэлж байна тэжээлийн үнэ нэмэгдээгүй ээ гээд. Нэмэгдсэн. Хивгийн чинь үнэ тонн тутамдаа 40-50 мянган төгрөгөөр нэмэгдчихсэн явж байгаа. Ахиад ч нэмэгдэж магадгүй гэж би бодож байгаа юм. Яагаад гэхлээр эрэлт маш ихтэй байна л даа. Тэгэхээр энэ дээр нөгөө ногоон тэжээл чинь ургаагүй, ургац алдчихсан энэ үед энэ импортын тэжээлийн асуудал дээр бас нэг юм гарч ирэх л байх тийм. Тэгэхээр энийг бас урьдчилаад харж байсан нь зөв байх гэж ингэж бодож байна.

Нэг зүйл асуугаад байгаа тэр нь юу вэ гэхлээр энэ тариаланчдын, ногоочдын энэ авсан маш их зээл байгаа. Одоо зээл аваад тарьчихдаг. 2 жилийн циклтай тариалалт хийдэг, уринш хийдэг, тариалдаг, хураадаг, дараа нь ургац аваад зээлээ дардаг. Ургац алдчихсан улсууд юугаар зээлээ дарах вэ? Тэгэхээр энэ дээр энэ зээлийн төлөлтийг хойшлуулах гэдэг асуудлыг ер нь би бас асуугаад чуулган дээр ч асуугаад олигтой хариулт авч чадахгүй байгаа. Энэ дээр ер нь ямар бодлого байгаа юм Хөдөө аж ахуйн яам хэлчихмээр байна.

Төсөвтэй холбоотой зүйл нь болохоор энэ хөдөө аж ахуйн салбарт хэрэгжүүлж байгаа олон хөтөлбөрүүд байгаа. Энэ дотор орж ирж байгаа энэ хүүгийн татаас, урамшуулалтай холбоотой асуудлууд байна. Нэлээн олон тэрбум төгрөг байгаа. 120, 30 тэрбум төгрөг байх шиг байна. Эндээс энэ газар тариалангийн салбарынхаа зээлийн хойшлуулаад энэ хүүгийн татаас дээр нь энэ онцгой нөхцөл байдал үүсчихсэн үе дээр нь бодлогын арга хэмжээ авч болохгүй юу гэдэг нэг ийм асуудал байгаа.

Зун ингээд л ган болоод л орохгүй байсан юм. Сэлэнгэ, Дарханд явж байхад нөгөө үүлэнд нөлөөлдөг сумны асуудал хүрэлцээ байхгүй, буудаж өгдөггүй, урдаас ирж байгаа цөөхөн сум байгаа, дуусчихсан гээд. Энийг ер нь яагаад урьдчилаад нөөцөлчхөж болдоггүй юм бэ? Энэ дээр ер нь хэдэн төгрөгийн төсөв байгаа юм, энэ ер нь хаанаа төсөв санхүү нь явдаг юм бэ? Энэ дээр юу хариулт хэлээд өгмөөр байна.

2 тоо байна. Зээлийн батлан даалтын сан 20 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ юунд зарцуулах мөнгө ингээд нэмэгдчихэв? 1 минутаа нэмээд авчхаж болох уу? Тэгж байгаад яачихъя.

Б.Бейсен: Туваан гишүүнд 1 минут өгье.

Ц.Туваан: Энийг Урамшуулал дээр өнгөрсөн оныхоос 233 тэрбум төгрөгөөр буурчихсан явж байна. Урамшуулал чинь. Хөдөө аж ахуйн салбар урамшуулал дээр явдаг юм. Энийг зарим хүмүүс энэ татаасыг шүүмжилдэг. Тэгэхдээ л бодит байдал энэ. Үндэсний аюулгүй байдал, хүнсний аюулгүй байдалтай холбоотой хүн амаа хүнсээр хангах асуудал учраас татаас дээр явдаг. Энэ юунаас ингээд ямар урамшуулал буурчхав? Тэгээд тодорхой нэг зүйл асууя. Хүнсний ногоонд

2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

урамшуулал олгож байгаа. Хүнсний ногооноос энэ манжинг яагаад ингээд ямар шийдвэрээр хасчхав? Хөдөө аж ахуйн сайд манжингийн хангалт 100 хувь болсон гэж энэ дээр чинь бас шийдвэр байх ёстой биз дээ? Энэ ямар шийдвэрээр энэ манжингийн урамшууллыг хассан гэдгээ надад хэлээд өгчихвөл сайн байна. Одоо ингээд яах вэ гэхээр манайхан дахиад манжин тариалалт чинь унана, урамшуулдаггүй юм чинь ингээд унана. Тэгэхээр энэ бодлого чинь ер нь зөв явж байгаа юм уу ямар байгаа юм? Энэ талаар хариулт авчихъя.

Б.Бейсен: 5 номер хариулъя.

Т.Жамбалцэрэн: Туваан гишүүний асуултад хариулъя. Тэр Зээлийн батлан даалтын сантай холбоотой 20 тэрбум тэрбум төгрөг гээд. Энэ Зээлийн батлан даалтын сангийн өөрийн хөрөнгийг нь нэмэгдүүлж байгаа ийм хэлбэр. Өөрийн хөрөнгийг нэмэгдүүлснээр Ерөнхийлөгчийн санаачилсан 2 хөтөлбөр, Атрын 4 дүгээр аян, Шинэ хоршоо хөдөлгөөнүүдийг хэрэгжүүлэхэд эдгээр дээр гарч байгаа батлан даалтын хэмжээ нь нэмэгдэх, илүү зээлийн хүртээмжийг нэмэгдүүлж, барьцаа хөрөнгийн дутагдалтай иргэн, аж ахуйн нэгжүүдэд батлан даалт гаргахад дэм болж байгаа ийм хэлбэр байгаа юм. Тэгэхээр Зээлийн батлан даалтын сангийн агуулга тэр хүрээнд байгаа.

Хүүгийн татаас улсын хувьд Хүнсний хувьсгал дээр гээд аваад үзэх юм бол 26 онд ингээд дуусаж байгаатай холбоотой буурсан. 640 тэрбум болж буурч байгаа. Мөн нөгөө зудад өртсөн малчдын зээлийн хүүгийн татаас бас буурч байгаа. Энэ хүрээндээ буурсан. Яг үндсэн 4 хөтөлбөртэй холбоотой хүүгийн хөнгөлөлт татаас буураагүй ийм дүнтэй байгаа.

Тэжээл дээр бид бас тодорхой арга хэмжээг авч байгаа. Ялангуяа бид нар ингээд л зудын эрсдэлийн үнэлгээ болдог асуудал тулгарахад зүүн бүсээсээ баруун бүс, баруун бүсээсээ зүүн бүс, хойд бүсээсээ өмнөд бүс рүүгээ ингээд л тэжээл зөөдөг. Бид нар бүсчилсэн тэжээлийн үйлдвэрүүдийг байгуулах ажлыг хийж байгаа. Тухайн бүс нутгуудад усалгаатай газар тариалан бий болгох, тэнд төмс, хүнсний ногоо, ногоон тэжээлээ тарих, тухайн бүсээсээ хэрэгцээгээ хангах энэ бололцоог бүрдүүлэх чиглэл дээр бас сүүлийн жилүүдэд анхаарч ажиллаж байгаа.

Тэгээд энэ хүрээндээ баруун бүсэд, Завхан аймагт, Ховд аймгуудад тэжээлийн үйлдвэр Дэлхийн банкны санхүүжилттэй ингээд ашиглалтад орохоор ажиллаж байна. Түүхий эдийн нийлүүлэлтийг нь бид нар тогтвортой болгохын тулд бид нар усалгаатай газар тариалан явуулах шаардлага байгаа. Хүнсний 5 төрлийн бүтээгдэхүүнд бид нар урамшуулал олгож байгаа. Эдгээр урамшууллууд маань тодорхой хүрэх үр дүнтэй, тодорхой хугацаатай байх ёстой гэж ингэж үзээд байгаа. Зарим төрлийн бүтээгдэхүүн дээр бид нар хугацаагүй бас олгоод яваад байгаа асуудлууд бий. Тухайлах юм бол бид сүүний урамшууллыг өгсний үр дүнд бас тодорхой ахицууд гарч байгаа. Хүнсний ногооны урамшуулал өгсний үр дүнд ахицууд гарч байгаа. Эдгээр урамшууллуудыг олгох эрх зүйн шийдвэрүүд нь анх гарахдаа дотоодын хэрэгцээ хангагдсан тохиолдолд эдгээр урамшууллуудыг зогсооно гэсэн тодорхой ийм зорилтот түвшнүүдтэй.

Тэгэхээр хүнсний ногоон дээр бид нар харьцуулаад үзэхэд өнгөрсөн жилийн дүнгээр манжин дотоодын хэрэгцээ бүрэн хангахуйц хэмжээнд хүрсэн гэдэг статистик тоо тулгуурлаж бид нар манжингийн урамшууллыг хойшлуулсан. Ингээд

2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

бусад бид нар таримлууд руугаа жигд бид нар шилжүүлээд явахгүй бол бас энэ урамшуулал ингээд нэр төрөл нь нэмэгдээд л тоо хэмжээ нь нэмэгдээд л байдаг бид нарын шаардлагатай санхүүжилтийн урамшууллын нийт дүнгүүд маань бас хүрэхгүй асуудлууд байгаа.

Дээр нь энэ гангийн эрсдэлийн үнэлгээгээр нэлээд эрсдэлтэй гарсан аймаг, сумаар нь бас нарийвчилж гаргасан мэргэжлийн байгууллагууд. Энэ дээр мэргэжлийн байгууллагуудын холбогдох дүгнэлтээ УОК-ын шийдвэрүүдийг гаргуулж байгаад зээлийн хүүгийн хөнгөлөлт, эргэн төлөлтийг хойшлуулах ажлуудыг бид нар зохион байгуулж ирсэн. Өнгөрсөн онд бид нар баруун бүсийнхийг хойшлуулаад л ирсэн. Энэ жилийн тухайд ч гэсэн бид энэ ургац хураалтын дараа мэргэжлийн байгууллагуудын санал, дүгнэлтэд үндэслээд зээлийн эргэн төлөлтийг хойшлуулах боломж бол байгаа.

Б.Бейсен: Батбаатар сайд хариулъя.

Т.Жамбалцэрэн: Үүлэнд нөлөөлөх асуудал Байгаль орчны яам хариулах байх.

Б.Батбаатар: Үүлэнд нөлөөлөх тухайд манай Ус, цаг уур орчны шинжилгээний газарт төсөв нь тавигддаг. Жилдээ 600 орчим сая төгрөг, нарийвчилсан мэдээ авъя гэвэл Баттулга дарга хариулчихна биз. Ер нь өнгөрсөн наадмын өмнө 1150 ширхгийг импортоор оруулж ирсэн. Үүнээс төсөв тавигдаагүй учраас энэ жил талыг нь, ирэх жил талыг нь хэрэглэнэ ээ гэсэн ийм. Уул нь энэ жил бүгдийг нь хэрэглэх зориулалтаар аваад тэгээд ингээд 2 хувааж хэрэглэе ээ гээд ийм зүйл байсан. Монголд үйлдвэрлэж эхэлж байгаа энэ пуужинг тэр пуужингийн туршилтын загварыг нь үйлдвэрлээд болно гээд тэр дээр төсөв, зардал тавигдсан боловч харамсалтай нь нөгөө төсөв өргөн баригдахад хасагдчихсан. Хэрвээ тэр байсан бол 1 ширхгийг нь 165 доллароор авдаг пуужин 30 орчим гэдэг чинь 50 орчим доллароор хасагдаж, 110 орчим доллароор дотооддоо үйлдвэрлэх буюу илүү нөөцтэй болох, гаднаас хамааралгүй болгох ийм боломж бол байсан. Говь.../минут дуусав./

Б.Бейсен: Батбаатар сайд гүйцээж хариулъя.

Б.Батбаатар: Говийг усжуулах төслийн нэгжийг уг нь Сангийн сайд бид нар бас, Сангийн сайд дэмжлэг үзүүлээд шийдээд өгье гэсэн юм 856 сая төгрөгийг 2026 оны төсөвт нь тавиад байгаа. Өмнөх 25 онууд л 230 сая байсан төслийн нэгжийнхээ бичгийг өгчих өө, бичгээ өгчихвөл төсвийн төсөлдөө оруулаад Засгийн газар дээр боогоод өргөн барьчихъя гээд тийм зүйл яасан. Харамсалтай нь өргөн баригдахад тэр нь алга болчихсон. Одоо тэгээд тийм л хариулт байна даа.

Төв аймгийн Мөнгөнморьтын самрын тухайд 8 сарын 10-ны дотор бичгээ ирүүлэх ёстой. Надад ирж, надад биш ээ Ойн газарт ирсэн бичгээрээ 9 сарын 05-ны өдөр тухайн Төв аймгийн Засаг дарга үйлдвэрлэлийн зориулалтаар бус ахуйн зориулалтаар 250 мянган тонн гэсэн байх самар бэлдье ээ гэдэг бичиг ирсэн. Тэр дээр журмынх нь хугацаа дууссан. Одоо нэгэнт журам нь байгаа учраас би нэг л зүйл хэлж байгаа юм. Нэг бол журмаа өөрчилж ир.

Б.Бейсен: Хариулт авчхаад, Сангийн яам нэмж хариулах уу? Хариулт байхгүй. 2 номер Баттулга дарга 6 номер.

2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Э.Баттулга: Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга Баттулга байна. Туваан гишүүний асуултад хариулъя. Энэ жилийн хувьд 1105-ийг оруулж ирсэн. Өмнө нь КОВИД-оос болоод энэ тэсэрч дэлбэрэх бодисын хяналт дотоодод чангараад БНХАУ-аас оруулж ирэхэд хүндрэл учирч байсан. Тэр утгаар нь бид нар дотоодод үйлдвэрлэе гэдэг арга замаа эрэлхийлээд явж байгаа. Энэ жилийн хувьд бол төсөв дээр бол яг улсын төсөв дээр суугаагүй. Гэхдээ энэ орон нутгийн хөгжлийн сангийн, сумын орон нутгийн хөгжлийн сангийн журамд бол малын хөлийн татвараас орсон мөнгөөр зарцуулах чиг үүрэгт нь бол хур тунадас зориудаар нэмэгдүүлэх гэсэн зардал байгаа. Тэр утгаар нь аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвүүдэд бол хэрэгцээ шаардлагыг нь хараад төсвийг нь орон нутгаас гаргуулаад явна шүү гэдэг ийм чиглэл өгсөн байгаа.

Б.Бейсен: Туваан гишүүн тодруулъя.

Ц.Туваан: Тэр манжингийн урамшууллын шийдвэрийг нь надаа өгчхөөрэй. Ямар шийдвэрээр? Энэ чинь ингээд төрийн бодлого явж байснаа гэнэт өөрчлөгдчихдөг нөгөө муу тариа, хэдэн ногоочид чинь манжингаа хураагаад урамшуулалтай гэж байсан чинь байхгүй болчихсон гээд. Төрийн бодлого ингэж явмаар байна. Тэгэхээр надад шийдвэрийг нь өгмөөр байна.

Зөгийн дээр ямар хэмжээний юм тавигдсан юм бэ төсөв яг энэ 26 оны төсөв дээр? Энийг хариулаад өгчих. Тэгээд тэр юуны Байгаль орчны яам газрын дарга нөгөө Мөнгөнморьтын самар дээр тодорхой хариулт нэмээд өгчхөөч. Энэ нэгэнтээ ургачихсан тэгээд дээрээс нь энэ чинь улс, тухайн сум, орон нутгийн гол амьжиргааны эх үүсвэр байхгүй юу даа. Тэгвэл яах вэ дээ тэр хоцорсон юм бол тэнд нь хариуцлагыг нь яриад тэгээд цаана нь хамгийн гол нь ард иргэдийн орлого олох асуудал байгаа байхгүй юу. Тэгэхээр журамдаа өөрчлөлт оруулдаг юм уу? Энийг шийдчихэж болохгүй юм уу? Энэ ямар бүүр хуульд өөрчлөлт оруулах асуудал байгаа биш тийм ээ энэ дээр хариулт авъя.

Б.Бейсен: 5 номер хариулъя.

Т.Жамбалцэрэн: Тэр урамшуулал олгохтой холбоотой сайдын гаргасан шийдвэрийг танд бас хүргүүлъя. Урамшуулал олгох журам дээр бас журмын тодорхой зүйл, заалтууд байгаад байгаа юм. Тэгэхээр тэр холбогдох журмын заалтыг нь гаргасан тушаал шийдвэртэй нь хүргүүлъя.

26 оны төсөв дээр тухайлсан зөгий гэдэг агуулгаар тусгагдаагүй. Шинэ хөдөө хоршооны хүрээнд, Атрын 4 дүгээр аяны хүрээнд, Хүнсний хувьсгалын хүрээнд эдгээр зээлийн хөтөлбөрүүдэд хувийн хэвшлүүдэд бүрэн хамрагдаад явах бололцоо нь байгаа.

Б.Бейсен: 6 номер газрын дарга.

Т.Балжинням: Гишүүний хариултад хариулъя. 7 сарын 20-ноос 8 сарын 10-ны дотор бол тухайн орон нутгийн ойн анги нь нөөцөө тогтоодог байгаа. Тэгэхээр журам дээрээ яасан бэ гэхээр ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалттай самарт өгөх нөөцийг тухайн хугацаанд бол ойн анги буюу нөөцөө тогтоогоод боломжит хувилбар буюу дээд хязгаар нь манай түүхэд ийм боломжтой байна гэдгээ нэгтгүүлээд Ойн газарт эргүүлдэг байгаа юм.

Тэгэхээр энэ журам дээр яаж байна нөгөө ахуйн зориулалттай буюу үйлдвэрлэлийн зориулалттай болохоор тухайн холбогдох Зөвшөөрлийн тухай хуулиараа явагддаг учраас тэгээд хугацаанаасаа өмнө ирээд нягтлагдаад нийт улсын хэмжээнд гарах дээд хязгаар тогтоох нь яг хугацаагаараа байдаг учраас хугацаанаасаа хоцорч ирсэн. Тухайн аймгийн Засаг дарга бол бас холбогдож мэдээллүүдийг нь бас хүргүүлсэн байгаа юм. Шийдэх боломжгүй байгаа юм.

Б.Бейсен: Батбаатар сайд гүйцээж яриулья.

Б.Батбаатар: Манай яамны салбарын хамт олон ямар зүйл хэлсэн бэ гэхлээр ингээд жил болгон цувраад ээлжлээд ингээд өөр өөр байдлаар асуудлууд яваад байдаг. Энэ нь өөрөө байгаль орчныг хамгаалах, хяналт зохион байгуулахад хүндрэлтэй асуудал үүсэж байна гэдэг зүйлийг урьд нь 7 сард ярьсан, 8 сард, 7 сард, 7 сарын сүүлд, 8 сарын эхээр хугацаандаа багтааж мэдээ, тайлангаа ирүүлэхгүй энэ чинь алга болно шүү гэдгийг ер нь бүх аймаг руу сануулсан. Бүх аймгийн Засаг даргад самар ургадаг. Тэгээд харамсалтай нь тэрийгээ ирүүлээгүй. Тэгээд би яамны хүмүүстэй Ойн газар болон яамны байгалийн нөөцийн газрынханд үнэхээр наад газар чинь самар нь байгаа юм бол би журам гаргадаг юм бол тэр журмаа өөрчилж болно сайдын журмыг тэгэхээр та нар асуудлаа, шийдлээ оруулж ир ээ л гээд орхичихсон.

Б.Бейсен: Батчимэг гишүүн асуулт асууя.

П.Батчимэг: Өнөөдрийн Эдийн засгийн байнгын хороогоор 26 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 27-28 оны төсвийн төсөл тэгээд энэ төсвийн хоёр дахь танилцуулга энэ их чухал цаг үе л дээ. Тэгээд сайдууд маань Батбаатар сайдыг эс тооцвол бусад сайдууд маань энэ танхимд алга байна. Ноднин төсөв хэлэлцэж байхад 14 мега төсөл тэр том том төсөл, хөтөлбөрүүд, төслүүд, төмөр зам, уул уурхай ярьж байхад энэ танхим дүүрэн багтахгүй бүгдээрээ сууж байсныг санаж байгаа байх.

Тэгвэл энэ жил Ерөнхий сайд нь хүний хөгжил, энэ эрүүл мэнд, боловсрол, энэ хүний хөгжил мега төсөл өө гээд мега төсөл гээд ярьчихсан энэ тунхаглачихсан энэ төсөл, төсөв хэлэлцэж байхад яагаад энэ олон сайдууд өнөөдөр ирж танилцуулгаа хийхгүй байгаа юм бэ гэдэг дээр асуулга тавьж байна. Энэ танхимд ирсэн төрийн албан хаагчдыг хүндэтгэж байна. Үргэлж хуралдаа ирдэг, танилцуулгаа хийдэг, ярьдаг, асуултад хариулдаг та бүхэнд хүндэтгэлтэй хандаж байна. Ирээгүй сайдуудад харамсаж байна. Энэ жил яахаараа боловсрол, эрүүл мэндийн салбар яриад, мега төсөл яриад ирэхээр энэ 26 оны төсвийг үл тоосон байдалтай сайдууд ирж танилцуулгаа хийхгүй байгаа нь үнэхээр харамсал төрүүлж байна шүү. Хүнс, хөдөө аж ахуйн яам бол Монгол Улсын үндсэн том ч чиглэлийн яам. Бид өнөөдөр мал аж ахуй, газар тариалан, ургамал, газар тариалан ярихгүйгээр энэ яам оршин тогтнохгүй. Өнөөдөр өвөлжилтийн бэлтгэл ажил, мөн энэ ургац хураалтын ид ажил өрнөөд дуусчихлаа. Болсон, болоогүй энэ хувийн аж ахуйн нэгж, энэ аж ахуйн нэгж хувийн тариаланчдын нуруун дээрх ачаа дээр явж энэ ажил дууслаа гэж харж байгаа.

Тэгтэл өнөөдөр Эдийн засгийн байнгын хороогоор дээр хэлэлцүүлэг, сонсголд мэдээлэл өгнө өө гэххээд одоогоор өнөөдөр энэ мэдээлэл бидэнд ирээгүй. Энэ мэдээллийг хэзээ өгөх вэ гишүүдэд? Ер нь Хүнс, хөдөө аж ахуйн яам

2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

хүнсээ хаячихсан, хүнээ хаячхаж байгаа хөнгөн үйлдвэрлэлийн салбарыг орхигдуулаад байгаа ийм л салбар харагдаад байгаа. Шинэ хоршоо, тэр Атрын-4, тэгээд л Хүнсний хувьсгал энэ том том төслүүд нь, хөтөлбөрүүд нь яваад л байгаа. Энэ гарсан зээл Шинэ хоршоо дээр гарч байгаа 500, 500 тэрбумаар хаяад байгаа энэ зээлүүд эргэн төлөлт, тэдний үр өгөөж малчдад яг очиж байгаа зөв оносон зээл мөн үү энэ дээр зээлийн гарсан тэр шатлал юмыг танилцуулж хэлж өгөөч. Өнөө.../минут дуусав./

Б.Бейсен: Батчимэг гишүүн 1 минут.

П.Батчимэг: Байгаль орчны сайдаас Батбаатар сайдаас асуулт байна. Та шинээр ажил аваад Засгийн газрын бүрэлдэхүүнд орж сайд болоод 100 хоногоо давчихсан. Тэгэхээр таны өнөөдөр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны сайдаар ажиллах ер нь анхнаасаа гараа ямар байв? Яг үйл ажиллагааны чинь чиглэл өнөөдөр та яг юун дээр фокуслаж ажил гэж байгаа вэ? Байгаль орчин, уур амьсгалтын өөрчлөлтийн яамыг анхнаасаа би өнгөрсөн жил ер нь нэршлээс нь эхлээд л үгүйсгэж байсан юм. Ер нь утаа ярихгүй, утаанаас зугтсан хог, байгаль орчин, хөрсний бохирдол энэ мэтийн юмнууд асуудлуудыг тулгамдсан энэ ард түмнийхээ амьдрах, эрүүл амьдрах энэ сэдвээ хаягдчихсан энэ яам одоо та ахиад та энэ сэдэв дээр босож ирэх үү? Таны үйл ажиллагааны фокус яг гол чиглэл юун дээр байгаа вэ гэдэг дээр та хариулт өгөөч. Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас энэ ургац хураалтын.../минут дуусав./

Б.Бейсен: Хүнс, хөдөө аж ахуйн яам хариулъя. Дараа нь Байгаль орчны яам. 5 номерын микрофон.

Т.Жамбалцэрэн: Батчимэг гишүүний асуултад хариулъя. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Энхбаяр сайд тариалангийн бүс нутаг, Сэлэнгэ, Орхон, Булган аймгуудад тариалалтын ажилтай орон нутагт ингээд ажлаар явж байгаа учраас өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанд оролцож чадаагүй.

Салбарт хэрэгжиж байгаа хөтөлбөрүүдийн үр дүнгүүд хөтөлбөр бүрээрээ гарч байгаа. Хүнсний хувьсгал буюу хүнсний хангамж, аюулгүй байдал, үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэхтэй холбоотой гол нэрийн 19 нэр төрлийн бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээг хангах ийм зорилготой. Тэгээд энэ хөтөлбөрт өнгөрсөн хугацаанд 1.2 их наяд төгрөгийн зээлийн санхүүжилт гарч 3100 орчим иргэн, аж ахуйн нэгжүүдийн зээлийн үр шимийг хүртэж ажиллаж байгаа. Өнөөдрийн байдлаар томоохон гэж тооцогдох 53 үйлдвэр шинээр ашиглалтад ороод ингээд явж байгаа. Хөтөлбөр хэрэгжээд 3 жил болж байна. Бүтээгдэхүүний бас өсөлтүүд тодорхой хувиар гарч байгаа. Энийг 19 нэр төрлийн бүтээгдэхүүнээр нь задлаад, мөн малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний үнэ цэнийг өсөн нэмэгдүүлэх зорилготой Цагаан алт хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж байгаа зээл авсан иргэн, аж ахуйн нэгжүүд зээлийн хөрөнгөөр хэчнээн ямар үйл ажиллагааны үр дүнгүүдэд хүрэхээр байгаа энэ мэдээллүүдийг бас танд бичгээр хүргүүлье. Одоо энэ хариултын явцад 5 минутад би тэр болгон бүгдийг нь бас хариулж чадахгүй. Манай газрын дарга нар, нэгжийн дарга нар байгаа учраас бүх мэдээллүүд нь байгаа. Тэгэхээр дараа гэхгүйгээр одоо Байнгын хорооны хурлын дараа ч юм уу танд эргээд энэ мэдээллүүдийг нь өгье.

Энэ жилийн тухайд ургац хураалтын дүн гараагүй. 8 сарын 15-ны байдлаар ургацын урьдчилсан баланс гарсан. Ургац хураалтын ажил өнөөдөр 70 гаруй

2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

хувьтай явж байна. Цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалаад гэдэг юм уу ажиллах хүн хүч, тээвэр ложистик дээр салбарын яамнаас зохион байгуулалтуудын ажлуудыг аваад ингээд ажиллаж байна. Өвлийн бэлтгэл ажлыг хангахтай холбоотой хэд хэдэн удаагийн УОК-оос ч хэд хэдэн удаагийн хурал, арга хэмжээг зохион байгуулсан.

Засгийн газраас өвөлжилтийн бэлтгэлийг хангахтай холбоотой тогтоол, шийдвэр гараад орон нутгуудад хүргэгдсэн. Хэрэгжилт, явцын талаар УОК-оос гарсан ажлын хэсэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас гарсан ажлын хэсгүүд газар дээр нь ажиллаж нөхцөл байдалтай танилцаж ажилласан. Бэлтгэл ажлын явцад, ургац хураалтын ажлын явцад гарч байгаа хүндрэл бэрхшээл, тулгамдаж байгаа асуудлуудыг аль болох шийдвэрлэх чиглэлээр ажиллаж байна. Сая бас Туваан гишүүний асуултад хариулсан тэр ган бүхий бүс нутгуудад газар тариалангийн салбар эрсдэл зөрчсөн иргэн, аж ахуйн нэгжүүдийн эрсдэлийн судалгаа, үнэлгээ хийх, эргээд тэр авсан зээл, эргэн төлөлтийг нь хойшлуулахтай холбоотой асуудлуудыг ургац хураалтын дараа нэгтгэн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж холбогдох шийдвэрүүдийг гаргуулна.

Өвөлжилтийн бэлтгэлтэй холбоотой асуудал дээр өвөлжилтийн нэгдсэн дүнг нэгтгэж авч Засгийн газрын хуралдаанаар танилцуулсны дараа Улсын Их Хурал, Байнгын хороо тодорхой мэдээллүүдийг хийнэ гэдгийг энэ дашрамд хэлье.

Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд зээлүүд хэвийн үргэлжлээд явж байгаа. Атрын-4 дүгээр аяны хүрээнд гол бидний хийх ёстой ажил нөгөө 200 мянган га газраа тариалангийн талбайд шилжүүлэх, атаршсан болон атар газруудаа эргэлтийн талбайд оруулах асуудлууд. Дээр нь энэ усалгаатай газар тариалан гэдэг тариаланг бид нар цаашдаа хөгжүүлж авч явахгүй бол энэ байгаль цаг уурын эрсдэл, гангийн асуудлаас болж ургац алдах, эргээд энэ үйлдвэрлэлийн тогтвортой үйл ажиллагаануудад доголдол гарах ийм эрсдэлүүд байна. Энэ 4 хөтөлбөр бол арилжааны банкны эх үүсвэртэй ингээд зээл олгогдоод яваад байгаа боловч нөгөө талдаа энэ салбарын бодит үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа, энэ салбарт ажиллаж байгаа аж ахуйн нэгж, энэ салбарт ажиллаж байгаа мэргэжилтнүүдийн ажиллах орчин, нөхцөл энэ салбарын хөрөнгө оруулалт үнэхээр дутагдалтай байгаа гэдгийг бас энд хэлье.

Б.Бейсен: Батбаатар сайд хариулъя.

Б.Батбаатар: Батчимэг гишүүний асуултад хариулъя. Батчимэг гишүүнийг би улс төржсөн асуулт гэдэг утгаар хэлж байгаа биш шүү. Улс төрийн шийдвэрээ яаж гаргасан бэ, юун дээрээ анхаарсан юм бэ гэж асууж байна гэж ойлгож хариулъя. Тэгэхээр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн салбар энэ салбарт мэдээж өмнө нь үргэлжилж байсан сайн зүйлүүдийг улам өргөн дэлгэр болгож хөгжүүлж явах ёстой. Тулгамдсан буюу өмнө нь үлдсэн муу үүдийг нь засаж, цэвэрлэж явах ёстой. Энэ хүрээндээ байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн салбар бодлогын төрийн захиргааны төв байгууллага болоод бусад бодлогын газрууд, агентлагууд, харьяа газрууд энд эрх чөлөөг нь олгох ёстой юм байна гэдэг ийм зүйлийг бодож байгаа юм.

Яагаад вэ гэхлээр 6 жилийн дотор 6 дахь сайдынхаа нүүрийг үзсэн юм байна лээ. Тодорхой хэмжээгээр энэ нь өөрөө нөгөө өмнөх сайдууд муу ажиллаж байсан, сайн ажиллаж байсан гэхээсээ илүү.../минут дуусав./

Б.Бейсен: Батбаатар гишүүн нэмж хариулъя.

Б.Батбаатар: Тэгээд сайн, муу ажиллаж байсан гэхээсээ илүү нөгөө ийм огцом өөрчлөлтүүд яваад байх нь. Дээрээс нь Байгаль орчны яам гэхэд нөгөө ингээд байр дамжиж нүүсэн нь 3 жилийн дотор 200 гаруй хүн солигдох жишээний, 120 хүнтэй, 111 хүнтэй л яам шүү дээ. Тэгэхээр энэ өөрөө бодлогын буюу нөгөө суурь бодлого тээгчид нь ажлын нөхцөл байдлаас энэ яамны бодлогыг барьж явах зүйлээс гарсан байна гэдэг ийм дүгнэлтүүд хийсэн.

Дээрээс нь эдийн засаг хүндрэх, илүү хялбар буюу илүү хурдан хугацаанд санхүү мөнгөтэй болох энэ асуудал Улсын Их Хурлын тогтоолоор хүртэл илэрсэн шүү дээ. Ерөнхийлөгч хориг тавьж байж бид нар зогсоож авч чадсан. Тэр нь юу вэ гэхлээр байгаль орчны салбарын бодлого их тийм энэ яамны үндсэн байгаль орчны хамгаалагч байгаль орчны салбарт ажилладаг ажилтан, албан хаагчдын, иргэдийн дуу хоолой чадахаа байснаа байсан байна гэдэг дээр анхаарсан нь.../минут дуусав./

Б.Бейсен: Батбаатар гишүүн, сайд гүйцээж хариулъя.

Б.Батбаатар: Тэгэхлээр ийм байдлаар ажиллаж энэ салбараа нэгдүгээрт боловсон хүчин, хүний нөөц, зорилго чиглэл харж байгаа харааныхаа хувьд нэг тал руугаа харсан, нэг зүгт харсан ийм бодлоготой яам байя, болъё гэдгийг яам болон агентлаг дундаа ярьсан. Орон нутагт явж байхдаа бас ярьсан. Монголчуудын хэлдэг уул дагаж ус, ус дагаж мод гэж. Тэгэхээр газар, ус, мод гэдэг энэ зүйлийг бид нар хөгжүүлэх ёстой. Ирэх жилийн СОР дээр ч гэсэн гол суурь үндэс нь болгох ёстой гэж үзэж байгаа. Хөрсний бохирдол, агаарын бохирдол гээд яригдаж байдаг. Сая өнгөрсөн хаврын чуулганаар Улсын Их Хурлын тогтоолоор Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны дарга нь Ерөнхий сайд байх ёстой гэдэг даалгасан тогтоол гаргачихсан. Энэ дагуу Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны дарга Ерөнхий сайд хийж байгаа. Ер нь Байгаль орчны сайд хохирогч нь юм байгаа юм шүү дээ. Эрчим хүч, зам тээвэр, хот бол энэ агаарын бохирдлыг үйлдвэрлэгч бид бол уг нь хохирогч юм байгаа юм. Цааш нь бид нар олон.../минут дуусав./

Б.Бейсен: Батчимэг гишүүн тодруулъя.

П.Батчимэг: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Батбаатар сайдаас асуусан миний гол асуулт ер нь та 100 хоног давчихлаа тэгэхээр бойжиж чадав уу, ер нь таны цаашдын үйл ажиллагааны таны чиглэл, барьж ажиллах таны ажлын чиглэл юу байх вэ гэсэн. Тодорхой хариулт авч чадсангүй. Ер нь өнгөрсөн 100 хоногийн хугацаанд та хүний нөөцдөө их анхаарсан юм байна гэж л ойлголоо. Мөн үү? Ер нь утааны асуудал энэ ирэх он ингээд утаа гарлаа, утаа тэгээд энэ утаагүй түлш тэгээд энэ нөгөө байрны дулаалга энэ тэр дээр таны яам ер нь анхаарч ажиллах уу?

Б.Бейсен: Батбаатар сайд хариулъя.

Б.Батбаатар: Утааны асуудал дээр мэдээж ажиллана. Гэхдээ Үндэсний хорооны даргыг Ерөнхий сайдаар томил гэдэг тогтоолыг Их Хурал 5 сард гаргасан. Жаргалан гишүүн шаардах хуудас явуулсан. Засгийн газрын хурлаар ороод

2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Үндэсний хороо Ерөнхий сайдын эрх мэдлийн хүрээнд даргалдаг болсон. Ерөнхий сайдтай ямар байдлаар ажил булаацалдах нь эрх мэдлийн хувьд, үйл ажиллагаа явуулахын хувьд утаатай тэмцэлгүй яах вэ. Карбон кредитийн хэлэлцээр 2 улстай хийж байгаа. Сингапуртай 10 сарын 6-ны өдөр өдөр 2 цагт бид нар карбон кредитийн хүлэмжийн хийн гарын үсэг зурахаар болсон. Швейцарын талтай 5 удаа хэлэлцээрээ хийгээд 11 сард COP-30 дээр Бразилд гарын үсэг зурахаар болсон. Үндэсний тодорхойлсон хувь нэмэр 3.0-ыг Засгийн газрын хурлаар оруулж батлуулсан. Тусгай хамгаалалттай газар нутгийн хилийн цэсийг шинэчлэх ажил 19, 20 оноос хойш.../минут дуусав./

Б.Бейсен: Батбаатар сайд гүйцээж хариулъя.

Б.Батбаатар: 2019, 2020 онд гарсан Их Хурлын тогтоол 6 жил шийдэгдээгүй байсныг сая Засгийн газар анх удаагаа алхам хийж хилийн цэсийг шинэчлэн баталсан. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Ойн тухай хуулийг яаман дээр хэлэлцээд Ойн тухай хууль бол өвс ногоо хурааж байгаа юм шиг газар тариалангийн хууль шиг болчихсон байсан. Тэр дээр өөрчлөлт оруулж дахиж шинэчлэн ажиллаж байгаа. Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль өргөн баригдсан ажиллаж байна. Сангийн яамтай хамтарсан ажлын хэсгийн ажлыг үргэлжлүүлж Тусгай сангийн буюу Байгаль орчны сангийн орлогыг байгаль орчинд нь эргэн зориулагддаг болохоор Төсвийн тухай хууль дагаж өргөн мэдүүлэх гэж байгаад сая Төсвийн тухай хуулиа дагуулахгүйгээр тусад нь өргөн барья гэдгээр ажиллаж байна. Монголын судалгааны төв олон улсад НҮБ-д нээлттэй ил тод байдлын тухай тайлан өгдөг. Японы тайланг хуу.../минут дуусав./

Б.Бейсен: Дараа нь бичгээр бас гүйцээж хариулт өгье. Одоо хариулчихна. Батбаатар сайд хариулъя.

Б.Батбаатар: Монголын ил тод байдлын тайлан НҮБ-д очих ёстой. Одонтуяа сайд байхдаа хүртэл ажлын хэсэг томилоод харж байсан юм байна лээ. Өөр улсын тайланг хуулж тавиад гадаад НҮБ-д аваачаад тавьчихсан. Тэрийг нь бусад улсууд харсан. Одонтуяа сайд тэр хүнээ солих гээд сольж чадаагүй. Нөгөөдөх нь тэр хэвээрээ явж байгаа, дүгнэлтүүд гарч байгаа. Тэгэхлээр ингээд явахгүй байгаа ажлууд хаана гацаж байна вэ гэхлээр хүмүүс дээр гацаж байгаа. Тийм би 2, 3 хүн сольсон. Туул голын сав газрын даргыг сольсон орон нутгаас, хөдөө зарим Тусгай хамгаалалттай газрын дарга нарт, үүрэг гүйцэтгэгч нарт мэдэгдэл өгсөн байгаа. Тухайн газар нутаг дээр ажил явж байх ёстой, яам, тамгын газар ажил явж байх ёстой, Улсын Их Хурал дотор ажил явж байх ёстой. Тодорхой хүнээс болоод гацаж байгаа зүйл тэр хүн нь өөрчлөгд.../минут дуусав./

Б.Бейсен: Идэрбат гишүүн асуулт асууя.

Ц.Идэрбат: Өдрийн мэнд хүргэе. Бас гишүүдтэй нэлээн асуудлууд давхцаж байгаа байна. Асууж тодруулъя гэсэн зүйлүүд байна. Нэгдүгээрт би энэ байгаль орчны салбарт бас энэ жил байгаль орчны салбарт энэ томоохон төсөл, хөтөлбөр янз янзын юм байхгүй. Ганц COP17 гэдэг ийм том л арга хэмжээ байгаа юм байна. Зөв байж чадвал бид нар орлого олж бас бололцоо нээлттэй байгаа юм байна. Гэхдээ сайд нь явж чадахгүй байгаа юм байна.

Тэгэхээр энийг тэр Засгийн газрынхаа түвшинд яриад бас бололцоогоо нээлгээд авах нь зөв байх. Миний асуух гээд байгаа зүйл бол өнөөдрийн энэ

2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

төсвийг ингээд харахаар зөвхөн СОР17-д оруулсан төсвүүд ингээд орсноос болоод танай салбарын хөл дүн бол нэмэгдчихсэн юм шиг боловчиг. Яг ингээд задаргааг нь үзэхээр бүх юмнууд чинь хасагдаад явчихна. Бүх юмнууд чинь хасагдаад. Тэгэхээр ер нь энэ байгаль орчны салбар энэ 2026 онд хэвийн ажиллах бололцоо байгаа юу? Хэвийн ажиллах бололцоо? Энийг сайд хариулах уу, Төрийн нарийн хариулах уу, хэн хариулах вэ? Энэ төсвийг нь харахаар надад туйлын хүнд л харагдаад байна даа. Дараагийн нэг зүйл энэ Одонтуяа сайд байх үед л яригдсан даа.

Хэрвээ, хэрвээ танай салбар дээр ингээд хөрөнгө мөнгө дутагдаж байгаа бол гадаадын маш их төслүүд ганцхан танай салбар дээр хэрэгждэг. Энэ ер нь яг Монголын байгаль орчны салбарт ер нь яг тийм ямар үр дүнтэй үйл ажиллагаа явуулдаг бэ? Одонтуяа сайдын үед хийсэн танилцуулгаар кофе тэгээд л хурал зөвлөгөөн цаас ийм л юм болоод л зардал нь дуусдаг. Тэр битгий хэл Монголын төрийн байгууллагад, яаманд тайлангаа тавихгүй хүртэл төсөл, хөтөлбөр хэрэгжээд байж байдаг. Тэр нь Монголд өр болдог, янз янзын л асуудал байгаа юм байна. Тэгэхээр энэ дээр ер нь та шинэ сайдын хувьд төсөв, хөрөнгө ийм дутагдалтай байгаа үед энэ гаднын олон төсөл хөтөлбөрүүдтэй ер нь яаж ойлголцож ажиллахаар байгаа вэ гэдэг хоёр дахь асуулт.

Гурав дахь асуулт би энэ төсөв дээрээс бас хараад байлаа. Өнгөрсөн хавар ер нь ган болох нь ээ ялангуяа энэ төвийн бүс нутгаар ган болох нь ээ гээд. Би тухайн үед бас Байнгын хороон дээр асууж байсан. Та хэд үүлэнд нөлөөлөх юмаа бэлдсэн үү л гэсэн бэлдсэн л гээд байсан. Тэгээд өнөөдөр бэлдээгүйгээс болоод ургацаа алдчихсан л юм байна гэж би сая ойлголоо л доо. Туваан гишүүний асуултаас. Тэгэхээр ирэх жил энэ үүлэнд нөлөөлөх энэ тэнгэр, цаг агаар бид нар ямар болохыг хэлж таашгүй. Дахиад ийм байдал үүсвэл яах юм бэ? Тэгэхээр энэ дээр чинь 1 ч төгрөг байхгүй. Тэр сумын Орон нутгийн хөгжлийн сан дээр тавьж байгаа л гэж байна. Тэр сумын Орон нутгийн төсөв тэр хэдийнхэн пуужин авах вэ дээ, авахгүй шүү дээ, бараг тавихгүй гэсэн үг.

Тэгэхээр ер нь салбарын яам энэ дээр ер нь нэлээн бодлогоо зангидаж аймгийн Засаг дарга нартай гэрээ юмаа хийж, эсвэл төсөв дээрээ ийм юм оруулж ирэхгүй бол бид нар дахиад ган гачиг, дахиад л байгаль орчин, хөдөө аж ахуйн салбар чинь нэрвэгдвэл туйлын хүнд байдалд орно оо л гэж ийм 3 асуулт асууя.

Б.Бейсен: Байгаль орчны сайд хариулъя. Дараа нь Хүнс, хөдөө аж ахуйн сайд, Төрийн нарийн. Батбаатар гишүүний сайдын микрофон өгөөрэй.

Б.Батбаатар: Яам хэвийн ажиллах боломжтой юу, үгүй юү гэдэг дээр Төрийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч Батбаяр хариулчхаарай. Бас салбар уу? Тэгвэл би хариулчих уу? Тийм би өөрөө хариулчихъя. Төрийн нарийн юм уу сайд нь хэн нь хариулах вэ гэсэн болохоор тийш нь өгсөн юм. Яг үнэндээ энэ төсөв, мөнгөөр ер нь Монголын төсөв чинь өөрөө тэр чигээрээ хэцүү л байгаа шүү дээ. Ганцхан манай салбар гэлтгүй. Тэгэхдээ бүх төсөв хорогдсон. Зөвхөн СОР-ын дүнгээр нэмэгдсэн харагдаж байгаа гэдэг үнэн. 47.9 тэрбум төгрөгөөр төсөв хорогдсон 25 оныхоос. Өмнөх онтойгоо яривал өшөө бүүр хасагдсан.

Тийм болохоор хэвийн ажиллах гэдэг бол нэлээн ур чадвар шаардахаас өөр аргагүй нөхцөл, байдалд орох байх. Ур чадвар шаардана гэдэгт нь хууль, эрх зүй зөрчлөнөө өө гэсэн санаа байж болохгүй ээ гэдгийг бас давхар хэлмээр байна.

2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Хэцүү, хэвийн ажиллах боломжтой 100 хувь гэж хэлэхэд их хэцүү. Олон төсөл, хөтөлбөрүүд байгаль орчны салбарт хэрэгждэг гэж байгаа. Энэ олон төсөл, хөтөлбөрүүд хэрэгжээд, ямар зорилгоор, ямар чиглэлээр хэрэгжсэн юм бэ? Яг ямар зорилгын улмаас энэ төсөл, хөтөлбөр Монгол Улсад хэрэгжсэн юм тэр нь үр дүнд хүрсэн юм уу, хүрээгүй юм уу гэдэг дээр нь одоо дүн шинжилгээ, судалгаанууд хийж эхэлж байна. Харамсалтай нь олон төсөл, хөтөлбөрийн мэдээ, мэдээлэл бүрэн гүйцэт гарч ирж бас чадахгүй байгаа. Ямар нэг байдлаар удаадаг, ямар нэг байдлаар хэн нэг хүнээс болоод гацдаг, мэдээлэл нь ирдэггүй асуудлууд үүсэх хандлагууд гарч байгаа. Бас тодорхой ажлын буюу нөхцөл байдлын шаардлагуудаас болоод бас тийм зүйлүүд болж байна.

Жишээлэхэд, Тусгай хамгаалалттай газар нутгийн газрын олголт, архив гэхэд яаман дээр байдаггүй. Яаманд нэгтгэгдсэн архив байхгүй. Тэрийг яаманд бүх энэ Богд хаан гэнэ үү, Горхи Тэрэлж гэнэ үү бид нарын яриад л байдаг архив нь яаман дээр байдаггүй ийм нөхцөл байдалтай явж байдаг. Эд нарыг нь яаман дээр нэгтгэе гэдэг ийм чиглэлүүд өгөөд ажиллаж байна. Олон төсөл, хөтөлбөрүүдийн үр дүнг тооцож, үнэлж, энэ ондоо багтааж гаргаж яг аль төсөл хөтөл, хөтөлбөр нь зөв юм, явах ёстой юм, яг аль төсөл, хөтөлбөр нь маш сайхан нэртэй Монголд үр дүнгүй байгаа юм тэрнээс нь татгалзах ёстой юм уу, үгүй юм уу ёстой гэдэг дүгнэлт гаргах ёстой. Тэгэхдээ энд бас нэг хэсэг хугацаа зарах нь. Саяын богино хугацаанд харахан амжаагүй байна.

Гангийн эрсдэл үүлэнд нөлөөлөх, хур тунадаст нөлөөлөх тухай гэж байна тээ? Энэ дээр санал нэг байна. Та бүхэн төсөв хэлэлцэж байх явцдаа бас энэ асуудлыг Их Хурлын гишүүний бүрэн эрх байж байгаа ажиллаж болох байх гэж бодож байна.

Б.Бейсен: Идэрбат гишүүн тодруулъя. Дараа нь, Идэрбат гишүүний микрофон өгье.

Ц.Идэрбат: 2 том салбар хугацаа богино учраас шууд л ярьж хөдөө аж ахуйн салбараас би бас нэлээдгүй мэдээллүүдээ авлаа. Тэгээд би эндээс яг энэ орон нутагт ингээд явж байхад хөдөө аж ахуйн үйлдвэр эрхлэгчдийн яриад байгаа нэг зүйлийг хэлэх гээд байгаа юм. Янз янзын техник, тоног төхөөрөмжүүд худалдаж авахад 50 хувийг нь эргүүлээд буцаагаад өгдөг өө гээд. Хөнгөлөлтүүд байгаа шүү дээ тийм ээ. Гэтэл тэр заавал ингээд нөгөө Монголд байгаа компаниас авах ёстой болж байна.

Гэтэл эндээс авч байгаа үнэ, урдаас очоод авч байгаа үнэ хоёрын хооронд бараг ингээд даблдаж байна. Эндээс авах үнээрээ 1 трактор биш урдаас тракторыг ард нь чирэх төхөөрөмжүүдтэй нь авчих хэмжээний ийм зүйл яваад байна гэдэг зүйлийг энэ газар тариалангийн бизнес эрхэлж байгаа хүмүүс хэлээд байна л даа. Тэгээд заавал ингэж байх ёстой юу? Нэгэнт ингээд хөнгөлөлт үзүүлж байгаа бол, хөнгөлөлттэй зээл олгож байгаа бол өөрөө ингээд очиж аваад өөрийнхөө шаардлагад хангасан, чанар юмаа хангасан ийм юм авах бололцоотой юу гэж асуугаад байх юм. Энэ дээр хэн хариулах вэ?

Б.Бейсен: Хөдөө аж ахуйн Төрийн нарийн хариулъя. 5 номер. Хэн хариулах вэ? Салбарын мэргэжилтнүүд бас энэ сайд, Төрийн нарийнууд сайн мэдэхгүй байна лээ. Мэргэжилтнүүд хариулаарай. Болорчулуун дарга уу тэр?

2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Ц.Болорчулуун: Идэрбат. Гишүүний асуултад хариулъя. Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун. Тэгэхээр Хүнсний 36 дугаар тогтоол Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан энэ хөтөлбөрийн хүрээнд бид нар 3 жил энэ газар тариалангийн үйлдвэрлэлийн, төмс, хүнсний ногооны зориулалттай техник, тоног төхөөрөмж, бордоон дээр 50 хувийн хөнгөлөлтийг үзүүлж ирсэн.

Ингэхдээ бол Тариалангийн тухай хуулиараа энэ техник зарж борлуулдаг аж ахуйн нэгжүүд нь өөрснөө засвар, үйлчилгээний төвтэй, гарал үүсэл нь тодорхой ийм нөхцөлийг хангасан байж байж дотоодод техник зарж борлуулна гэсэн нь энэ үнэ, хуулийнхаа хүрээнд энэ дилер компаниудаар дамжуулж техникийг оруулж ирсэн. Мэдээж өөрсдөө арай үнэ хямдыг нь сонгох юм бол орж ирээд хагас жил явах юм уу, 1 жилийн дараа энэ техник, засвар үйлчилгээний төвгүй учраас хэнээс худалдаж авсан, иргэд тухайн иргэнээс худалдаж авсан техникүүд ингээд алга болох ийм магадлалтай учраас ийм шалгуур үзүүлэлтийг тодорхой хэмжээнд тавьсан.../минут дуусав./

Б.Бейсен: 4 номергүй цээж хариулъя.

Ц.Болорчулуун: Техникийн хөнгөлөлт нь энэ жилээр ингээд дуусгавар болж байгаа. Бордоон дээр бол энэ жилийн тухайд төсөв дээр тодорхой хэмжээний төсөв байгаа. Ингээд 1 жил дахиад урагшлахаар байгаа. Тийм энэ жилээр дууссан байгаа.

Б.Бейсен: Ганбаатар гишүүн асуулт асууя.

Г.Ганбаатар: Бейсен дарга санал байна. Ер нь энэ салбарынхаа төсвийг хэлэлцэж байгаа үед сайд нар нь байхгүй. Энэ хурлаа битгий хийж бай. Өөрийнхөө ирэх оныхоо төсвийг хэлэлцэж байх үед салбарын сайд нь тэр хаа байх нь хамаа байхгүй энэ хуралдаа ирж байх ёстой. Сая яах вэ Байгаль орчны сайд би та надаас асуулт байхгүй бол би ингээд дараагийн ажилдаа явъя гэж байна. Ер нь салбарынхаа энэ асуудал дээр цаашдаа иймэрхүү зүйлийг Байнгын хороо баримталж яахгүй энэ чинь бүр утгыг нь алдлаа. Одоо ингээд хар л даа асуусан болчихоод, хариулсан болчихоод 4, 5-хан хүн сууж байна шүү дээ.

Нөгөө талаасаа энэ Ардын намын даргын сонгуультай холбоотой энэ төрийн ажил үндсэндээ гацлаа. Байнгын хорооныхоо хурлуудыг хар, Улсын Их Хурлынхаа ирцийг хар, дээрээс нь энэ төр удирдаж байгаа энэ байгаа байдлаа харцгаа та нар. Тэгээд 2, 3 асуулт байна. Тэр шинэ хоршоо хөдөлгөөн дээр 133.9 тэрбум төгрөг тавьсан юм байна. Одоо энэ луйвраа зогсоох болоогүй юу Хөдөө аж ахуйн яам аа. Та нар өөрсдөө мэдэж байгаа шүү дээ. Өнгөрсөн жил сонгуулийн өмнө Шинэ хоршоо гэдэг үлгэр зохиогоод шинэ луйвраа зогсоогоод ажиллах хүчний дөрөвний нэг нь хөдөө аж ахуйн салбарт ажилладаг ажилладаг юм.

Түүний хөдөө аж ахуйн ялангуяа малчдын саналыг авах гэж луйвар гаргасан шүү дээ 5 их наядын хөтөлбөр гээд. Одоо энэ чинь 1 их наяд хүрлээ. 24 оны төсөв дээр 518 тэрбум гэж байсан. Өнгөрсөн оныхыг нийлээд 844 тэрбум болсон. Одоо ахиад 133.9 тэрбум. Ингээд нийлбэрээрээ их наяд хүрлээ. Энийгээ зогсоох болоогүй юм уу? Нөгөө талдаа яг үндсэндээ энэ чинь хоршооллын зарчмыг алдагдуулсан. Би бас хоршооллын салбарыг 20-иод жил ажилласан хүнийг мэдэх юм. 7 ардчилсан зарчим байдаг юм олон улсын зарчим нь. Түүний 4, 5 дээр нь тэр хоршооны биеэ даасан байдал гишүүдийн эдийн засгийн оролцоо гэдэг юмыг нь

2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

байхгүй болгосон шүү дээ. Энд ЖДҮ-ийн газрын дарга байна уу? Та хоршооллын салбарыг бас жоохон гадарлах ёстой. Байхгүй байгаа юм уу тээ? Үндсэндээ энэ чинь зарчмаараа явж байсан юмыг устгасан шүү та нар. Үүний зээлийн хүүд хэдийг төлсөн? Надад дараах асуултуудад хариулж өгөөрэй.

Нэгдүгээрт нь зээлийн хүүгийн хөнгөлөлтөд хэдэн тэрбум болоод байна вэ?

Хоёрдугаарт нь Шинэ хоршоо хөтөлбөрийн хүрээнд шатахууны зардал өчнөөн олон төрийн албан хаагчдыг та нар томилолт гээд явсан. Улаанбаатар хотод байсан 200, 400, 570 бүх машин түрээсэнд яваад дууссан. Өдрийн 200 мянгаар. Үүний томилолтын зардалд хэд болсон юм? Мөн энэ банкны шатахууны зардал миний ойлгосноор 5 тэрбум төгрөг, шатахууны зардалд нь зарцуулсан гэсэн сонгуулийн өмнө. Бүх 570, 470-ыг өдрийн 200 мянгаар түрээсэнд явуулсан гэсэн энэ мэдээллүүдийг надад өгчих. Одоо наад юмнуудаа та нар боль оо.

Хоёрдугаарт нь, улсын төсвөөс. Хоёрдугаарт нь. Энэ юу юм бэ? Цөцгийн тос үйлдвэрлэх сүүний ферм Булганд 3.6 тэрбум. Улсын төсвөөр цөцгийн тос үйлдвэрлэх ферм байгуулж яах гээд байна та нар? Ахиад хөдөө аж ахуйн кластер.../минут дуусав./

Б.Бейсен: Ганбаатар гишүүнд 1 минут.

Г.Ганбаатар: Хөдөө аж ахуйн кластер төслийн газар тариалан, малын тэжээлийн төсөл Баянхонгор, ахиад хөдөө аж ахуйн аж үйлдвэрлэлийн агро парк 4.9 тэрбум. Хувийн хэвслүүд хийж болох юмыг яагаад улсын төсвөөр хийж байгаа юм? Ялангуяа тэр тэр цөцгийн тос үйлдвэрлэх сүүний фермийг яахлаараа улсын төсвөөр хийж байгаа юм та нар? Ийм юм оруулж ирэхээсээ ичдэггүй юм уу салбар нь? Эдгээр асуултад эхлээд би хариултаа аваадахъя. Хэн нь хариулах юм? Төрийн нарийн хариулах юм уу, хэн нь хариулах юм?

Б.Бейсен: 5 номерт Төрийн нарийн хариулъя.

Т.Жамбалцэрэн: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Шинэ хоршоо хөдөлгөөнийг өрнүүлэхтэй холбоотой Улсын Их Хурлын тогтоол гарсан. Улсын Их Хурлын тогтоолоор хэрэгжүүлэх үйл ажиллагаа энэ үндсэн хөтөлбөрийг баталсан. Тэгээд энэхүү арга хэмжээг хэрэгжүүлж л салбарын яам ажиллаж байгаа. Өнгөрсөн хугацаанд нийтдээ 844.5 тэрбум төгрөгийн зээлийг 24938 зээлдэгчдэд олгосон. Энэ зээлд өнгөрсөн 24, 25 онд нийтдээ 115.8 тэрбум төгрөгийн хүүгийн хөнгөлөлтийг өгсөн. 115.8 тэрбум төгрөгийн хүүгийн хөнгөлөлт өгсөн. 26 оны төсөв дээр 500 тэрбум төгрөгийн арилжааны банкны эх үүсвэртэй зээлийг гаргана гэж ингэж тооцож байгаа. Тэгээд үүнтэй нийлээд хүүгийн хөнгөлөлттэй 109 тэрбум төгрөгийн хүүгийн хөнгөлөлт ирэх оны төсөв дээр ингээд суугдаад явж байгаа.

Энэ Шинэ хоршоо хөдөлгөөнийг хэрэгжүүлэхтэй холбоотой хүүгийн хөнгөлөлт нь л зөвхөн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багц суугдаж байгаа. Бусад энэ хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой 1 ч төгрөгийн зардал Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багцад, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх хүрээний байгууллагуудад тусгагдаагүй ээ гэдгийг хэлье.

2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Тэр хөрөнгө оруулалттай холбоотой ажлууд, энэ шинэ ажлууд бол байхгүй. Дандаа он дамжиж явж байгаа ажил. Тэр цөцгийн тосны үйлдвэрлэхтэй холбоотой энэ ажил 2022 онд эхэлсэн ийм төсөв. 26 онд дуусна. 26 онд санхүүжигдэх дүн нь 120 сая төгрөг байгаа. Ингээд 26 ондоо дуусахаар ийм ажлууд байгаа. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас шинээр огт ажлууд тусгаагүй. Шилжих эдгээр ажлууд байгаа. Эдгээр ажлууд нь салбарын яамнаас гэхээс илүүтэйгээр Их Хурлын гишүүдийн гэдэг юм уу, Шинэ хөдөө төслийн хүрээнд гэдэг юм уу ийм агуулгаар тухайн жилийн төсвүүд дээр суугдаж он дамжаад санхүүжигдээд ингээд явж байгаа. Хэрэгжилт гүйцэтгэлийн хяналтыг нь салбарын яам холбогдох орон нутгийн байгууллагууд нь тавиад явж байгаа. Дийлэнх нь ингээд 26 онд санхүүжигдэх дүнгүүдээрээ ингээд дуусахаар байгаа.

Б.Бейсен: Ганбаатар гишүүн тодруулъя.

Г.Ганбаатар: Миний асуусан асуултад тэр өнгөрсөн Шинэ хоршоо өнгөрсөн онд хөдөө төрийн албан хаагчдыг явуулсан зардал, шатахууны зардал эдгээр асуудлуудыг би бас нэмж асуусан байгаа. Энэ дээрээ нэмэлт тодруулга авъя.

Хоёрдугаарт нь энэ Шинэ хоршоо юу чинь та нар нэгэн цагт дуудагдана шүү. Их наяд нүүрсний сонсгол гэдэг шиг тэр улс төрийн шийдвэр нь гарсан байна уу, сонгуулийн үед гарсан байна уу энэ нэгэн цагт энэ үнэхээрийн луйвар. Та нар одоо бодоод үз дээ. Энэ эргэн төлөлт нь дөнгөж 58 хувьтай. Нийт 844 тэрбум төгрөг гарчихсан байна. Яг үнэндээ энэ чинь эзэндээ очсонгүй. Ардын намыг дэмжих үү гэж асууж байгаад 10, 20-оор нь айл болгоод өгчихсөн юм байна лээ шүү дээ. Тэгээд яг хоршоо байгуулаад авъя гэсэн хүмүүс нь өчнөөн хоршоо өнөөдөр болтол авч чадаагүй. Тэгээд 58 тэрбум гэдэг чинь ердөө 6-хан хувийн төлөлттэй нийт гарсан зээлийнхээ. Энийг хэвийн зүйл гэж үзэж байна уу өөрөө?

Б.Бейсен: Хариулаарай. Хэн хариулах вэ? 5 номер.

Т.Жамбалцэрэн: Ганбаатар гишүүн ээ энэ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багц дээр зөвхөн татаас, хүүгийн хөнгөлөлт нь л сайдын багц дээр сууж байгаа. Хэрэгжилт, зохион байгуулалт, гүйцэтгэлд нь манай яаман дээр хэрэгжихгүй байгаа. Шадар сайдын ажлын албан дээр энэ Шинэ хоршоо хөдөлгөөнийг хэрэгжүүлэхтэй холбоотой нэгж ингээд ажиллаад явж байгаа. Өнгөрсөн хугацаанд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас Шинэ хоршоо хөдөлгөөнийг хэрэгжүүлэхтэй холбоотой зардал тийм олон түрээснүүд манай салбар сайдын багцаас огт гараагүй ээ гэдгийг хэлье. Шинэ хоршоо зээлтэй холбоотой эргэн төлөлтүүд өнгөрсөн оны, энэ оны 5, 6 сараас эргэн төлөлтүүд төлөгдөж эхэлсэн. Энэ дээр арилжааны банк, зээлийн батлан даалтын сангууд хамтарсан ажлын хэсэг гараад орон нутгаар хяналт шалгалтын ажлууд хийгээд явж байгаа. Тэгээд энэ дүнгээр албан ёсны эргэн төлөлтийн дүнгүүд гарна. Саяын таны дурдсан.../минут дуусав./

Б.Бейсен: 2 номер хариулах юм байна. Шадар сайдын ажлын алба байна уу? Байгаа юу?

Б.Батбямба: Батбямба. Шадар сайдын ахлах зөвлөх Батбямба байна. Шинэ хоршооны энэ салбар дундын уялдаа холбоог хангах Үндэсний хороо өнгөрсөн 24 оны хорооны ажлын алба 24 оны 11 сард байгуулагдаад ажлын алба нь үндсэндээ 12 сараас жигдрээд ажиллаж байгаад өнгөрсөн 7 сарын, 25 оны 7

2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

сарын 30-ны өдрөөр тасалбар болгоод Монгол Улсын холбогдох Засгийн газар Улсын Их Хурлын холбогдох шийдвэрийн дагуу татан буугдсан Үндэсний хороо болоод ажлын алба нь. Энэ хугацаанд 10, 24 оны 11 сард ингээд байгуулагдсан учраас улсын төсөв батлагдсан хойно байгуулагдсан. Тийм учраас энэ хорооны ажлын албаны 15 хүний цалин, бусад үйл ажиллагааны зардлыг гүйцэтгэлээр нь Монгол Улсын Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргахаар шийдвэрлэсэн. 2.4 тэрбум төгрөг тусгай тогтоол гаргаж шийдвэрлэж өгсөн. Энэ тогтоолоос 900 орчим сая төгрөг л зарцуулсан байгаа энэ ажлын алба. Энэ ажлын алба ямар ажил хийсэн юм бэ гэхээр ерөнхийдөө.../минут дуусав./

Б.Бейсен: 2 номер гүйцээж хариулъя.

Б.Батбямба: Шинэ хоршоо, байгуулагдсан шинэ хоршоонууддаа бас эргээд хяналт тавих, мониторинг хийх, зарим арга зүйн зөвлөгөө өгөх, шинээр байгуулагдаж байгаа хоршоог бойжуулах чиглэлээр төслийн шаардлага хангуулах ч гэдэг юм уу ийм ажлуудыг тогтвортой хийж ирсэн. Энэний дагуу түрүүн Төрийн нарийн бичгийн даргын хэлсэнчлэн 99 мянга орчим иргэд хоршоонд нэгдэж нийтдээ 25, 11 мянган хоршоо байгуулагдсан байгаа. Энэ хугацаанд нийтдээ 844 төгрөгийн зээл олгогдсон байна. Графикаараа 5 жилийн хугацаанд төлөгдөх ёстой. Өнөөдрийн байдлаар эргэн төлөлт 106 хувьтай явж байгаа. Яах вэ төлөгдсөн зээлийн хугацаа нь эхний 1 жилдээ бас тодорхой хэмжээгээр зээлийн хөнгөлөлтөд хамрагдсан. Зарим татаас олгогдсон. Дээрээс нь эхний 1 жилдээ бас энэ хүүгийн төлбөр төлөхгүй ийм нөхцөлүүд байсан учраас харьцангуй бага төлөгдсөн. Үндсэн зээлийн төлбөр бол иймэрхүү байдалтай төлөгдөж ирсэн байна.

8 сарын 1-нээс эхлээд Монгол Улсын Засгийн газар дээр хэлэлцээд Шинэ хоршооны ажлын албаны хүмүүсийг Шадар сайдын харьяалалд шилжүүлчихсэн ажиллаж байгаа.../минут дуусав./

Б.Бейсен: Гишүүд асуулт асууж дуусаж байх шиг байна.

Би хэд хэдэн асуулт асууя Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас. Энэ жил ер нь зуншлага муу, мал тарга хүч авч чадсангүй тэгээд баруун аймгууд байж байна. Тэгээд тариалангийн бүс нутгуудаар ингээд хүнд байдалтай байна. Энэ жил энэ гурилын хангамж хэчнээн хувийг хангана гэж урьдчилсан тооцоо байна нэгдүгээрт?

Хоёрдугаарт энэ өвс, тэжээлээр хангах боломж бий юу? Сая үнэ нь нэмэгдчихсэн байгаа. Та нар сая аваад ирсэн өнөөдрийн байдлаар хивэг 40 мянга гарчихсан 1 шуудай нь пресс өвс 20 мянга гарчихсан байна. Тэгэхээр энийг хангах тал дээр бас баруун аймгуудынх нь ОХУ-тай бас гэрээ хэлэлцээр хийж байгаа юм байна. Бас наашаагаа бичиг явуулсан гэсэн Засгийн газрын хурлаар оруулаад бас хангах асуудал зүүн аймгаас татаж байна, үнэтэй очиж байна. Энийг өвөлжилтийн бэлтгэл ажлыг яаж хангая гэж бодож байна, ямар хэмжээний мэдээлэлтэй байна?

Нөгөө талаар Байгаль орчны яамнаас энэ зуншлага, өвөл өвс, тэжээл муу байдалтай холбоотой энэ ан амьтны байдал нэлээн хүнд. Том угалз, аргаль, янгир, буга энэ тэр ч голын эргээр буучихсан. 8 сард би Засгийн газарт бичиг хүргүүлсэн. Сум энэ аймгуудын хүсэлтийн дагуу. Ер нь анг нэмж буудуулаад засаг төсөвт, ер нь төсөвт орлого бүрдүүлэх талын асуудал дээр анхааръя гэдэг тийм

2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

хүсэлт ирсэн нь тэр бүгдийг Засгийн газарт явуулсан шийдэгдээгүй л байж байгаа. Тэгээд ан амьтны өвс, тэжээлийг яаж шийдье гэж бодож байна энэ?

Дараагийн асуудал энэ Байгаль орчны яамнаас, Сангийн яамнаас хог хаягдлын асуудал байгаа. Эмнэлгийн аюултай хог хаягдал, онц аюултай хог хаягдал асуудлууд байж байгаа. Жишээлбэл моторын тоос сольсон тосны асуудлаар бас юм яадаг юм байна. Тэгээд түрүүн бид нар энэ газар үйлдвэрүүдээр очоод танилцаад ирсэн. Гэтэл энэ дээр төсөв тавьдаг юм байна. Зүгээр цуглуулж байгаад төсвөөс тэрбумаар нь юу авдаг мөртөө боловсруулах үйлдвэртэй тийм ганц үйлдвэр байдаг юм байна л даа Налайхын тэр Городокийн тийшээ. Тэд нар юм авдаггүй. Тэгэхээр энд ямар хэмжээний төсөв хуваарилдаг юм, орон нутгийн төсөвт яадаг юм уу, Байгаль орчны яаманд хуваарилдаг юм уу энэ талаар мэдээлэл авъя.

Энэ цөлжилттэй тэмцэх талын асуудал дээр бас манайх сая 2 тэрбум төгрөгөөр уг нь Эгийн голын усан цахилгаан станцаас усны шинжилгээг чинь барихаас өмнө бүх химийн, хөрсийн бүх шинжилгээг хийсэн шүү дээ. Гэтэл тэрний оронд энэ Усны газар, Байгаль орчны яам, Онцгой комисс нийлж байгаад говь руу ус татах, цөлжилттэй тэмцэх асуудлаар энэ аль талаар усны урсац хаагуур урсах вэ, шуудуу татах юм уу, нуур, цөрөм байгуулах боломж байна. Энэний судалгааг хийх боломж байдаггүй юм уу? Ер нь хийчихвэл яадаг юм энэ ер нь? Зориг гаргаж хийчихэд ер нь газрын доорх усыг хүлээгээд тийм хэмжээний хангалт ч бүрдэхгүй байх ер нь. Цаашдаа энэ асуудал бусад дэлхийн бусад бүх орнууд тэгж байхад манайх бас тэрийгээ бодмоор юм. Тэрийг бас энэ талаар судалгаа хийж болохгүй юм уу?

Шадар сайдын Онцгой комиссын энэ шахмал түлшний хангамж хэр байна? Төсөвт тэр 224 тэрбум төгрөг яасан шүү дээ. Одоогийн байдлаар хангалт нь хэр байна, Хятадаас хэчнээн тонны, мянган тонн оруулж ирсэн. Тэр талаар мэдээлэл авъя.

Эхлээд хөдөө аж ахуйн яам. 5 номерын микрофон.

Т.Жамбалцэрэн: Байнгын хорооны даргын асуултад хариулъя. Ургац хураалтын ажил ид дундаа явж байна. Бид нарын ур урьдчилсан балансаар улаан буудайн тариалалт дотоодын хэрэгцээ 30 орчим хувиар дутах ийм нөхцөл байдал үүсэж байгаа. Тийм учраас импортын улаан буудайгаар дотоодын хэрэгцээт гурилыг хангана гэж ингэж тооцож байгаа. Гурил импортолж авахаасаа илүүтэйгээр улаан буудайн нөөцөө бүрдүүлж, дотоодын үйлдвэрлэлүүдээ тогтвортой түүхий эдээр хангаад эргээд баруун бүстэй хямд дотоодын стандартын шаардлага хангасан чанартай гурилыг нийлүүлнэ ээ гэж ингэж тооцож байгаа. Энэ хүрээндээ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдаар ахлуулсан ажлын хэсэг дотоодын гурил үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдтэй хэд хэдэн удаагийн уулзалтуудыг зохион байгуулсан. Энэ хүрээнд баруун бүсийн 5 аймгуудад дотоодын гурилын үйлдвэрүүд борлуулалтын цэг байгуулж, үйлдвэрийн үнээрээ гурилаа борлуулах ийм зохицуулалтын ажлыг авч байгаа.

Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангахтай холбоотой Засгийн газрын тогтоол гараад ингээд өвс, тэжээлийн шаардлагатай, аюулгүй нөөцийг бүрдүүлээд ажиллаж байгаа. Орон нутгийн түвшинд УОК-оос өгсөн, Шадар сайдаас өгсөн чиглэлийн дагуу, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдаас өгсөн чиглэлийн

2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

дагуу хэд хэдэн ажлын хэсэг орон нутгуудад ажилласан. Миний бие ч гэсэн энэ баруун бүсийн аймгуудад ажилласан. Тэгээд энэ үеэр бас энэ өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэлттэй холбоотой аймаг, орон нутгийн Онцгой комиссын авч байгаа арга хэмжээнүүд, мэдээллүүдийг бас сонссон. Энэ дээр бас бодлогын чиглэлд бодлогын зөвлөмжүүдийг өгч ажилласан байгаа. Ялангуяа малчдын түвшинд өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэлтийн ажил нэлээд бага хувьтай. Аймаг, орон нутгийн аюулгүй нөөц бүрдүүлэх ажил төсвийн хэмнэлттэй холбоотой, төсвийн тодотголтой холбоотой төсөв, мөнгө нь татагдсан гэдэг асуудлуудыг тавьж байсан.

Ялангуяа өнөөдрийн нөхцөл байдал дээр баруун бүсээр импортоор гэхээсээ илүүтэйгээр зүүн бүсээс байгалийн хадлан, төвийн бүсээс хивэг нэлээдгүй хэмжээгээр зөөгдөж байгаа. Гол дийлэнх өртөг шингэж байгаа асуудал нь энэ тээвэр дээрээ нэлээд өндөр 60, 70 хувь нь тээврийн хөлс нь нэмэгдэж байгаа ийм зохицуулалт байгаа. Тийм учраас баруун бүсийн хил залгаа аймгуудыг ОХУ-аас шаардлагатай өвс, тэжээлийнхээ нөөцийг бүрдүүлэх, ингэхдээ гол хүчит тэжээлийн нөөцийг бүрдүүлэх энэ чиглэлээр бас холбогдох зөвлөмж чиглэлүүдийг өгсөн.

Нөгөө талдаа энэ өвөлжилтийн нөхцөл байдал хүндрэхтэй холбоотой өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэхээс гадна мал, махаа эдийн засгийн эргэлтэд оруулах асуудлуудыг нэлээн шуурхайлах ёстой. Зун гангийн нөхцөл байдал өндөр байсан. Намаржилт тийм сайн биш. Өвөл онд орохгүй малаа эдийн засгийн эргэлтэд оруулах, малынхаа тоо хэмжээг өгөх зохицуулалтуудыг авч, тодорхой хэмжээний орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийг тогтвортой ажиллуулах, эргээд мал, махаа экспортлох боломжийг нь бүрдүүлэх чиглэлээр бас тухайн бүс нутгуудад ажилласан. Харьцангуй экспорт, махны экспорт эрчимтэй явагдаж байна. Баруун бүсийн малаа эдийн тэгээд эргэлтэд оруулах малчдын хандлага маш өндөр байгаа.

Тийм учраас бодлого зохицуулалтын хүрээнд аж ахуйн нэгжүүдэд хүндрэл, чирэгдэл учруулахгүй байх, бичиг баримтын түргэн шуурхай нэг цонхны бодлогоор шийдвэрлэх, нөгөө талдаа үйлдвэрүүдэд нь эргэлтийн хөрөнгийн зээл олгох асуудлуудыг салбар яаман дээр зохион байгуулж ажиллаж байгаа гэдгийг хэлье.

Б.Бейсен: Байгаль орчны яам 6 номер.

Ц.Уранчимэг: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Тусгай хамгаалалттай газрын бодлогын газрын дарга Уранчимэг байна. Ан амьтантай холбоотой Байгаль орчны яамнаас био техникийн арга хэмжээ ажиллах ажлыг сайдын тушаалаар ялангуяа тусгай хамгаалалттай газар нутгуудад тодорхой чиглэл хүргүүлсэн байгаа. Тэгэхээр баруун бүсүүдэд гангийн эрсдэл өндөртэй байгаа учраас зүүн бүсэд бас тодорхой хэмжээний нөөцийг бэлтгээд баруун бүсийн аймгууддаа ТХГН-ийнхаа сүлжээгээр дамжуулаад бас ан амьтны био техникийн арга хэмжээ авах үйл ажиллагааг зохион байгуулж байгаа.

Мөн агнуурын мэргэжлийн байгууллагын агнуурын бүс нутаг дээрээ мэргэжлийн байгууллагын эрхтэй компаниудтайгаа хамтраад энэ био техникийн арга хэмжээ авах чиглэлийг тухай бүрд нь яам хүргүүлж байгаа. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулиар орон нутагт ан амьтны орлогоос олсон орлогыг буцаагаад байгаль хамгаалах арга хэмжээнд зарцуулах зардлын ангиллаар бол бас био техникийн арга хэмжээ авхуулах ийм боломж байгаа.

Хоёр дахь асуулт хог хаягдалтай холбоотой асуудал дээр тайлбар өгье. Тэгэхээр Хог хаягдлын тухай хуулиараа аюултай хог хаягдлын.../минут дуусав./

Б.Бейсен: 6 номер гэж байж хариулъя.

Ц.Уранчимэг: Мэргэжлийн байгууллагын зөвлөл ажиллаж аюултай хог хаягдлын мэргэжлийн байгууллагын эрхийг олгодог. Тэгэхээр Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас улсын төсвөөс тодорхой хэмжээний аюултай хог хаягдлыг бууруулах зорилгоор бол ямар нэгэн улсын зардлаас мөнгө төлөвлөдөггүй. Тэгэхээр байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээрээ тухайн бүс нутагт аюултай хог хаягдал үүсэж байгаа бол орчны байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах урьдчилан сэргийлэх зорилгоор мөн хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулахад аюултай хог хаягдлын мэргэжлийн байгууллагын эрхтэй аж ахуйн нэгж, байгууллага тухайн бүс дээр байгаа аюултай хог хаягдлыг ялангуяа том үйлдвэрүүдээс үүсэж байгаа тос, тосон бүтээгдэхүүнийг шууд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулиараа гэрээ байгуулаад тэр мэргэжлийн байгууллагын эрхтэй компанид олгоод үнэ төлбөргүйгээр нийлүүлж тэр аюулгүй хог хаягдлыг мэргэжлийн байгууллага эрхтэй компани бол цуглуулж, тээвэрлэж, хадгалж, дахин ашиглах энэ зохицуулалтыг боловсруулах ажлыг хийдэг ийм зохицуулалттай байгаа.

Б.Бейсен: 2 номер.

Б.Батбямба: Бейсен гишүүний асуултад хариулъя. Нийслэлийн хэмжээнд энэ жилдээ ер нь 340-өөс 50 мянган тонн түлш хэрэглэнэ гэсэн ийм тооцоо гарсан байгаа. Түүнийхээ 40 мянган тонныг хуучин хэрэглэж байсан шахмал түлшээ хэрэглээд дуусгана. Тэгээд үлдсэн 306 орчим мянган тонн түлшийг БНХАУ-аас импортлох буюу хөх нүүрс буюу хагас кокс нүүрсийг авч хэрэглэнэ ээ гэсэн ийм тооцоо гаргасан байгаа.

Өнөөдрийн байдлаар нийслэлийн хэмжээнд 8.5 орчим мянган шахмал түлшийг 344 цэгээр өнгөрсөн долоо хоногоос борлуулаад эхэлчихсэн байгаа. Нийтдээ шахмал түлшний нөөц байгаа үйлдвэрийн энэ дамжлагаас гарч дуусаж байгаа нөөц нийтдээ 35-40 орчим мянган тонн ингээд гараад хэрэглээд дуусна дахиж үйлдвэрлэхгүйгээр. Шинээр хэрэглэж эхлэх гэж байгаа хөх нүүрсний тухайд эхний 2 ... ирээд үйлдвэрийн хашаанд зүүн үйлдвэрийн хашаанд буу.../минут дуусав./

Б.Бейсен: 2 номер гүйцээж хариулъя.

Б.Батбямба: Орчихсон явж байгаа. 1 состав дунджаар 2450 орчим тонн ийм хагас коксожсон хөх нүүрс орж ирж байгаа. Мэдээж лабораторийн шинжилгээнд хамруулж байгаа Монгол Улсад байгаа итгэмжилсэн лабораториудаар үзэхээр шахмал түлштэйгээ харьцуулахад гол үзүүлэлтүүд нь бүгд бага, тал хүртэл нь бага. Тухайлбал, хүхрийн хэмжээ, чийглэгийн хэмжээ, дэгдэмхий бодисын хэмжээ, үнсний хэмжээ гээд энд үзүүлэлтүүд нь бид нарын уламжлалт сүүлийн 2, 3 жил хэрэглэсэн шахмал түлшнээс харьцангуй бага гарч байгаа. Илчлэгийн хэмжээ жоохон илүү ийм байдалтай ингээд шинжилгээнд оруулаад түрүүчээсээ ингээд хэрэглээнд гарахаар бэлтгэл ажлыг хангаж байгаа. УОК дээр товчхондоо ийм мэдээлэл ирсэн байна.

2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Б.Бейсен: Ер нь тэр шахмал түлшний асуудал дээр ер нь үйлдвэрийн дотооддоо байгуулах тал дээр төсөв дээр тавиулсан уу Сангийн яам юу бодож байгаа бол? Одоо ер нь ийм хэмжээний нүүрсийг гаргачхаад гаднаас Хятадаас худалдаж авчхаад ичмээр л юм байгаа юм л даа. Энэ дотооддоо энэ үйлдвэрлэх тал дээр энэ төсөв, үйлдвэрийнх нь төсөв тавиулсан уу?

Хоёрдугаарт энэ Байгаль орчны яамныхан ийм асуудал байгаа юм байна. Энэ хаягдал тос боловсруулах 1 л үйлдвэр байдаг юм байна. Тэгээд үзэхэд бид нар очоод үзлээ. Байгаль орчны яам, манай Байнгын хорооныхон дахиж очоод үзэх гэж байгаа юм. Налайхын гордок дээр. 100 мянган тонн хаягдал тос байна шүү дээ моторыг нь сольсон. Тэрнээс 70 мянган тонн түлш, дизелийн түлш үйлдвэрлэдэг юм байна. 30 мянган тонн нөгөө юунд нь битум замын тийм ашигтай үйлдвэр байдаг юм байна. Тэр томсгоод тэгээд газрын үйлдвэрийг хаачхаад Төв аймгийн ямар сум билээ? Төв аймгийн нэг сум дээр Эрдэнэ сум билүү нэрийг нь мартчихлаа. Тэн дээр том үйлдвэр баригдаж байгаа юм байна. Ерөнхий сайд бас энийг дэмжиж байгаа юм байна ер нь.

Гэтэл тэд нар юм авч чаддаггүй. Тос цуглуулж, хаягдал тос цуглуулж байгаад газар булдагууд нь хэдэн тэрбумаар нь юу авдаг нөгөө. Тэгэхээр тийм үйлдвэрээ дэмжмээр юм. Та нар бас очоод үзсэн үү ер нь? Та нарыг бас үзүүлэх гээд байгаа. Бид нар, манай Байнгын хорооныхон үзэхгүй бол. Би чинь бид нар нефтийн үйлдвэр барьж чадахгүй та нарын түлш үйлдвэрлэл гэж юу байдаг юм гээд 1 удаа хөөгөөд явуулсан. Сүүлдээ үзэх гэхээр үзсэн. Үнэхээр тийм юм байна. Тэгэхээр чинь тийм үйлдвэрүүдээ бас дэмжмээр юм бид нар. Гэтэл тэр сая түлшний дотооддоо үйлдвэр барих тийм төсөв хийлгэсэн юм байна уу ер нь? Сангийн яамны талаар юу бодож байгаа энэ, Онцгой комисс? Байнга Хятадаас авч явах уу бид нар?

2 номерын микрофон. Түлшээ байнга Хятадаас авч байх уу бид нар яах вэ тэгээд?

Б.Батбямба: Энэ дээр холбогдох салбарын яамнууд нийслэлийн зүгээс бас тодорхой бодлогуудаа гаргаж танилцуулах байх. УОК дээр ирсэн. Яагаад гэхээр УОК-ын даргаар бас энэ нийслэлийн орчны бохирдолтой холбоотой асуудлаар шуурхай штаб байгуулаад ахлуулсан учраас эхний мэдээллүүдээ авчхаад бид нар холбогдох газруудтайгаа хамтраад ажиллаж байгаа. Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хороо бас ойрын үед хуралдаж энэ асуудлыг бас тодорхой бодлогын чиглэлүүдээ гаргах болов уу гэсэн ийм хүлээлттэй. Уул нь өнөөдөр товлосон байсан.

Б.Бейсен: Гишүүд асуулт асууж дууслаа.

Үг хэлэх гишүүд байна уу?

Үг хэлэх гишүүд байхгүй байна.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо эрхлэх асуудлын хүрээнд Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хоёр дахь хэлэлцүүлгийг хийж дууслаа.

2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Хэлэлцүүлэг хийсэн талаарх танилцуулгыг Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссанд тул хуралдааныг хаасныг мэдэгдье. Гишүүдэд, ажлын хэсэгт баярлалаа.

16.59 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.ОТГОНДЭЛГЭР